

Улсын бүртгэлийн  
дугаар:

Төсөл хэрэгжүүлэх гэрээний дугаар:  
ШуСс-2018/54

МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН  
ФИЛОСОФИЙН ХҮРЭЭЛЭН

**“ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ОЮУН САНААНЫ ҮНДЭС”**

сэдэвт суурь судалгааны төслийн тайлан

2018-2021 (эцсийн тайлан)

<b>Төслийн удирдагч:</b>	Б.Пүрэвсүрэн доктор (Ph.D) профессор, Философийн хүрээлэнгийн захирал
<b>Захиалагч:</b>	Боловсрол, шинжлэх ухааны яам
<b>Санхүүжүүлэгч байгууллага:</b>	Шинжлэх ухаан технологийн сан
<b>Тайлан өмчлөгч:</b>	ШУА-ийн Философийн хүрээлэн

## ГАРЧИГ

<b>РЕФЕРАТ</b> .....	<b>3</b>
Суурь судалгааны ажлыг гүйцэтгэгчдийн мэдээлэл.....	5
<b>НЭГ. ҮНДСЭН ХЭСЭГ</b> .....	<b>6</b>
1.1. Суурь судалгааны төслийн зорилго.....	6
1.2. Төсөл хэрэгжүүлэх үндэслэл, хэрэгцээ шаардлага.....	6
1.3. Суурь судалгааны төслийн нийгмийн болон шинжлэх ухааны ач холбогдол.....	7
1.4. Судлагдсан байдал.....	7
1.5. Суурь судалгааны төслийн үр дүнгээс гарсан зарим дэвшилтэт талууд.....	7
<b>ХОЁР. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ</b> .....	<b>8</b>
<b>ГУРАВ. СУУРЬ СУДАЛГААНЫ АЖЛЫН ДҮГНЭЛТ</b> .....	<b>9</b>
<b>ДӨРӨВ. СУУРЬ СУДАЛГААНЫ ТӨСЛИЙН ҮР ДҮНГИЙН ТОЙМ</b> .....	<b>11</b>
4.1. Нэг сэдэвт бүтээлүүд.....	11
4.2. Эрдэм шинжилгээний хурал, семинар.....	16
4.3. Эрдэм шинжилгээний илтгэлүүд.....	19
4.4. Эрдэм шинжилгээний өгүүллүүд.....	28
4.5. Ном товхимол.....	33
4.6. Бүтээлийн жагсаалт .....	40
<b>ХАВСРАЛТ</b> .....	<b>44</b>

## РЕФЕРАТ

ШУА-ийн Философийн хүрээлэнгийн Философийн салбараас 2018-2021 онд “Тогтвортой хөгжлийн оюун санааны үндэс” 2018/54 суурь судалгааны төслийг гүйцэтгэсэн болно.

Философийн хүрээлэн нь дунд хугацааны стратегийн төлөвлөгөөгөө “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Шинжлэх ухаан, технологийн тухай хууль, Шинжлэх ухаан технологийн талаар төрөөс баримтлах бодлого зэргийг үндэс болгон боловсруулсан билээ. Уг төлөвлөгөөнд хүрээлэнгийн үйл ажиллагааны үндсэн 4 чиглэлийг тодорхойлохдоо: 2-рт “Монголын нийгэм, хөгжил, оюун санааны хүрээний асуудлыг философи, улс төр судлал, эрх зүй, социологи, улс төрийн эдийн засаг, нийгмийн сэтгэл зүй, шашин судлалын үүднээс судалж шинжлэх ухааны үндэстэй дүгнэлт гаргаж, цаашдын чиглэл, арга замыг тодорхойлсон үндэслэл боловсруулах” хэмээсэн нь уг суурь судалгааны төслийг хэрэгжүүлэх үндэслэл болсон билээ.

Нэгдсэн Үндэстний байгууллага нь 2015 оны 9 дүгээр сард зохион байгуулагдсан 70 дугаар чуулга уулзалтаараа “Эх дэлхийгээ шинэчилье 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн зорилго (ТХЗ)”-ыг 193 гишүүн орныхоо хамтын шийдвэрээр баталсан байдаг. Монгол Улс тогтвортой хөгжилд хүрэх дэлхий нийтийн, урт хугацааны бодлогын баримт бичгийг дэмжин хэрэгжүүлэхээр УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоолоор батлан мөрдүүлж эхэлсэн.

Энэхүү суурь судалгаа нь тогтвортой хөгжлийн тухай дорно дахин хийгээд монголын уламжлалт сэтгэлгээний суурь үзэл баримтлалыг боловсруулах, үзэл суртлын асуудлаар орчин үед өрнө дахинд гарсан эрдэм шинжилгээний бүтээлүүдийг судалж ингэхдээ байгальтайгаа шүтэн барилдах, шинжлэх ухаан ба оюун сэтгэлгээний, ёс журам ба шударга ёсны, мухар сүсэг ба бодит мэдлэгийн, хүмүүнлэгийн болон соёл урлагийн үндэслэлүүдийг боловсруулж төрийн удирдлагад хүргэхэд чиглэсэн билээ.

Төслийг хэрэгжүүлэх хугацаанд дэлхий нийтэд тархаад буй COVID 19 цар тахал дэгдсэнээр 2020 оны санхүүжилт бүрэн ороогүйтэй зэрэгцэн зарим төлөвлөсөн ажил тодорхой хугацаанд хойшлогдсоноор уг төсөлт ажлын гүйцэтгэх хугацааг нэг жилээр сунгах шийдвэр гарсан билээ. Гэсэн хэдий ч төслийн багийнхан төлөвлөгөөт ажлуудаа бүрэн гүйцэтгэж төслийн үр дүнд нэгэн сэдэвт бүтээл-4, ном товхимол-4, эрдэм шинжилгээний өгүүлэл-9, эрдэм шинжилгээний илтгэл-24 бичиж хэвлэн нийтлүүлсэн

ба экспертийн түвшний судалгаа-1, эрдэм шинжилгээний хурал, хэлэлцүүлэг-3, хамтын бүтээлийн зохиогчдын багийн уулзалтуудыг тус тус зохион байгуулж ажиллалаа.

Суурь судалгааны төслийн үр дүнд хэвлэгдэн гарсан бүтээлүүдийг Монгол Улсын боловсрол, төрийн болон өөрөө удирдах ёсны бүх шатны байгууллага, соёл, урлаг, хэвлэл мэдээлэл, аж ахуй нэгж зэрэг монголын нийгмийн бүхий л хүрээнд, олон нийтийг соён гэгээрүүлэхэд чиглэсэн аливаа үйл ажиллагаанд ашиглах бүрэн боломжтой.

**ТҮЛХҮҮР ҮГС:** тогтвортой хөгжил, оюун санаа, оюуны урсгал, ёс суртахуун, соёл урлаг, экологи, гоо зүй, шашин шүтлэг, уламжлалт ёс заншил

## ТӨСЛИЙН ГҮЙЦЭТГЭГЧИД

Төслийн удирдагч: Б.Пүрэвсүрэн доктор (Ph.D), профессор

Гүйцэтгэгчид: Ч.Ган-Өлзий (ФХ, ЭШТА) доктор (Sc.D)  
Ш.Ганхуяг (ФХ, ЭШАА), доктор (Ph.D)  
С.Соёлмаа, (ФХ, ЭШАА) доктор (Ph.D)  
Ж. Энхбаяр (ФХ, ЭШАА) доктор (Ph.D)  
П.Мягмарсайхан (ФХ, ЭШДЭА) магистр  
Ж.Бямбасүрэн (ФХ, ЭШДЭА) магистр

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Баруун Сэлбийн  
гудамж-15, ШУА-ийн хүрээлэнгүүдийн нэгдсэн 2 дугаар байр,  
Философийн хүрээлэн

Утас: 976-11-330847

Э-шуудан: [b.puujee@gmail.com](mailto:b.puujee@gmail.com)

## **НЭГ. ҮНДСЭН ХЭСЭГ**

### **1.1. СУУРЬ СУДАЛГААНЫ ТӨСЛИЙН ЗОРИЛГО**

Тогтвортой хөгжлийн байгаль, нийгэм, эдийн засгийн талуудыг тэнцвэртэй шүтэн барилдуулах оюун санааны суурь хүчин зүйлүүдийг тогтооход чиглэсэн.

#### **Зорилт:**

- Хөгжлийн байгаль, нийгэм, эдийн засгийн талуудыг тэнцвэртэй шүтэн барилдуулах оюун санааны суурь хүчин зүйлүүдийг гаргах;
- Тогтвортой хөгжлийн оюун санааны үндсийн тухай нэг сэдэвт бүтээл гаргах;
- “Тогтвортой хөгжлийн оюун санааны үндэс” төслийг хэрэгжүүлэхэд философи, улс төр, шашин зан үйл, сэтгэл зүй, боловсрол, ёс зүй, эрх зүй, урлаг соёл, нийгэм хүмүүнлэгийн чиглэлүүдээр шинэлэг санаа дэвшүүлсэн өгүүллүүдийг бичиж нийтлүүлнэ.

### **1.2. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮНДЭСЛЭЛ, ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА**

- Монгол улс НҮБ-аас баталсан тогтвортой хөгжлийн конвенцид нэгдэж, 2030 он хүртэлх хөтөлбөрөө баталлаа. Засгийн газрын мөрийн хөтөлбөрт “тогтвортой хөгжлийг шинжлэх ухааны үүднээс үндэслэж өгөх” тухай, Монгол Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт заасан “Тогтвортой, хариуцлагатай, хүчтэй чадамжтай, хууль дээдэлсэн төрт ёсыг баримтална” гэсэн баримт бичгийн санаанд тулгуурлав. Ингэхдээ нийгмийн хөгжлийн оюун санааны үндэс нь юу байх ёстой вэ гэдэгт голлон анхаарав. Энэ асуудал нэн өргөн хүрээг хамрах учиртай: тухайн сэдэв дам атлаа шууд холбогдох гадаадын зарим эрдэмтдийг анхааран шинжлэхээр төлөвлөв.
- Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг боловсруулах. Үүнд: Байгальтайгаа шүтэн барилдах, шинжлэх ухаан ба оюун сэтгэлгээний, ёс журам ба шударга ёсны, мухар сүсэг ба бодит мэдлэгийн, хүмүүнлэгийн болон соёл урлагийн үндэслэлүүдийг боловсруулж төрийн удирдлагад хүргэх;
- Монголчуудын сэтгэлгээ, сэтгэл зүйн онцлог, уламжлалт ёс заншил, ёс суртахуун, улс төр, соёл, урлаг, шашин шүтлэг, хууль эрх зүй зэрэг монголын нийгэм оюун санааны амьдралыг бүхэлд нь танин мэдэхгүйгээр тогтвортой хөгжлийн оюун санааны үндсийг танин мэдэх бололцоогүй юм.

- Сүүлийн 30-аад жилийн хугацаанд монголын нийгмийн оюун санааны амьдралд гарсан өөрчлөлтүүдийг нийгмийн хөгжлийн үе шатуудтай холбон тайлбарлах хэрэгцээ шаардлага тулгарч байна.

### **1.3. СУУРЬ СУДАЛГААНЫ ТӨСЛИЙН НИЙГМИЙН БОЛОН ШИНЖЛЭХ УХААНЫ АЧ ХОЛБОГДОЛ**

Монгол Улсын боловсрол, төрийн болон өөрөө удирдах ёсны бүх шатны байгууллага, соёл, урлаг, хэвлэл мэдээлэл, аж ахуй нэгж зэрэг монголын нийгмийн бүхий л хүрээнд ашиглах, олон нийтийг соён гэгээрүүлэхэд нөлөөлөх боломжтой байна.

### **1.4. СУДЛАГДСАН БАЙДАЛ**

Хөгжлийн удирдлагын загвар, нийгмийн (социаль) үндэслэлийг судалж байсан тодорхой бүтээлүүд бий боловч оюун санааны амьдралыг тухайлан авч судалсан судалгаа ховор байна. Гэвч 2010-аад оноос зарим нэг бүтээлүүд гарсныг тэмдэглэх хэрэгтэй.

- Академич С.Норовсамбуу, академич Г.Чулуунбаатар, профессор Б.Даш-Ёндон нарын удирдлагаар хэвлэгдсэн “Монголын нийгмийн өөрчлөлт” (УБ., 2008, 2013) хамтын бүтээл,
- Б.Даш-Ёндон туурвиж, академич Г.Чулуунбаатарын редакторласан “Монголын хөгжлийн философи (асуудал, аргачлал, ашиг тус)” (УБ.,2013 он), “Нийгмийг танихуй: түүх-хөгжлийн философи” (УБ., 2014 он), Философийн хүрээлэнгээс хэрэгжүүлсэн “Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд нөлөөлөх субъектив хүчин зүйлсийн шинжилгээ” (2017-2019 он) сэдэвт төслийг дурдаж болно.

### **1.5. СУУРЬ СУДАЛГААНЫ ТӨСЛИЙН ҮР ДҮНГЭЭС ГАРСАН ЗАРИМ ДЭВШИЛТЭТ ТАЛУУД**

**Шинэлэг тал:** Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд өрнө дорнын философийн харьцуулсан судалгаа хийж түүнийг энэхүү төсөлд ашиглана.

**Дэвшилттэй тал:** Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг уламжлал дээр (ялангуяа монгол сэтгэлгээний тогтвортой уламжлал) төдийгүй орчин үеийн шинжлэх ухаан технологийн дэвшил дээр хослон суурилсан шүтэн барилдахуйн ухаанаар боловсруулна.

## ХОЁР. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэхэд монголын нийгмийн оюун санааны амьдралд гарч буй өөрчлөлт түүний учир шалтгааныг олон эшт үзлийн зарчмыг баримтлан өрнө дорнын харьцуулсан судалгаанд тулгуурлан монголын нийгэм, хөгжлийн философийн судалгааг хийхдээ төслийн судалгааны арга зүйн хувьд судлаачид өөрсдийн сэдэв, чиглэлд аль тохирсон арга зүйг сонгосон болно. Үүнд:

- Судалгааны үндсэн арга болох таамаглах, ажиглах, харьцуулах аргууд;
- Хүмүүнлэгийн ухааны дүгнэлт гаргахад арга зүйн ач холбогдолтой герменевтик арга;
- Баримт бичгийн шинжилгээний арга;
- Чөлөөт ярилцлага;
- Хувь хүний оршихуйд хандсан экзистенциализм, психоаналитик арга.

Судалгааны үр дүнд харьцуулалт хийх зорилгоор энэ талаар өмнө хийгдсэн судалгаа, эрдэм шинжилгээний ажлын үр дүн, дүгнэлт, статистикийн мэдээллүүдийг гол эх сурвалж болгон ашигласан. Үүнд:

- Шинжлэх ухаан, технологийн тухай хууль
- Шинжлэх ухаан технологийн талаар төрөөс баримтлах бодлого
- Тогтвортой хөгжлийн зорилгын баримт бичгүүд
- Үндэсний хөгжлийн газрын судалгааны тайлан, материалууд
- Монгол Улсын хөгжлийн тухай үзэл баримтлал, хөтөлбөрүүд
- Үндэсний статистикийн хорооны дүн мэдээнүүд
- ШУА-ийн Философийн хүрээлэнд гүйцэтгэсэн социологийн судалгааны тайлангууд гэх мэт.

### **Боловсруулалт:**

- Монголын нийгмийн хөгжлийн талаар бичсэн ном, товхимол, энэ талаар дурдсан төсөл хөтөлбөрүүдийг уншиж судлан боловсруулалт хийж төслийн гүйцэтгэгч нар өөрийн судалгааны чиглэл, сэдэвтэйгээ уялдуулан судалгаа хийж эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл, ном бичиж хэвлэн нийтлүүлсэн.
- Тогтвортой хөгжлийн суурь асуудал, монголчуудын уламжлалт соёл, зан заншил, гоо зүйн үнэлэмж, ёс суртахууны нийтлэг үнэлэмжид тулгуурлан оюун санааны ерөнхий дүр зургийг тодорхойлох үүднээс янз бүрийн салбарын эрдэмтдийн хэлэлцүүлгийг өрнүүлж, эмхэтгэл хэвлүүлсэн нь оюун санааны үндсийг тодруулахад чухал түлхэц болсон.



- Эрдэмтдийн төлөөллийг сонгон экспертийн түвшний хэлэлцүүлэг зохион байгуулсан.
- Төслийн эцсийн бүтээгдэхүүн болох “Тогтвортой хөгжлийн оюун санааны үндэс” хамтын бүтээл нь судлаачдын төслийн хугацаанд хийж гүйцэтгэсэн томоохон судалгаа юм.

## **ГУРАВ. СУУРЬ СУДАЛГААНЫ АЖЛЫН ДҮГНЭЛТ**

Философи нь янз бүрийн үзэл баримтлалуудыг илүү өргөн агуулгаар авч үздэг тэдгээрийн ач холбогдлыг ерөнхий зүй тогтлын үүднээс задлан шинжлээд зогсохгүй ойлголтуудын агуулга, анхны утгыг тайлан ойлгох, тэднийг ашиглах арга барил, дүрмийг тодотгож өгдөг.

Аливаа судалгаанд хэрэглэгдэж байгаа ойлголтын утга агуулга нэг мөр тогтоогүй бол үл ойлголцолд хүрч, танин мэдэхүйн онолын зөрчил үүсч, асуудлыг шийдвэрлэх явдалд бэрхшээл учирдаг. Ийм нарийн төвөгтэй ойлголтын нэг болох “тогтвортой чанар”-ын үзэл баримтлал хүн, байгаль, нийгэм, соёл, танин мэдэхүй, сэтгэл зүй, зан үйл, хүрээлэн буй орчин, эдийн засаг, технологи, шударга ёс, тэгш хуваарилалт, адил боломж, хэрэгцээ гэх мэтийн төвөгтэй олон нэр томъёогоор дамжин оюуны ертөнцтэй холбогдож байдаг. Тэдгээр ойлголт, нэр томъёо нь олон янзын салбарыг хамарч байдаг тул тогтвортой чанар ба оюун санааны асуудлыг зайлшгүй олон шинжлэх ухааны хоорондын хамтын ажиллагаанд авч үзэх ёстой. Үүний тулд хүн гэж юу вэ? байгаль гэдэг юу болох?, хэрэгцээ ямар байдаг тухай тэдгээрийг тодорхойлох шаардлагатай.<sup>1</sup> Ийм шаардлагын үүднээс монголчуудын сэтгэлгээ, сэтгэл зүйн онцлог, уламжлалт ёс заншил, ёс суртахуун, улс төр, соёл, урлаг, шашин шүтлэг, хууль эрх зүй зэрэг монголын нийгэм оюун санааны амьдралыг бүхэлд нь танин мэдэхгүйгээр тогтвортой хөгжлийн оюун санааны үндсийг танин мэдэх бололцоогүй билээ. Иймээс хөгжлийн байгаль, нийгэм, эдийн засгийн талуудыг тэнцвэртэй шүтэн барилдуулах оюун санааны суурь хүчин зүйлүүдийг тогтоох нь бидний ажлын гол зорилго байлаа.

Зорилгынхоо хүрээнд бид суурь судалгааны ажлаа эхлүүлсэн эхний жилдээ тогтвортой хөгжлийн философиор гарсан ном товхимол, баримт бичгүүдэд анализ хийж эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл бичиж хэвлүүлэн эрдэм шинжилгээний хэлэлцүүлэг зохион байгуулсан билээ. Түүнчлэн тогтвортой хөгжлийн талаарх дорно

---

<sup>1</sup> Батын Ч.Ган-Өлзий. Тогтвортой хөгжил: Оюуны ертөнцийн философи. УБ., 2018, 12 дахь тал

дахин, монголын уламжлалт сэтгэлгээний суурь үзэл баримтлалд дүн шинжилгээ хийж компаратив философийн судалгааны бүтээл хэвлүүлэх ажлаа эхлүүлсэн юм. Ингэхдээ “нийгэмд тулгарсан асуудлыг шийдвэрлэхийн тулд философийн эргэцүүллийг нээлттэй болгож, хүмүүнлэгийн, нийгмийн болон байгалийн шинжлэлийн салбар ухаанууд, эдийн засаг, нийгэм, улс төр, шашны хүрээ хийгээд янз бүрийн соёл, уламжлалын үйл ажиллагааны хэлбэрүүдтэй үр дүнтэй хамтран ажиллах нь чухал байна” гэсэн эхний дүгнэлтэд хүрсэн юм.

Бид суурь судалгааны ажлаа хэрэгжүүлсэн хоёр дахь жилдээ тогтвортой хөгжлийн үзэл баримтлалуудад компаратив философийн анализ хийж экспертийн түвшний социологийн судалгаа явуулсан ба мэдээлэлдээ тулгуурлан санал, зөвлөмж гаргасан билээ. Үүний зэрэгцээ төслийн гүйцэтгэгч нар тогтвортой хөгжлийн оюун санааны хүчин зүйлсийг тодруулахыг зорихдоо өөр өөрсдийн судалгааны чиглэлтэйгээ уялдуулан эрдэм шинжилгээний илтгэл, өгүүллийг мэргэжлийн сэтгүүлүүдэд бичиж нийтлүүлсэн нь бидний судалгааны ажил тодорхой үр дүнд хүрэхэд чухал нөлөө үзүүлсэн.

Суурь судалгааны төсөл хэрэгжүүлэх сүүлийн жилд дэлхий дахинд үүсээд буй КОВИД-19 цар тахал дэгдсэнээр санхүүжилт бүрэн хийгдээгүй тул төлөвлөгөөт ажлууд тодорхой хугацаанд хойшилсон учраас төслийн гүйцэтгэлийн хугацааг 1 жил буюу 2021 онд дуусгахаар ШУТС-тай тохиролцсон юм. Гэсэн хэдий ч төслийн багийнхан бичиж нийтлүүлэх, сурталчилан таниулах ажлаа орхигдуулалгүй цахим хурал, хэлэлцүүлгийг зохион байгуулж санал солилцсоор байсан билээ. Төсөл хэрэгжсэн хугацаанд бид нэгэн сэдэвт бүтээл-4, ном товхимол-4, эрдэм шинжилгээний өгүүлэл-9, эрдэм шинжилгээний илтгэл-24-ийг бичиж хэвлүүлжээ.

Төслийн эцсийн үр дүн болох “Тогтвортой хөгжлийн оюун санааны үндэс” сэдэвт хамтын бүтээлийг бичиж хэвлүүлсэн нь нийгмийн хөгжлийн оюун санааны хүчин зүйлсийг тодруулахад үнэ цэнэтэй, ач холбогдолтой бүтээл болсон гэж төслийн багийнхан үзэж байна.

# ДӨРӨВ. СУУРЬ СУДАЛГААНЫ ТӨСЛИЙН ҮР ДҮНГИЙН ТОЙМ

## 3.1. НЭГ СЭДЭВТ БҮТЭЭЛ

Дэлхий нийтэд хэрэгжиж буй тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг монгол улсад хэрэгжүүлэхэд монголчуудын оюун санааны болоод нийгмийн амьдралын төлөв байдал, соёлын онцлог, улс төр, эдийн засгийн хүчин чадал гээд олон янзын хүчин зүйлээс шалтгаалаад гарах үр дүн нь тэр хэрээр ялгаатай байх биз ээ. Олон улсын жишиг стандарт, хүлээгдэж буй үр дүндээ хүрэхийн тулд бид оюун санааны түвшин, бусдаас ялгагдах өвөрмөц онцлог, давуу болон сул талаа судалж тодорхой тодорхой шийдлүүдийг эрэн хайж ажил хэрэг болгох нь тогтвортой хөгжлийн зорилгыг биелүүлэхэд ихээхэн ач тустай болно. Төслийн явцад гүйцэтгэгч доктор (Sc.D), профессор Ч.Ган-Өлзий, доктор С.Соёлмаа нар нэгэн сэдэвт бүтээл хэвлүүлсэн. Үүнд:

1. Философийн шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор Ч.Ган-Өлзий **“Тогтвортой хөгжил: Оюуны ертөнцийн философи”** нэртэй бүтээлээ 2018 онд бичиж хэвлүүлжээ. Редактор доктор Ш.Ганхуяг, шүүмж өгсөн академич Г.Чулуунбаатар, доктор Г.Лодой нар.

Зохиогч уг бүтээлдээ тогтвортой хөгжил ба нийгмийн оюун санааны ертөнц хоёрын харилцааны үндсэн зүй тогтлыг судлах философи, арга зүйн асуудалд зориулагдсан болно. Хөгжлийг үзэх өрөөсгөл философийг даван туулж, үндэстний өв уламжлал, соёл, эв нэгдэл болон олон нийтийн итгэл найдвар, тэгш эрх ба шударга ёс, эрх чөлөөний оюун санааны үндсийг тогтвортой хөгжилтэй холбон шинжилж, харилцааны үндсэн зүй тогтлыг илрүүлэн тодорхойлохыг зорьсон чухал бүтээл юм. Зохиогч уг бүтээлээрээ метаэпистемологийн түвшинд ухаарлын чинадад (transcendental reduction) эргүүлэн шилжүүлэх, хянан засварлах арга хэрэглэдэг өөрчлөгдөгч (transforming), хамтран оролцогч философи (public discourses) нь тайлал зүйн мэдэгдэхүүний билиг байх боломжтойг батлахыг оролджээ.

Жинхэнэ ахуйн шинж чанарт хүрэх Хайдеггер ба Гадамерийн арга зүйг Монголын буддын төв үзлийн тайлал, мэдэгдэхүүний билигтэй шүтэн барилдуулж улмаар тогтвортой хөгжил ба оюуны соёлын харилцааг судлах арга зүй болгон хэрэглэснээр тогтвортой хөгжлийн оюуны ертөнцийн суурь онтологийг зөв ойлгож болно. Чингэвээс, аливаа үндэстний өв уламжлал, соёл ба хөгжлийн ухаарлын чинад орших суурь тулгуур ойлголт болох оюун ухаан, ёс төр ба шаналах сэтгэл гурвыг онтологид

оруулах арга зүй, хөгжил дэвшлийн үндсэн шалгуур болгон ашиглах ёстойг мөн хөгжлийн загвар, үзэл баримтлалуудын дараа үүсэж буй онол чойрууд нийт үндэстнийг хамарсан эдийн засгийн хөгжлийн тухай үзэл санаанд бүрмөсөн эргэлзсэн эргэцүүлэл, сэтгэлгээ, хөгжилд эдийн засгийн өсөлтийг сааруулж, хүн, нийгэм ба байгалийн шүтэн барилдахуйг эрхэмлэхэд чиглэсэн эрэл хайгуулын үр дүн болон шинээр гарч эхэлж байгаа онол, үзэл санааг тогтоосноор хүн, байгаль ба эдийн засгийн шүтэн барилдахуйн их зохицлын эрин эхлэх нь хөгжлийг тогтворжуулах, байгаль хамгаалах, нийгмийн шударга ёсыг тогтоох, энх тайвныг бэхжүүлэх даяарын зорилгод чиглэх ёстой гэдгийг зохиогч энэхүү бүтээлдээ онцолжээ.

2. Философийн шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор **Ч.Ган-Өлзийн “Орчлонгийн нууцыг тайлахуй” (компаратив философийн судалгаа)** сэдэвт бүтээл (УБ.,2020) хэвлэгджээ. Редактор доктор Ш.Ганхуяг, шүүмж өгсөн академич Х.Намсрай, академич Г.Чулуунбаатар нар.

Уг бүтээлийн шинэлэг тал нь философийн компаратив судалгааг ашиглан шинжлэх ухаанч философийг эргэцүүллийн шинэ өндөр түвшин, ойлгохуй ба тайлбарлахуйн гүн тогтолцоонд гаргах оролдлого хийсэн. Үүнд:

- ✓ Космологийн энтроп шинжийг шүүмжлэлтэй судлан квантчлагдсан орон, хугацааны шинэ онолд түшиглэн хэт том хэмжээст (космологийн) болон хэт бага хэмжээст (квантын) хамаарлууд хугацааны олон хэмжүүрээр илэрдэг нь долгион орны хоосон чанар, агшин ба галавын дхармын агуулга, шугаман биш, нэг хэмжээст биш өөрчлөгдөгч Орчлонгийн шүтэн барилдахуйн түгээмэл хуультай дүйж буйг харуулахыг оролдсон.
- ✓ Мэдээллийн нийгэмд интернэтийг бүтээн ашиглах болсон нь онтологийг өргөтгөн танин мэдэхүйн энгийн хувьсгалаас илүү өргөн утга агуулгыг бий болгож, онтологийн бус асуудлыг онтологид оруулан судлах шинэ боломж нээж байгааг онолын хувьд үндэслэв.
- ✓ Орчин үеийн квант болон харьцангуйн онолын монголын буддын философийн тайлбарыг анх удаа хийж, оюун бие хоёрыг шүтэн барилдуулж, объект субъектийг байнга өөрчлөгдөгч нэгдэлд нь авч үздэг арга зүй боловсруулсан байна.
- ✓ Нэг нэгдмэлийн илэрхийлэл тэгш хэм нэрийтгэлийн (ноумэн) чанартай байх атал олонлог нь мэдэгдэхүүний (феноменаль) шинжтэй учраас алив тэгш хэм заавал зөрчигдөх зүй тогтолд үндэслэн шинжлэх ухааны танин мэдэхүй ямагт мэдэгдэхүүний билгээс нэрийтгэл зүйд, түүнээс эргээд дахин мэдэгдэхүүний

билигт, баримтат чанараас онолын загвар бүтээхэд, түүнээс эргээд дахин мэдэгдэхүүн (феномэн)-д шилдэг ойлгох, тайлбарлах орчил мөн гэдэг үндсэн зүй тогтлыг шинээр боловсруулж өгсөн.

- ✓ Зөвхөн “Homo sapiens”-ийн хүрээнд баригдан антроморф шинжтэй байсан сонгодог философи түүнээсээ гарч, физик ба биологи хоёрын судалгааг нэгтгэн ойлгож чадсанаар Орчлонгийн түгээмэл зүй тогтлыг бүхэлд нь тайлж чадах шинэ астрофилософи үүсэх боломжит чиглэлийг таамаглан дэвшүүлэхийг оролдсон болно.

Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын үндэс болж буй ашиг тусын үзэл санааны санаанаас байгаль, нийгэм, хүний хам тогтолцооны шүтэн барилдахуйн үзэл санаанд шилжих зүй тогтолд суурилан хүмүүнлэгийн ертөнцийн философийг шинээр үндэслэж өгсөн.

3. Философийн ухааны доктор (Ph.D) **С.Соёлмаа “Домгийг бүтэц-тэмдэг зүйн үүднээс шинжлэхүй” (Монгол аман зохиолын жишээн дээр)** нэрт бүтээлээ 2019 онд хэвлүүлжээ. Редактор доктор М.Золзаяа, доктор Г.Лодой нар.

Зохиогч уг бүтээлд домгийн философийн тойм, домгийн үүргүүд ба философийн харилцан хамаарал, домгийн бүтэц-тэмдэг зүйн шинжлэлийн онцлог, монголчуудын домгийн сэтгэлгээг судлах зарим асуудал, монгол домгийн бүтцийн онцлогийг аман зохиолын жишээн дээр шинжилсэн байна. Ингэхдээ домгийн тухай онол үзэл баримтлалын тухай тоймыг гаргаж, улмаар домгийн олон талт үүрэг ба философийн үүслийн асуудал, шинжлэх ухаан зэрэг рациональ мэдлэг ба домгийн харилцааг, домгийн бүтэц-тэмдэг зүйн үндсийг, монголчуудын домгийн сэтгэлгээг хэрхэн авч үзэж ирсэн судалгааны тойм зэргийг тодруулж, монголын болон гадаадын философичид, аман зохиол судлаач ба домог зүйч нарын ололт амжилтад тулгуурлан монгол домгийн бүтцийг шинжлэн үзэх зорилт тавьжээ.

4. Судалгааны үр дүнгээр нийгэм, хүмүүнлэгийн салбарын эрдэмтэн судлаачдын оролцоотойгоор **“Тогтвортой хөгжлийн оюун санааны үндэс”** нэртэй сэдэвт хамтын бүтээлийг хэвлүүлсэн юм.



“Тогтвортой хөгжлийн оюун санааны үндэс” (УБ., 2022, шүүмж өгсөн доктор (Ph.D) С.Даваадулам, доктор (Ph.D) С.Цэдэндамба нар). Уг нэгэн сэдэвт бүтээл нь 3 бүлэг, 15 зүйлтэй. Нэгдүгээр бүлэг нь “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын шинжилгээ”, хоёрдугаар бүлэг нь “Тогтвортой хөгжлийн оюун санааны нийгэм-философи шинжилгээ”, гуравдугаар бүлэг нь “Тогтвортой хөгжил ба монголын нийгмийн оюун санааны амьдрал” гэсэн сэдвүүдтэй.

Нэгдүгээр бүлгийн “Тогтвортой хөгжлийн зорилго, зорилт ба үзэл баримтлал” сэдэвт 1§-ийг төслийн удирдагч доктор (Ph.D) Б.Пүрэвсүрэн, “Тогтвортой хөгжил ба даяаршил дангааршлын хамаарал” сэдэвт 2§-ийг доктор (Ph.D) Ш.Ганхуяг, “Тогтвортой хөгжил ба нийгмийн тэгш байдал: Улс төрийн эдийн засгийн анализ” сэдэвт 3§-ийг доктор (Sc.D) Б.Батхишиг, “Олон соёлт нөхцөл дэх хүний тогтвортой хөгжлийн асуудал” сэдэвт 4§-ийг доктор (Ph.D) С.Соёлмаа, “Ёс зүй, тогтвортой хөгжлийн зарим асуудал” сэдэвт 5§-ийг магистр П.Мягмарсайхан нар бичжээ.

Хоёрдугаар бүлгийн “Буддизм дахь оюун санааны тогтвортой хөгжлийн асуудал” сэдэвт 1§-ийг доктор (Sc.D) Д.Гантөмөр, “Хөгжлийг тогтворжуулахад сакраль мэдлэгийн гүйцэтгэх үүрэг: Гүний экологи ба спиритуализм” сэдэвт 2§-ийг магистр О.Болор-Эрдэнэ, “Тогтвортой хөгжил ба оюуны урсгал /Brain Drain/” сэдэвт 3§-ийг доктор (Ph.D) Н.Галиймаа, “Тогтвортой хөгжил ба урлагийн философи” сэдэвт 4§-ийг доктор (Ph.D) Б.Дэлгэрмаа, “Тогтвортой хөгжил ба оюун санааны түвшин” сэдэвт 5§-ийг доктор (Ph.D) Ж.Энхбаяр, “Монголчуудын оюун санааны шинэчлэл ба соёлын бодлого” сэдэвт 6§-ийг доктор (Ph.D) Ж.Долгорсүрэн нар бичсэн.

Гуравдугаар бүлгийн “Монгол менталитет ба монгол ухаан” сэдэвт 1§-ийг доктор (Ph.D) Г.Лодой, доктор (Ph.D) В.И.Павлов, “Монголын нийгмийн ёс суртахууны төлөв байдал” сэдэвт 2§-ийг магистр Ж.Бямбасүрэн, “Тогтвортой хөгжлийн сэтгэл зүй “Хүн байхад суралцахуй”-н монгол өв ба өнөө үе” сэдэвт 3§-ийг доктор (Ph.D) Д.Баттогтох, доктор (Ph.D) Б.Лхамцэрэн, “Монгол дахь тогтвортой хөгжлийн боловсролын үзэл баримтлал, үйл ажиллагаа” сэдэвт 4§-ийг доктор (Ph.D) Г.Уянга нар бичсэн байна.

## НЭГ СЭДЭВТ БҮТЭЭЛ



### 3.2. ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ, СЕМИНАР

1. 2018 оны 11 дүгээр сарын 15-нд **“Олон соёлын хүрээнд экологи, шударга ёс, энх тайвны үйлсэд хамтран ажиллах философи”** сэдэвт эрдэм шинжилгээний хэлэлцүүлгийг зохион байгуулсан.

Хэлэлцүүлгийн зорилго нь байгаль, экологийн тэнцвэрт байдлыг хадгалсан, шударга иргэний нийгмийг цогцлоосон, энх тайвнаар орших олон соёлын уулзвар дахь хүний зөв хандлагыг төлөвшүүлэхэд чиглэдэг философи ба бусад шинжлэх ухааны сүүлийн үеийн судалгааны үр дүнг хэлэлцэж, санал солилцоход оршино.

Хэлэлцүүлгийг нээж ШУА-ийн Тэргүүн дэд ерөнхийлөгч академич Г.Чулуунбаатар, ЮНЕСКО-ийн Монголын Үндэсний Комиссын Ерөнхий нарийн бичгийн дарга С.Уянга нар үг хэллээ. Хэлэлцүүлэгт академич Д.Доржготов “Экологийн сүйрэл ба соёл иргэншлийн хямрал”, доктор (Sc.D), профессор Л.Дүгэржав “Антарактид судлал ба экологи”, доктор (Sc.D) Л.Хайсандай “Монгол төрийн алтан аргамжийн бодлого: Түүх ба орчин үе”, доктор (Ph.D), профессор Б.Пүрэвсүрэн “Нийгмийн экологи ба олон соёлын нөхцөл байдал”, доктор (Sc.D), профессор Ч.Ган-Өлзий “Нийгмийн шударга ёсыг олон соёлын заагт судалж, хамтран хэлэлцэх нь”, доктор (Ph.D), профессор Р.Дарьхүү “Экологийн ёс зүйн асуудалд” доктор (Ph.D) Ц.Батцэрэн “Бид хэн бэ?”, доктор (Ph.D) С.Соёлмаа “Шударга ёс ба иргэний нийгмийн зарим асуудлыг үнэлэмжийн философийн үүднээс авч үзэх нь” зэрэг сэдвээр илтгэл хэлэлцүүлсэн.

Хэлэлцүүлэгт ШУА-ийн Философийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтнууд, ШУТИС, МУИС, ХААИС, Отгонтэнгэр ИС, Ач АУИС-ийн багш нар, оюутнууд, хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөгчид, эрдэм шинжилгээ, судалгааны бусад байгууллагын төлөөлөгчид оролцлоо. Хурлын илтгэлүүдийг “Олон соёлын хүрээнд экологи, шударга ёс, энх тайвны үйлсэд хамтран ажиллах философи” нэрээр эмхэтгэн хэвлүүлсэн.

2. 2019 оны 11 дүгээр сарын 21-нд дэлхийн философийн өдрийг тохиолдуулан төслийн 2019 оны хийж гүйцэтгэсэн судалгаа шинжилгээний үр дүндээ тулгуурлан **“Тогтвортой хөгжил ба оюуны соёлын өв”** сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлыг Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музейд зохион байгуулсан.

Хуралд ЮНЕСКО-ийн МҮК-ийн дарга, нийгэм хүмүүнлэгийн шинжлэх ухаан мониторингийн асуудал хариуцсан мэргэжилтэн, Монголын философийн холбоо, төрийн өмчийн болон хувийн их дээд сургуулийн төлөөллүүд, ШУА-ийн хүрээлэнгүүд,



соёл урлагийн төлөөллүүд, хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөллүүд, оюутан залуучууд гэх мэт өргөн хүрээг хамарсан зочид төлөөлөгчид оролцсон юм. Тус хуралд доктор Б.Галиндэв “Өнөөгийн монголын нийгмийн оюун санааны орон зайн төлөв байдал, агуулга, чиг хандлага”, судлаач С.Одхүү “Монгол менталитетийн асуудалд”, доктор С.Энхбаатар “Монгол дахь философийн хөгжил: Индигенизаци”, доктор Д.Гантөмөр “Монголын оюун санааны тогтвортой хөгжлийн асуудалд”, доктор Ш.Ганхуяг, магистр Ж.Бямбасүрэн “Төрт ёсоо дээдлэх соёл”, доктор Ш.Ариунаа “Аж үйлдвэрийн IV хувьсгалын үед соёл хоорондын харилцаа чухалчлагдах нь” сэдэвт илтгэлүүдийг бичиж хэлэлцүүлээ.

Тус эрдэм шинжилгээний хурлын гол зорилго нь дэлхий дахины өөрчлөлтийн талаарх өргөн хүрээтэй хэлэлцүүлэг өрнүүлэх нөхцөлийг бүрдүүлж, шинэ тутам тулгамдаж буй оюуны болоод хөдөлмөрийн шилжих хөдөлгөөн, хүрээлэн буй орчны өөрчлөлт, хиймэл оюун ухаан зэрэг асуудлыг шийдвэрлэхийн тулд олон талт хамтын ажиллагааг идэвхжүүлэх, дэмжихэд чиглэсэн билээ.

3. 2019 оны 6 дугаар сарын 28-нд судлаачдын үзэл санаа, бодлогын зөвлөмжийг тусгах үүднээс **“Тогтвортой хөгжил ба оюуны урсгал”** экспертүүдийн хэлэлцүүлгийг зохион байгуулсан.

Тус хэлэлцүүлгийн зорилго нь “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” хөтөлбөр хэрэгжихэд нөлөөлөх соёл, боловсрол, ёс зүйн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх үүднээс эрдэмтдийн санаа бодол, үзэл баримтлалыг нэгтгэн зөвлөмж гаргахад оршино.

Дэлхий дахинаа өндөр ур чадвар бүхий ажилтнуудын төлөөх өрсөлдөөн өрнөж буй өнөө үед Монгол улсаа тогтвортой хөгжүүлэхэд оюуны урсгалыг /Brain Drain/ тогтоон барих бодлого чухал бөгөөд энэ нь хүндээ зориулсан оюуны хөрөнгө оруулалт буюу хүмүүн капитал аа үр дүнтэй ашиглах бодлогод хамаарна.

Оюуны урсгал бол өндөр боловсрол, мэдлэг, чадвартай хүмүүс нь гадаадад цалин хөлс өндөр, илүү сайн нөхцөлд ажиллаж, амьдрах үзэгдлийг хэлдэг бөгөөд энэхүү урсгал болон түүнийг тогтоон барих эргэлэг (brain drain and retention) үзэгдэл нь нийгмийн оюун санааны амьдрал дахь оюуны олз (brain gain), оюуны эргэлт (brain circulation), оюуны холбоос (brain linkage) үзэгдлүүдтэйгээ нягт холбоотойгоор улс орон болгонд өөр өөрийн өнгө аясаар хэрэгжиж байна.

Манай орон “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”-г 2016 оны 2 сарын 05-нд УИХ-р баталсан билээ. Уг тогтоолоор Монгол улсын тогтвортой хөгжлийг хорин үзүүлэлтээр хэмжих тухай заагаад “Монгол Улс 2030 онд нэг хүнд ногдох орлогоороо

дунд орлоготой орнуудын тэргүүлэх эгнээнд хүрсэн, тогтвортой өсөж байгаа эдийн засгийн олон салбартай, нийгмийн хүрээнд дундаж болон чинээлэг дундаж давхарга давамгайлсан, экологийн тэнцвэртэй байдлыг хадгалсан, **тогтвортой ардчилсан засаглалтай улс болно**” хэмээн тунхагласан байна.

Улс нийгмээ, засаглалын хувьд тогтвортой байлгаж, зөв бөгөөд гоц гаргуун тохинуулан удирдахад дэлхийн хөгжлийн ерөнхий чиг баримжаанд нийцсэн, өөрсдийн онцлогоо харгалзсан нийцэл найрсал бүхий онол үзэл баримтлал, хөгжлийн бодлогын философитой байх зайлшгүй билээ. Иймийн тулд эрдэм мэдлэгтэй, боловсролтой иргэдээ хэрхэн яаж тогтоон барих вэ? нийгмийн хөгжил юугаар хэмжигдэх вэ? гэх мэт олон асуултад хариулт авах зорилгоор экспертүүдтэй ярилцсан.

***Жич:** Дээр дурьдсан эрдэм шинжилгээний хурал, хэлэлцүүлэгт хэлэлцэгдсэн илгэлүүд хавсралтад бий.*

### **“ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ БА ОЮУНЫ УРСГАЛ” сэдэвт экспертийн түвшний социологийн судалгааны оролцогчид**



*Зураг. 2019 оны 6 дугаар сарын 28-нд, Хүрэлтогоот*

### 3.3. ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ИЛТГЭЛҮҮД

1. Доктор (Ph.D), профессор Б.Пүрэвсүрэнгийн **“Нийгмийн экологи ба олон соёлт нөхцөл байдал”** илтгэлийн гол санаа нь соёл бол тогтвортой хөгжлийг хангагч зүйл. Тогтвортой хөгжлийг хангахын тулд уугуул иргэдийн соёлын олон янз байдал, илэрхийллийг хөндөхгүйгээр хөгжлийн үзүүлэлтүүдийг хангах нь нэн тэргүүнийг зарчим болдог гэсэн санааг илэрхийлжээ.
2. Доктор (Ph.D), профессор Б.Пүрэвсүрэнгийн **“Монголчууд орос хэлийг дөрөөлөхүй: XX зууны монгол”** илтгэлдээ хэл бол соёлын хэрэглээ, соёлын эрх чөлөөний биелэл болох утгаараа соёлын адилсал эсрэг тохиолдолд ялгааны тэргүүн илрэл болдог. Орос хэл, соёлоор хойд хөрштэйгөө ижилсэх их хэрэг XX зууны Монголд өрнөсөн юм. Тийнхүү тэр үеийн дэлхийн их гүрэнтэй (энэ утгаараа Монгол дүү нь) эзэнт их гүрэн байсан монголчууд (энэ утгаараа Монгол ах нь) ах дүүгийн харилцаанд орсон билээ. Гэхдээ ах дүүгийн харилцаа гэдгийг найрамдалт, хамтын, нөхөрсөг гэсэн утгаар тайлбарлан бичжээ.
3. Доктор (Sc.D), профессор Ч.Ган-Өлзий **“Монгол туургатны уламжлал, соёл ба тогтвортой хөгжил”** нэрт илтгэлээ **“Угсаатны уламжлалт өв, соёл тогтвортой хөгжлийн гол шалгуур үзүүлэлт болох нь”** сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний бага хуралд зориулан бичиж хэлэлцүүлжээ.
4. Доктор (Sc.D), профессор Ч.Ган-Өлзий. **“Хүмүүний ахуйн тогтвортой төлөв”** хэмээх илтгэлдээ хүмүүний ертөнцийн утга учрыг судлахдаа философийн шинжлэх ухааны доктор Ц.Балхаажав багшийн нэгэнт боловсруулан баримталж ирсэн бүхэллэг хандлага ба ахуйн задлан шинжилгээнд оруулж буй **“өөрийн”** гэдэг тодотголыг орчин үеийн онтологийн хандлагын үүднээс тайлбарлажээ.
5. Доктор (Sc.D), профессор Ч.Ган-Өлзий **“Олон соёлын хүрээнд шударга ёсны хямралын асуудлыг хамтран ярилцах дискурс”** илтгэлдээ дэлхийн философичдын XXIV их хурлын зорилтыг хэрэгжүүлэхдээ философийн өөрийнх нь тухай, орчин үеийн ертөнцөд түүний эзлэх байр суурь, гүйцэтгэх үүрэг, зорилгын тухай шүүмжлэлт эргэцүүлэлд онцгой анхаарах ёстой хэмээн өөрийн саналаа илэрхийлэн бичжээ.
6. Доктор (Sc.D), профессор Ш.Ариунаа **“Дээд боловсролын багшийн академик ёс зүй”** илтгэлдээ Орчин үед ёс зүйн онол, сургаал нь нийгэм, хүмүүнлэгийн мэдлэгийн салбар ухаанд тасралтгүй хөгжиж онцгой дэлгэрч буй мэдлэг боллоо. Монгол улс дээд боловсролын хөгжил, хандлагаараа дэлхийн нийтийн хөгжлийн голдиролд нэгдэн орж, тэрхүү түвшин, орчин, хүрээлэлтэй хамт

алхахыг зорьж байгаа нь тодорхой. Үүнд чадвартай мэргэжилтэн, хүний хүчин зүйл, оюун сэтгэлгээний үнэ цэн онцгой байр суурь эзлэх нь гарцаагүй боллоо. Бидний өнөөдрийн амьдралд ёс зүй нь мэдлэг, практик, хүмүүсийн хоорондын харилцааны нөхцөл байдалд үйлчилж байдаг гол ойлголт болжээ. Ялангуяа мэргэжлийн ёс зүйн онцлог бол нэн түрүүнд аль ч мэргэжлийн хүрээнд үүсэж буй ёс суртахууны асуудлыг шийдэхэд чиглэж байгаа практик сургаал болоод байгаа талаар өгүүлжээ.

7. Доктор (Sc.D), профессор Ш.Ариунаа **“Ирж байгаа цаг үеийн нийгэм, хүмүүнлэгийн төлөвшлийг авч үзэх нь”** илтгэлдээ шинжлэх ухааны хэрэгцээ, үүрэг улам бүр өсөж, шинэ шинэ салбар ухаан төрөн гарлаа. Улмаар шинжлэх ухааны байр суурь, үүрэг, ач холбогдлыг тодорхойлох хэрэгцээ бий болсон. Энэхүү шаардлагаар 20 зууны 2-р хагаст “Шинжлэх ухааны философи” хэмээх шинэ салбар ухаан үүслээ. Шинжлэх ухааны зорилго нь тодорхойлох, тайлбарлах, урьдчилан харахад оршиж, мэдлэгийг бүтээхэд чиглэж байна. Нийгэм, хүмүүнлэгийн мэдлэг, харилцааны мөн чанараар хүний бүтээлч сэтгэхүйн шинж, идэвхтэй байдал, танин мэдэхүйн түвшин, ойлголт, мэдлэг, боловсрол нь тодорхойлогдож байдаг. Нэг үгээр хэлбэл, нийгэм, хүмүүнлэгийн мэдлэг, соёл нь хүний оршихуйн салшгүй хэсэг, материаллаг ба оюун санааны үнэт зүйлс, амьдралын дүр төрх, загвар, бэлгэдэл тэмдэг, үнэлэмжийн систем юм. Хүмүүсийн өдөр тутмын амьдралдаа “Үнэн гэж юу вэ”, “туршлага гэж юу вэ”, “мэдлэг гэж юу вэ”, “үзэл санаа гэж юу вэ” гэх мэтээр олон арван асуулттай тулгарч байдаг. Эдгээр асуулт нь явсаар шинжлэх ухааны салбарын судалгаа, салбар хоорондын танин мэдэхүйн үндсэн асуудал болж хувирсан юм. Улмаар орчин үеийн шинжлэх ухаан, технологийн өндөр хурдтай хөгжил нь хүний танин мэдэхүйд ирж буй мэдээллийг хэрхэн боловсруулах тухай асуудал, зохиомол оюун ухааны онол, компьютерын тархи, нейро хэл шинжлэл, мэдээллийн загвар гэх мэт ойлголттой нягт уялдах болжээ гэсэн шинэлэг санаануудыг тусгажээ.
8. Доктор (Sc.D), профессор Ш.Ариунаа **“Еврази: Үндэс угсааны тулгамдсан асуудал”** сэдэвт илтгэлдээ Хүний бүрэлдэх үйл явц нь хууль, шашин, хүмүүжил гэсэн ойлголттой ямар нэгэн байдлаар холбогддог. Гэвч хүн өөрөө хэн байхаасаа үл хамааран ямар ч үед өөрийн болон бусдын оюун ухаан, ёс суртахууны үзэгдэл дунд амьдардаг. Ямар ч үндэстэн, хүмүүст ерөнхий хууль үйлчилдэг. Соёл, ёс суртахууны өөрийн төдийгүй бусдын уламжлал, тогтолцоог

хүндлэх, түүнээс суралцах, хор хохирол учруулахгүй байх зэрэг болно. Энэ зорилгод хүрэхийн тулд тодорхой үйл ажиллагааны хүрээ их үүрэгтэй. Мөн хувь хүний онцлог шинж чанарыг харгалзан үзсэн бодлого чухал. Хууль сахиулагчид дээр үүссэн үүргээс заримдаа татгалздаг, учир нь тэдний гарт хүмүүст өөрийнхөөрөө нөлөөлж чаддаг агуу том, хамгийн аюултай эрх мэдэл байдаг. Уг нь бол нийгмийг төдийгүй өмчийн аюулгүй байдал нь иргэний нэгдлийг бий болгох найдвартай арга болж байдаг юм. Гэтэл улс төр, ёс суртахууны нөхцөл байдал нь эсрэг үр дагавар руу хүргэдэг. Жишээ нь, улс төр нь дарамт шахалт, харин ёс суртахуун нь эрх чөлөө рүү тэмүүлж байна. Эдгээрийн дунд үүсэж байгаа зөрчил, нэгэн сонирхолтой нөхцөл байдлыг үүсгэж байна. Энэ бол хувь хүний шинж чанараа хадгалах бас түүгээрээ удирдуулах явдал юм. Орчин үед төрийн зүтгэлтнүүд хүртэл олон үндэстнүүдийг нэг хаалт доор нэгтгэх хүсэлтэй байгаа боловч улс төрийн зөв оновчтой арга хэмжээгээр зорилгодоо хүрнэ хэмээн үзсэн нь бүүр ч их хүндрэл учруулж байна. Учир нь тийм улс төрийн бодлого, арга хэмжээний хүрээнд үндэстнүүдийн ялгаа устаж, хэл, ёс суртахуун, үзэл бодол нь нэг нэгэндээ үүсэж байгаа юм. Гэвч ямар нэгэн золиосгүйгээр онцлог ба нэгэн төрлийн шинжүүдийг хадгалж бие даасан нөхцөлтэйгөөр үлдээж болох уу? Хэрвээ төрийн зүтгэлтэн энэ асуултад хариулт эрж эхэлбэл хувь хүний нэр хүнд, ашиг сонирхлыг төр, ард түмний үйл хэргийн төлөө хэрхэн зохицуулж, ашиглаж болох тухай бодох хэрэгтэй болно. Гэвч энэ асуудлыг шийдэх цорын ганц арга зам бол тухайн субъектийн хувь шинж чанарыг л бодитойгоор судлах хэрэгтэй болох юм.

9. Доктор (Ph.D) Ж.Энхбаяр **“Жон Дьюи: Хүний мөн чанарын тухай”** хэмээх илтгэлдээ Жон Дьюиг нэгд, багш, боловсролын шинэчлэлийн төлөөх хөдөлгөөний эцэг, хоёрт, либераль ардчилсан үзэлтэн, гуравт, прагматик сэтгэгч гэсэн гурван үндсэн хүрээнд авч үзжээ.
10. Доктор (Ph.D) С.Соёлмаа, доктор (Ph.D), профессор Г.Лодой нар **“Мэдлэгийн тогтвортой хөгжил дэх домгийн төсөөлөх үүргийн асуудалд”** илтгэлдээ мэдлэгийн тогтвортой хөгжил гэдэг бол шинжлэх ухаан, философи гэх рациональ шинжтэй мэдлэгүүд дангаараа, өөрөөр хэлбэл домог, шашин зэрэг иррациональ мэдлэггүйгээр хөгжих бололцоогүй байдаг тухай бичжээ.
11. Доктор (Ph.D) С.Соёлмаа **“Шударга ёс ба иргэний нийгмийн зарим асуудлыг үнэлэмжийн философийн үүднээс авч үзэх нь”** хэмээх илтгэлийн гол утга нь

үнэлэмжийг субъект-объект гэсэн сонгодог философийн үүднээс авч үздэг хандлагыг шүүмжилж, субъект-субъектийн харилцаанд тогтолцооны үүднээс авч үздэг орчин үеийн зарим философийн гол санааг дэвшүүлж, улмаар эдгээр философийн үүднээс орчин үеийн монголын иргэний нийгмийн шударга байдлыг авч үзсэн байна.

12. Философийн ухааны магистр Ж.Бямбасүрэн **“Монгол хүний ёс суртахууны үнэт зүйлийн өөрчлөлт”** илтгэлдээ монгол хүн гэж ийм хүнийг хэлнээ гэсэн ёс суртахууных нь үүднээс тодорхойлох шинжүүд юу байж болох вэ талаар тунгаан бодож, энэ талаар ном, өгүүлэл уншиж судлахдаа монгол хүний ёс суртахууны эрхэмлэл, үнэт зүйлийг тодорхойлохдоо монголчуудын түүх, нийгмийн тогтолцооны онцлогтой нь уялдуулан судлах нь илүү оновчтой болох юм хэмээн бодлоо.
13. Философийн ухааны магистр Ж.Бямбасүрэн **“Орчин цагийн монголын хүний хандлагыг эргэцүүлэх нь”** илтгэлдээ одоогоос 20 гаруй жилийн өмнө өдрийн сонинд нийтлэгдсэн монгол судлаач Кимура Аяакогийн бичсэн “Тархины тураал” нийтлэлийг уншаад төрсөн сэтгэгдэл дээрээ үндэслэн бичсэн байна.
14. Доктор (Ph.D), профессор Ш.Ганхуяг, философийн ухааны магистр Ж.Бямбасүрэн нарын **“Төрт ёсоо дээдлэх соёл”** илтгэлийн гол санаа нь хууль цааз үүсээгүй эрт үед хүмүүсийн харилцааг зохицуулагч гол зүйл нь ёс суртахуун байсан бол төрт ёс үүссэнээр нийгмийн харилцааг хууль, дүрэм журам зохицуулах болсон. Монголын төрт ёсны уламжлалын хөрс суурь нь нүүдэлчдийн соёл, ёс заншил, сэтгэлгээний уламжлал юм. Монголын нүүдэлчдийн төрт ёс нь тэдний амьдралын арга ухаан, ёс заншил, шашин шүтлэг, сэтгэл зүйн болон үнэлэмжийн онцлогоос улбаатай төрийг тогтоогч оюун санааны багана юм. Монголын нүүдэлчдийн төрт ёсны уламжлалыг авч үзэхдээ, төрт ёс нь төрийн бичиг соёл, төрөөс иргэн, улс түмэндээ хандах хандлагыг илэрхийлсэн засаглалын үзэл санаа, иргэдээс төрд хандах ёс, үзэл бодол, суртал хийгээд төрийн билэгдэлтэй холбоотой гэсэн санаагаа дэлгэрүүлэн бичжээ.
15. Доктор (Ph.D) С.Соёлмаа **“Тогтвортой хөгжлийн ёс зүйн асуудлыг монгол домгийн бүтцээр шинжлэхүй”** илтгэлдээ тогтвортой хөгжлийн ёс зүйг Монголчуудын соёлын өв болох Монголын нууц товчооны нэгэн домгийн жишээн дээр шинжилжээ. Илтгэлийн шинэлэг санаа нь тогтвортой хөгжлийн ёс зүйг хүн ба байгаль/хүрээлэн буй орчин, болон техно-эдийн засгийн тогтолцоо

хоорондын харилцааны ёс зүй хэмээн үндэслээд улмаар Монголын нууц товчоонд байх Алун Гоо эхийн домогт хүн-байгаль-нийгмийн тэнцвэртэй харилцааны ёс зүйг шинжилсэнд оршиж байна. Мөн энэхүү домог нь Монголчуудын дунд тархсан домгуудаас домгийн бүтцийг илүү хадгалсан болохыг философийн үүднээс үндэслэсэн юм.




16. Философийн ухааны магистр Ж.Бямбасүрэн, шашин судлалын магистр Б.Мөнхцацралт нарын **“Экологийн ёс зүйн боловсролд шашны гүйцэтгэх үүрэг”** илтгэлийн гол утга нь Монголчууд байгаль, хүрээлэн буй орчинтойгоо нягт зохицон амьдарч ирсэн уламжлалтай. Эх дэлхийтэйгээ ойр байж, ахуй амьдралаа залгуулж ирсэн нь хүрээлэн буй байгаль орчноо хайрлан хамгаалах эрхэм ёс, хорио цээр бүхий үзэл санаа, зан үйлийн цогцыг бий болгожээ. Монголчуудын хувьд байгаль орчноо хамгаалах нь түүнийг гаднын ямар нэгэн хүч нөлөөнөөс нүд цавчилгүй харж хамгаалахын, эсвэл эвдрэл доройтолд орсных нь дараа “орсон борооны дараа цув нөмрөх” адил халаглан харамсахын нэр төдий бус бөгөөд харин болзошгүй эрсдэл, аюулаас урьдчилан сэргийлэхэд байгалийн зүй ёсонд нийцэн амьдрах, газар дэлхийгээ ижийтэйгээ зүйрлэн, хүндэтгэн дээдлэх, түүнийг хүнчлэн үзэж, хүмүүнлэг сэтгэлээр хандан, амьтан ургамлаа энэрэх, экологийн өндөр ёс зүйтэй байж нөөц баялгийг нь ариглан гамнах үзлээр илэрхийлэгдэх билээ гэсэн санааг харуулан бичжээ.
17. Философийн ухааны магистр П.Мягмарсайханы **“Тогтвортой хөгжихөд монголчуудын байгаль хамгаалах ёс зүйн үзэл чухал болох нь”** илтгэлийн гол санаа нь хүн төрөлхтөн хөгжлийн төлөө ганц чиглэл зорилготой явсаар эдүгээ зарим улс өндөр хөгжилд хүрч, зарим нь хөгжлийнхөө шатанд, ерөнхийдөө хөгжихийн тулд байгаа боломж бүхнээ шавхаж байгаа нь хүний амьдралын чанарт сайн талтай хэдий ч нөгөө талд нь байгаль орчинд сөргөөр нөлөөлөх нь ихсэж, эрт цагаас байгальтай дасан зохицож амьдарч ирсэн уламжлалыг эргэн харах шаардлагатай болсон. Монголчууд хүрээлэн буй орчин, газар шороо, уул усаа хайрлан хамгаалж байгальтайгаа зүй зохистой харьцаж амьдарч ирсэн олон зуун жилийн баялаг уламжлалыг орчин үеийн тогтвортой хөгжлийн асуудалд хэрхэн чухал болохыг илтгэлдээ хөндсөн. Хүний төлөө хөгжил дэвшил хурдтай явж байгаа байгаа шиг хүн амьдралын хэв маягаа байгальд ээлтэй байхаар зохион байгуулах, үүний тулд уламжлалт үнэт зүйл, дэвшилтэт соёл, амьдрах аргаа харгалзан үзэх хэрэгтэй тухай авч үзсэн.


18. Доктор (Ph.D), профессор Ш.Ганхуяг, доктор (Ph.D) Б.Очирхуяг нар **“КОВИД-19 цар тахал ба биофилософийн өөрчлөлт”** сэдэвт илтгэлдээ ковид-19 цар тахал хэзээ нэгэн цагт дуусах нь тодорхой боловч бидний амьдралд гарсан олон олон өөрчлөлтүүд манай нийгэмд цаашдын хэрэгцээ, үйл явц болон үлдэх тухай өгүүлжээ.
19. Доктор (Sc.D), профессор Ч.Ган-Өлзий **“Технологийн метафизик ба цахим ертөнц”** нэрт илтгэлдээ мэдээллийн нийгэмд интернэтийг бүтээн ашиглах болсон нь онтологийг өргөтгөн танин мэдэхүйн энгийн хувьсгалаас илүү өргөн утга агуулгыг бий болгож, онтологийн бус асуудлыг онтологид оруулан судлах шинэ боломж нээж байгааг онолын хувьд үндэслэжээ.
20. Доктор (Sc.D), профессор Ч.Ган-Өлзий **“Дооромбо Гэлэгжамцын боловсрол сурганы үйл ажиллагаа”** сэдэвт илтгэлээ “ХХ зууны Монголын утга соёлын өв” эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэлд хэвлүүлжээ.
21. Философийн ухааны магистр Ж.Бямбасүрэн **“Цахим орчны нөлөөнд өртсөн монгол ахуй”** илтгэлдээ даяаршлын нөлөөгөөр монголчууд суурин соёлд хурдацтай шилжих болсон нь нүүдэлчдийн уламжлалт соёлын залгамж холбоо алдагдахад хүрч улмаар гаднын юм бүхнийг шүтэн биширч, даган дуурайх боллоо. Энэ байдал даамжирсаар төрөлх хэл, соёл, зан заншил, аж төрөх ёсоо үгүйсгэх дүр зураг ч ажиглагдаж байна. Гадны юм бүхэн гоё, сайхан, үнэтэй бас бахдалтай. Харин дотоодын “уламжлалт” тодотголтой юм бүхэн үеэ өнгөрөөсөн, бүдүүлэг, хөдөөнийх болчихно. Ингэж өнгөрсөн түүх, уламжлал соёлоо үгүйсгэж тэр ч байтугай мэдэхгүй өсөж байгаа хүүхдүүд улс орныхоо соёлын дархлааг, үндэсний аюулгүй байдлаа хэрхэн, яаж хамгаалах вэ? Иймээс хүүхэд, залууст улсынхаа түүхийг үнэн зөвөөр танин мэдүүлж, өв соёлоороо бахархах, хүндэтгэн бишрүүлэх сэтгэлийг төрүүлж, цаашлаад түүх, ёс заншлаа өвлүүлэхэд чиглэсэн ажлыг бодлогын түвшинд дэмжин ажиллаж, хэрэгжүүлэх нэн шаардлагатай байна. Иймийн тулд сүүлийн 15 жилийн хугацаанд монголчуудын амьдралд гүн нэвчсэн цахим сүлжээг эергээр ашиглаж үүсээд буй соёлын энэ гажуудлыг арилгах, үндэсний түүх, соёлоо танин мэдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг түгээмэл явуулах нь зүйтэй гэсэн санааг илэрхийлжээ
22. Доктор С.Соёлмаа (Ph.D) **“Соёмбо үсгийн тухай философийн дискурсэд”** илтгэлээрээ соёмбо үсгийн бэлгэдэлт утгыг зөв буруу хэмээн дүгнэх гэсэнгүй, харин тайлбарлаж, хэлэлцүүлэгт ороход нь зуучилж улмаар соёмбо үсгийн тухай нийгмийн тогтсон ойлголтоос арай өөр утгыг тайлахыг зорьжээ.



23. Доктор (Ph.D) Ж.Энхбаяр **“Үзэл суртал ба улс төрийн дискурс”** хэмээх илтгэлдээ сүүлийн гучаад жилд улс төрийн олон төрлийн үзэл баримтлал дэлгэрч, түүгээрээ ялгарч эвлэлдэн нэгдсэн улс төрийн намууд, нийгмийн бүлэг хөдөлгөөнүүд үүсэн бүрэлдэв. Нэг үзэл суртал тойрон нийгмээрээ нэгдэн нягтарч байсан бол одоо нийгэм, улс төр, оюун санааны төлөв байдал үндсээрээ өөрчлөгдөж, иргэдийн үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, итгэл үнэмшлээрээ улс төрийн намд элсэх, сонгох, сонгогдох эрх чөлөө бүхий улс төрийн плюралист орчин бий болж, нэгдэж нягтрахын зэрэгцээ зөрчил, зөрөлдөөн ихтэй улс төрийн шинэ үзэгдэл, үйл явцаар дүүрэн нийгмийн амьдралын бодит байдлыг онцлон бичжээ.
24. Доктор (Sc.D), профессор Ч.Ган-Өлзийгийн **“Аргусан хуурчийн домог” шастирт философийн эргэцүүлэл (philosophical reflections)-ийг олны хэлэлцүүлэг (discursus) болгох аргыг хэрэглэсэн нь”** сэдэвт эрдэм шинжилгээний илтгэл нь философийн эргэцүүлүүд (philosophical reflections)-ийг олны хэлэлцүүлэг болгодог монолог, диалоги ба дискурсын уламжлалыг гарган үзүүлэхээр Чингис хааны амьд сэрүүн байх үеийн шүлэглэсэн найраглалын цөөн дурсгалын нэг гэж олонх эрдэмтэд санал нэгтэй үздэг “Аргасун хуурчийн домог” хэмээх шастирыг сонгон авснаараа онцлог ажээ.

**ТӨСЛИЙН ГҮЙЦЭТГЭГЧДИЙН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ИЛТГЭЛ  
БИЧИЖ ХЭВЛҮҮЛСЭН ЭШБХ-ЫН ЭМХЭТГЭЛҮҮД**





### 3.4. ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ӨГҮҮЛЛҮҮД

Төслийн гүйцэтгэгчид нийгмийн тогтвортой хөгжил, хүмүүнлэг үзэл, ёс зүй, оюун санааны суурь онтологийн асуудлаар 2018 онд -2, 2019 онд -6, 2020 онд 1 өгүүллийг хэвлүүлжээ. Үүнээс гадаадад 1 өгүүлэл хэвлэгдсэн байна.

1. Философийн ухааны доктор (Ph.D) С.Соёлмаа нь **“Мэдлэгийн тогтвортой хөгжлийн хүрээнд домгийн гүйцэтгэх үүргийг шинжлэх асуудалд”** нэрт өгүүлэлдээ мэдлэгийн тогтвортой хөгжлийн хүрээнд шинжлэх асуудлыг домгийн гүйцэтгэх үүргийг нэр томъёоны гарал үүсэл болон орчин үеийн зарим философийн үүднээс тухайлбал, бүтэц шинжлэлийн үүднээс авч үзжээ. Мэдлэг ерөнхийдөө ердийн мэдлэгээс нарийн төвөгтэй, илүү системчилсэн мэдлэг рүү хөгждөг. Ердийн мэдлэгээс домгийн, домгийнхоос философийн мэдлэг рүү, философиос шинжлэх ухаанд шилжих үеийг шатыг дамждаг гэсэн ерөнхий санааг илэрхийлсэн байна.
2. Философийн ухааны магистр Ж.Бямбасүрэн **“Эрдэм шинжилгээний ажилтны ёс зүй”** сэдэвт эрдэм шинжилгээний өгүүлэлдээ боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 454 дүгээр тушаалын хавсралтаар эрдэм шинжилгээний ажилтны ёс зүйн ерөнхий дүрмийг баталсан байдаг. Уг дүрмийн хэрэгжилт болоод бодит байдалд хэрхэн бууж байгаа тухай асуудлуудыг хөндөж, шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн хэрэгжилт эрдэм шинжилгээний ажилтнуудад хэрхэн тусгалаа олж байна вэ? гэх зэрэг асуудлыг судлан шинжилж, ёс зүйн дүрэм зөрчигдөөд байгаа шалтгааныг тодруулан цаашдаа зөрчил, маргаан гаргахгүй байхад анхаарах санамжийг боловсруулах зорилго тавин ажиллалаа. Энэхүү зорилгынхоо хүрээнд шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн шинэчилсэн найруулга болон эрдэм шинжилгээний ажилтны ёс зүйн ерөнхий дүрмийг судлан шинжилж, зөрчигдөөд байгаа заалтуудыг тусгайлан авч үзээд цаашид анхаарч ажиллах саналыг дэвшүүлжээ.
3. Философийн шинжлэх ухааны доктор (Sc.D) Ч.Ган-Өлзийн **“Йогочара ба квант физик”** өгүүлэлдээ шинжлэх ухааны танин мэдэхүй дэх “суурь үндэслэгээ”-ний үзэл санааг бүх оршигчийн тайлал зүйн мэдэгдэхүүний билиг л ойлгож тайлбарлах боломжтой. Ийм санаа нь Орчлонгийн философийн дүр зургийг зохион бүтээх, түүнийг шинжлэх ухааны үүднээс олж харахад зайлшгүй хэрэгтэй. Материйн суурь үндсэн түвшинд хэт чавхдас нь өөрийн квант орны өдөгдөн хөөрөх, чичигнэн долгилох ба эргэлдэн хуйлрах өөрчлөлтөөр бөөмс ба





хүчний мэдэгдэхүүний билгийн ертөнцийн бүх үүсгүүр, шүтэн барилдсан зохицлыг төрүүлж байдаг гэсэн санааг илэрхийлжээ.

4. Философийн шинжлэх ухааны доктор (Sc.D) Ч.Ган-Өлзийн **“Хаосын тайлалын мэдэгдэхүүний билиг”** нэрт өгүүлэлдээ философи анх үүсэхдээ огторгуйн тухай, орчлон ертөнц хэрхэн хаос буюу хоосон чанараас үүссэн болон түүний бүтэц ба бүрэлдэн буй болсон хамгийн жижиг тоосны тухай ухаан л байлаа. Философи хөгжиж ирсэн олон мянган жилийн түүх бүхэлдээ Орчлон, түүний үүсэж хөгжсөн хууль зүй тогтлыг тайлбарлах, энгүй энэ дайдад хүмүүний ахуйн эзлэх байр суурь, үүргийг ойлгох оролдлого байсан талаар өгүүлжээ.
5. Философийн ухааны доктор (Ph.D) Ш.Ганхуяг, философийн ухааны магистр Ж.Бямбасүрэн нар **“Нээлттэй нийгмийн тухай К.Попперийн үзэл”** нэрт өгүүлэлдээ нээлттэй нийгмийн тухай К.Попперийн үзлийг шинжлэхэд А.Бергсоны “хаалттай нийгэм” гэсэн ойлголтыг судлах шаардлагатай болдог тухай; учир нь хаалттай нийгмийн онцлог шинжийг ойлгосноор нээлттэй нийгмийн давуу тал, онцлогийг мэдэх бололцоотой. К.Поппер “нээлттэй нийгэм”-ийн гол шинжийг тодорхойлохдоо “ийм нийгэм бол иргэдийнхээ бие даасан, бүтээлч, шүүмжлэлт үйл ажиллагааны үр дүн байдаг” гэсэн үзлийнх нь талаар; тиймээс нийгмийн хөгжил нь тусгай объектив хууль, зүй тогтлоор тодорхойлогдохгүй хэмээн К.Поппер үзсэн юм. Ингэж нээлттэй нийгмийн шинжийг тодруулахдаа тэрээр историзм, историцизм хэмээх хоёр ойлголтын зөрүүг тайлбарласан байдаг. Өгүүлбээс “историзм бол юмыг түүхэн ёсоор үзэхийг, өөрөөр хэлбэл түүхчлэн үзэхийг шаарддаг, энэ чанараараа шинжлэх ухааны хувьд зөв зүйтэй. Харин историцизм бол өөр юм. Историцизм нь нийгмийн ухаан болбоос ирээдүйг урьдчилан харах зорилгоор түүхийн хуулиудыг нээх ёстой гэж үздэг. Историцизмын ёсоор урт удаан хугацааны урьдчилан харахуйг гаргавал энэ нь шалгалт, няцаалтад өртөхгүй, иймд үл гүйцэлдэх, зөгнөн мөрөөдсөн шинжтэй болно. Ийм зөгнөл мөрөөдөл шинжлэх ухааны урьдчилан харахуйтай огт тохирохгүй ажээ. Ийнхүү нээлттэй нийгмийн тухай үзлээ тэрээр “Нээлттэй нийгэм, түүний дайснууд”, “Түүхчлэх үзлийн гуйланчлал”, “Диалектик гэж юу вэ?”, “Марксын зөгнөл, Марксын ёс зүй” гэх мэт олон зохиол бүтээлүүддээ илэрхийлсэн байдгийг шинжлэн судлах зорилт тавьжээ.
6. Философийн шинжлэх ухааны доктор (Sc.D) Ч.Ган-Өлзийн **“Тогтвортой хөгжил ба шашны тухай орчин үеийн философи асуудалд”** өгүүлэлдээ

тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд тулгуурлан монголчуудын шашин шүтлэгийн онцлог байдлыг тайлбарласан байна.

7. Философийн ухааны магистр П.Мягмарсайхан **“Принципы гуманизма по отношению к природе как фактор устойчивого развития”** өгүүлэлдээ тогтвортой хөгжих хэрэгцээ тулгамдсан шинж чанартай болж буй өнөө үед дэлхийн улс орон бүхэн өөрсдийн оруулах хувь нэмэр, хөгжих бодлогоо томъёолсон байдаг. Үүнд улс орон бүхэнд хамаатай түгээмэл суурь ойлголт бол хүрээлэн буй орчиндоо хэрхэн хүмүүнлэгээр оршин тогтнож, аж төрөх вэ гэдэг асуудал болохыг тодруулж, монголчуудын байгалиа эрхэмлэн дээдлэх үзэл санаа нь хүнлэг энэрэнгүй ёсны үйл, үйлдэл байсныг өнөө цагт харгалзан үзэх нь тогтвортой хөгжих үзэл санаанд чухал болохыг авч үзсэн.
8. Философийн ухааны магистр Ж.Бямбасүрэн **“Нийгмийн тогтвортой хөгжил ба хувь хүний ёс суртахууны ухамсар”** хэмээх өгүүлэлдээ “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал – 2030” нь нийгэм, эдийн засаг, экологийн гурван тулгуурт үзэл баримтлал дээр тулгуурлан батлагдсан байдаг. Нийгмийн тогтвортой хөгжлийн хүрээнд хүн ам зүйн бүтэц, эрүүл мэнд, боловсрол, соёл, шинжлэх ухааны хөгжлийн төлөв байдал, дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ, хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдлийн түвшин, нийгмийн халамж, хамгаалал гэх мэт олон асуудлыг ярьж болно. Эдгээрийн хэм хэмжээг зохист түвшинд барьж хөгжүүлэхэд иргэн бүрийн оролцоо, идэвх санаачилга хамгаас чухал. Хүмүүс хоорондын харилцаан дээр нийгэм суурилдаг учраас нийгмийн тулгамдаж буй асуудал эцэстээ хүний өмнө тулгарч буй бэрхшээл юм. Иймийн тулд уг өгүүлэлдээ нийгэмд үүсээд байгаа зохисгүй үйлдэл, гэмт хэрэг зэрэг сөрөг үзэгдлүүд хувь хүний ёс суртахуунтай шууд хамааралтай болохыг тодорхойлж, үүнийг даван туулах гарц шийдлийг “ёс зүйн боловсрол” мөн гэсэн санаагаа илэрхийлжээ.
9. Философийн шинжлэх ухааны доктор (Sc.D) Ч.Ган-Өлзийн **“Хэт тэгш хэмийн философийн асуудал”** өгүүлэлдээ Орчлонгийн жам ёсны түгээмэл зүй тогтлыг философийн арга зүйгээр задлан шинжилж, зөв тайлбарлах нь тогтвортой ирээдүйн ашиг сонирхлын үүднээс шинжлэх ухаан, технологи ба инновацыг ашиглах онолын үндэслэл болж өгөх төдийгүй, алсын хараатай бодлого боловсруулж, хэрэгжүүлэхэд хөтөч болох практик ач холбогдолтойн талаар бичжээ.

**ТӨСЛИЙН ГҮЙЦЭТГЭГЧДИЙН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ӨГҮҮЛЭЛ  
БИЧИЖ ХЭВЛҮҮЛСЭН МЭРГЭЖЛИЙН СЭТГҮҮЛҮҮД**





К.И.Погосян «Лубан хуурч»  
Зөтөн, тос, 1932 он.  
Улаанбаатар хотноо Театрын музейд  
хадгалагдаж буй

# ШИНЖЛЭХ УХААН АМЬДРАЛ

## ШИНЖЛЭХ УХААН - ТАНИН МЭДЭХҮЙН СЭТГҮҮЛ

МОНГОЛ УЛСАД САЛХИНЫ ЭРЧИМ ХУЧИЙГ АШИГЛАХ БОЛОМЖ \* МОНГОЛ ОЮУНЫ УР  
ЧАДВАРЫН ЧИГ ХАНДЛАГЫН СУДАЛГАА \* ТӨВ АЗИЙН УС ХАГАЛБАР \* АЛТАЙН УРИАНХАЙН  
УЛАМЖЛАЛТ ЭСТИЙГ ӨВЛӨН ХАДГАЛЖ БУЙ ВАЙДАЛ \* МОНГОЛД АНУ-ИЙН ХУДАЛДАА,  
ЭДИЙН ЗАСГИЙН АШИГ СОНИРХОЛ БУЙ БОЛЖ ӨНГӨЖӨН НЭ \* НИЙГМИЙН ТОГТВОРТОЙ  
ХӨГЖИЛ БА ХУВЬ ХҮНИЙ ЕС СУРГАХУУНЫ УХАМСАР \* ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ БА ШАШНЫ  
ТУХАЙ ОРЧИН ҮЕИЙН ФИЛОСОФИ АСУУДАЛД \* ХАЙПЕРСПЕКТИЙН ТАНДАН СУДЛАЛЫН  
ОРЧИН ҮЕИЙН ЧИГ ХАНДЛАГА \* ДАРАМБАЗАРЫН СЭНГЭЭ ГЭВЦ \* МӨСӨН ШАГАЙН ХАРВАА  
\* НЭГЭН САНААЧЛАГЫН ТҮҮХ \* УРАН ЗОХИОЛ ДАХЬ ГЭМЭЭНИЙ ДҮРСГӨЛГИЙН ХАРЬЦУУЛАЛ

4  
2019

“УТГАА ХАМСЭН ҮГИЙН УТГА, ХЭРГЭГЭЭ Х.Н”





### 3.5. НОМ ТОВХИМОЛ

1. Төслийн хүрээнд 2018 онд “Олон соёлын хүрээнд экологи, шударга ёс, энх тайвны үйлсэд хамтран ажиллах философи” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэлийн эмхэтгэн гаргасан. Редактор доктор Б.Пүрэвсүрэн, хэвлэлд бэлтгэсэн философийн магистр Ж.Бямбасүрэн.

Тус хэлэлцүүлгээс дараах ерөнхий зөвлөмж гарсан:

**Энх тайвны үйлсэд:** Монгол улс бол тусгаар тогтносон, бүрэн эрхт, иргэний ардчилсан хүмүүнлэг нийгмийг цогцлоосон, чөлөөт зах зээлийн эдийн засаг бүхий, парламентын засаглалтай улс юм. Монгол улс өнөөдөр гадаад харилцаандаа Чингисийн үеэс уламжилж ирсэн **Алтан аргамжийн бодлогыг** баримтлах нь зүйтэй бөгөөд энэ нь улс төр-эдийн засгийн хувьд төдийгүй олон соёл, шашин хоорондын харилцаа, хэлхээ холбоог дэмжсэн, эв найрамдалтай, харилцан ашигтай хамтын ажиллагааг нөхцөлдүүлсэн гадаад бодлогын зарчим юм.

**Байгаль, экологийн хувьд:** Байгальд ээлтэй эрчим хүчний эх үүсвэрийг хөгжүүлэх тал дээр анхаарч, байгалийн нөөц баялгийг өдөр тутмын амьдралдаа хэмнэж; монголчуудын уламжлалт байгальтайгаа нэгдмэл, зохицолтой ханддаг үзэл санааг багаас нь монгол иргэн хүнд төлөвшүүлж; байгалийн баялгийг хувийн эрх ашиг, шуналын үүднээс ашиглаж буй гадаадын болон дотоодын байгууллага, хүмүүсээс хамгаалж; байгалиа хайрладаг хамгаалдаг хэмнэдэг экологийн соёлыг хүний бүхий л харилцаанд нэвтрүүлэх нь чухал юм.

**Шударга нийгмийн үйлсэд:** Иргэн бүрийн хүсэл эрмэлзэл, чин эрхэмлэлийг харгалзан үзсэн; тулгадаг, шийтгэдэг бус, харин ёс зүйтэй улс төр эрх зүйн хэм хэмжээ, бодлогыг чухалчилсан; төр нь иргэнээ, иргэн нь төрөө дээдэлсэн эрх зүйн орчныг бүрдүүлж; оролцооны ба харилцааны ардчилал, ёс зүйг нийгмийн гол зарчим болгосон; нийгмийн, хамтын болон хувь хүнийхээ оюунлаг үнэт зүйл дээдэлсэн, иргэнийхээ бие эрүүл мэндийг нь хайрлаж хамгаалсан, соёлт нийгмийг цогцлоох зарчим нь шударга нийгмийн үйлсэд чухал ач холбогдолтой юм.

2. Философийн шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор **Ч.Ган-Өлзий “Тогтвортой хөгжил: Нийгмийн шударга ёсны философи” (компаратив философийн судалгаа)** нэрт бүтээлээ 2019 онд бичиж хэвлүүлжээ. /Редактор доктор О.Хатанболд, шүүмж өгсөн академич Г.Чулуунбаатар, академич Ж.Болдбаатар нар/.

Зохиогч уг бүтээлдээ шударга ёсны үзэл санааг дорно өрнийн философийг харьцуулсан судалгаанд суурилан тайлбарлах, шударга ёс бол нийгмийн тогтвортой

хөгжлийн суурь зарчим мөн гэж тайлал зүйн мэдэгдэхүүний билгийн философийн үүднээс үндэслэж өгөх зорилго тавьжээ. Энэ зорилгод хүрэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлж шийдвэрлэхийг оролджээ. Үүнд:

- ✓ “Шударга ёс” гэдэг ойлголтын агуулгыг нийгэм-философийн ай хэмээн өргөн утгаар тодотгон, түүний парадигмуудыг тодорхойлж өгөх;
- ✓ Шударга ёсны үзэл санааны хувьсал хөгжлийг мөшгөн сурвалжилж, дорно өрнийн философид тайлбарлаж ирсэн гол хандлагын онцлогийг илрүүлэх;
- ✓ Шударга ёсны хэрэгжилтэд нийгэм ба хүй хамтлаг болон хувь хүний оролцооны зохицлыг үндэслэж өгөх; “шударга ёс” ба “тэгш байдал” хэмээх ойлголтуудын харьцааны онцлогийг орчин үеийн шатанд гарган харуулах; тогтвортой хөгжлийн хэтийн төлөв, алсын харааны суурь зарчим болох нийгмийн шударга ёсны үзэл санааг шүтэн барилдахуйн үүднээс боловсруулахын зайлшгүй чухлыг үндэслэж өгөхөд чиглэжээ.

Энэхүү бүтээлийн шинэлэг санаа: Тогтвортой хөгжлийн үндэс болгон шударга ёсны зарчмын үндэсний өв соёл, уламжлалыг улс төрийн байгууламжуудтай шүтэн барилдуулсан үзэл баримтлал боловсруулах ёстой. Энэ хандлагын гол үзэл санаа нь: 1. тогтвортой хөгжлийн шударга ёсны суурь үндэс болгон хэрэгцээ, ашиг тусыг авч үздэг сэтгэлгээнээс уламжлалыг улс төрийн зарчимтай шүтэн барилдуулах зохицлын үзэл санаанд шилжих; 2. шударга ёсны тогтолцооны хамгийн үр ашигтай төлөв нь тогтвортой тэнцвэргүй байдал гээд шинэ философийг үндэслэх; 3. хүн нийгмийн харилцаанд хувь хүний ашиг сонирхол хамгийн чухал гэдэг философиос татгалзаж, хувь хүн, хүй хамтлаг ба нийгмийн харилцаа тэргүүн ач холбогдолтой гэж үзэх; 4. ийм хандлага танин мэдэхүйн орчин үеийн үлгэр загварт нийцэх бөгөөд шинжлэх ухаан, философийн хуучирсан сэтгэлгээг даван туулахад тус болох нь дамжиггүй.

3. Философийн шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор **Ч.Ган-Өлзий**, философийн ухааны доктор (Ph.D) Г.Уянга нарын **“Тогтвортой хөгжилд чиглэсэн үйлийн боловсрол” (компаратив философийн судалгаа)** сэдэвт бүтээл 2019 онд хэвлэгджээ. /Редактор доктор Т.Нэмэхжаргал, шүүмж өгсөн академич Б.Жадамба, академич Г.Чулуунбаатар нар/.

Энэхүү бүтээлийн зорилго нь байгальтай шүтэн барилдсан үйлээр хөгжиж ирсэн боловсрол, хүмүүжлийн сургаал, амьдрах ухааны монголын уламжлалт үзэл санааг “Оюун түлхүүр” шастирын жишээн дээр гаргаж, түүнийгээ орчин үеийн прагматик философи дахь үйлийн боловсролын тухай Ж.Дьюин үзэл баримтлалтай харьцуулан тогтвортой хөгжлийн үндсэн зүй тогтолтой холбон судлахад чиглэжээ.

4. Төслийн хүрээнд экспертийн хэлэлцүүлэг зохион байгуулж “Тогтвортой хөгжил ба оюуны урсгал” сэдэвт зөвлөмжийг 2019 хэвлүүлсэн. /Редактор: Б.Пүрэвсүрэн, хэвлэлд бэлтгэсэн: Ж.Бямбасүрэн/.

Хэлэлцүүлгийн үр дүнд товхимол гаргасан ба дараах санал, зөвлөмжүүдийг тусгажээ. Үүнд:

- 1) **“Brain Drain” хэмээх ойлголтын тухайд:** “Brain Drain” оросоор “Мозговая утечка” хэмээх ойлголтыг энэхүү хэлэлцүүлэгт өндөр ур чадвартай мэргэжилтнүүдийн гадагшаа чиглэсэн шилжих хөдөлгөөн буюу “оюуны урсгал” гэж нэрлэх саналтайгаар хэлэлцсэн билээ. Хэлэлцүүлгийн явцад экспертүүд уг ойлголтыг “оюуны гоожилт”, “оюуны урсгал”, “оюуны нүүдэл”, “оюуны шилжилт хөдөлгөөн” гэх мэт олон утгаар тайлбарлаж байсан юм. Ямартаа ч дотроос гадагшаа чиглэсэн шилжилт хөдөлгөөн гэж тодорхойлсон юм. Ингэхдээ “Оюуны урсгал” гэж орчуулах нь илүү эвтэйхэн, наалдацтай орчуулга болох юм гэсэн шийдвэрт хүрлээ.

Зарим эксперт хэлэлцүүлгийн сэдвийг ач холбогдолтой ч өнөөдрийн Монголын нөхцөлд “Brain drain” нь тийм ч аюулын түвшинд хүрэхээр хэмжээнд очоогүй хэмээн дүгнэсэн юм.

- 2) **“Brain Drain” буюу “Оюуны урсгал” үүсэж буй нийгэм-соёлын нөхцөл:**

• Засгийн газар, яамд, нийслэлийн удирдах газраас дарга, сайд нар ирж бодлого хөтөлбөрөө эрдэмтэн, профессор, судлаач нарт танилцуулдаг. Угтаа эрдэмтдэд бодлого танилцуулах биш, харин эрдэмтэд тэр бодлогыг боловсруулж, эрдэмтдээс заавар зөвлөгөө авдаг байх учиртай. Ингэж чадаагүйгээс шинжлэх ухааны үндэслэлгүй төрийн бодлого цаг хугацааны шаардлага, шалгуурыг дааж чадахгүй байна. Монгол төрийн залгамж чанар, засгийн газрын үйл ажиллагаа, ажлын байрны хангалт, улс төрийн намуудын үйл ажиллагааны доголдоос хамаарч мэргэжилтэй боловсон хүчнүүдийг тогтвортой ажиллуулах зарчим алдагдсантай холбогдон монголдоо мэргэжлээрээ ажиллах залуучуудын итгэл алдарсан нь оюуны урсгалыг бий болоход ихээхэн нөлөөлж байна.

• Улс орны бие даан оршин байх түүнийгээ хадгалах гол нөхцөл нь хэл, соёл байдаг. Сүүлийн үед монголчууд гадаад хэлийг ялангуяа англи хэл сурахыг ихэд хичээх болсон нь төрөлх монгол хэлээ зөв зүйтэй ашиглаж чадахгүйд хүрч байна. Ийм байдал нь биднийг сэтгэлгээний хувьд маш их ядууруулж, шинжлэх ухааны ойлголт, нэр томъёо ч хөгжихгүй болжээ. Тиймээс тогтвортой хөгжлийн оюун санааны үндэс гэдэг бол эцэстээ “хэл, соёл”-д л оршиж байдгийг бодох учиртай.

- Эрүүл биетэй, эрдэм боловсролтой, ёс суртахуунтай хүн бол Монголын баялаг. Үүний тулд бид хүнээ хүмүүжүүлэх, хөгжүүлэх тал дээр онцгой анхаарах шаардлагатай болсон. Япон хүнийг хүмүүжүүлж төлөвшүүлэхэд Бүшидо, хятад хүнийг хүмүүжүүлж төлөвшүүлэхэд Күнзийн сургаал чухал үүрэг гүйцэтгэдэг шиг Монгол хүнийг “монгол хүн” болгож төлөвшүүлэх нэгдсэн үнэт зүйл бидэнд нэн шаардлагатай байна. Үндэсний соёлын дархлаа сайтай Монгол хүнийг бий болгож чадах юм бол гадагшаа явсан ч, яваагүй ч өнөөдрийн бидний ярьж хэлэлцэж буй асуудал тодорхой хэмжээнд шийдэгдэх боломжтой.

3) *“Brain Drain” буюу “Оюуны урсгал” үүсэж буй шинжлэх ухаан, боловсрол, боловсон хүчин (хүний нөөц)-тэй хамаатах нөхцөл:*

- Манайд шинжлэх ухааныг хөгжүүлэх хамгийн гол зүйл нь “хэрэглээ” юм. Шинжлэх ухаан төдийгүй мэдлэгийн хэрэглээ. Гэтэл бодит байдал дээр ихэнх тохиолдолд дипломын хэрэглээтэй болчихоод мэдлэгийн хэрэглээ нь чухал биш болжээ. Яагаад залуу боловсон хүчнүүд гадагшаа яваад байна вэ? Дээд боловсролтой хүн гадаадад хар ажил хийх нь цаг зуурын үзэгдэл ч өндөр мэргэжилтэй хүн мэргэжлээрээ ажил хийх гэж байгаа бол харин өөр хэрэг. Энэ бол манай үйлдвэрлэл, шинжлэх ухаан тухайн хүнийг хэрэглэж чадахгүй байна л гэсэн үг. Өөрөөр хэлбэл манай оронд шинжлэх ухаан хөгжихгүй байна. Үүний гол учир нь шинжлэх ухаан хэрэглээнд нэвтрэхгүй байгаатай шууд холбоотой. Тиймээс УИХ, засгийн газраас төсөл хөтөлбөрийг ШУА, их, дээд сургуулиудад захиалгаар гүйцэтгүүлж судалгааны үр дүнгээс нь хууль тогтоомж бодлогодоо тусгадаг тогтолцоотой байх шаардлагатай. Иймээс гадагшаа чиглэсэн энэ хөдөлгөөнийг зогсоохын тулд шинжлэх ухаан, мэдлэгийн хэрэглээг л бий болгох ёстой юм.

- Түүнчлэн их, дээд сургуулийн сургалтын чанар, төгссөний дараа ажлын байраар хангах явдал учир дутагдалтай байна. Энэ нь оюутан залуусын ирээдүйдээ итгэх итгэлийг бууруулж ингэснээрээ гадаадад ажиллаж амьдрах хүсэл тэмүүллийг нэмэгдүүлж байна. Харин гадаадад сурч, ажиллаж, амьдарч байгаа монголчууд эх орондоо ирэхээрээ дотоодынхоо нийгэм, эдийн засаг, эрх зүйн орчин, боловсролын чанар, хүртээмж, үйлдвэрлэл, үйлчилгээний соёл зэргийг голж байна. Иймээс гадагшаа чиглэж байгаа урсгалыг зогсоох, тогтоон барих гэхээсээ илүү гадаадад боловсрол эзэмшиж, дэвшилтэд технологийг ашиглаж, шинэ шинэ боломжийг олж харж өөрчлөлт хийхийг хүсэж тэмүүлж байгаа залуучуудаа буцааж эх оронд нь татах оролдлогыг бодлогын түвшинд хийж хэрэгжүүлэх нь хамгийн зөв шийдэл болно.

- Монголоос монголчууд гарахдаа өөрийнхөө оюуны урсгалыг аваад оюунаа биш харин өөр хүчийг ашиглах байдалтай байна. Үүнийг зөв ойлгож, зөв дүгнэх хэрэгтэй. Нэгэнт эрч хүчээ авчихсан, хувийн боломж бололцоогоо харчихсан дээрээс нь дэлхий нээлттэй болсон энэ цаг үед хувь хүний хөгжил, үр хүүхдийнхээ боловсрол, амьдралын чанараа сайжруулах гээд маш олон асуудлын үүднээс оюунаа ч авч явж байна, биеийн хүч, эрүүл мэндээ ч авч явж байна. Тэгэхээр бид монголоо бусад оронтой дамнасан ажил төрөл хийх боломжийг бүрдүүлмээр байна.

4) **“Brain Drain”** буюу **“Оюуны урсгал”** үүсэж буй шашны нөхцөл:

- Монгол Улсад өрнөсөн ардчилсан өөрчлөлтийн 30 шахам жилийн хугацаанд дэлхийд зонхилох томоохон шашнуудаас гадна шинээр дэлгэрсэн шашны олон урсгал чиглэлүүд орж ирэн тууштай үйл ажиллагаа явуулж байгаа нь ихээхэн аюултай үзэгдэл юм. Олон зууны номлол, туршлага, арга барил, санхүүжилт, зохион байгуулалттай шашны институци дараагийн үеийн жинхэнэ номлогчоо бэлтгэж, тухайн газар орон, нийгэм соёлд өөрийн гэсэн байр суурь, нөлөөг баттай тогтоож чаддаг байна. Тэгэхээр гадаадын миссионерууд болон гадаад дотоодод бэлтгэгдсэн номлогчдын үйл ажиллагаагаар дамжаад оюун санаа, итгэл үнэмшлийн оюуны урсгалын олон чиг хандлага манайд нэвтэрч (brain gain) байгааг ихэд анхаарууштай.

• “Brain drain” үүсэх шашны нөхцөл байдал өнөөдрийн нийгэмд “Brain gain”-ыг бодвол тийм ч аюултай үзэгдэл биш байна. Харин гаднаас орж ирж байгаа шашны олон урсгал чиглэлийн нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөг бид анзаарч тэдгээр байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах нь зүйтэй.

5) **“Brain Drain”** буюу **“Оюуны урсгал”** гэсэн ойлголтыг *Тогтвортой хөгжлийн зорилттой холбогдуулахад:*

- Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, үндсэн зарчим байгаа ч, тухайн үндэстний байгаль цаг уур, эрхлэх аж ахуй, нийгэм-соёл, хүн ам зүйн бүтэц, ертөнцийг үзэх үзэл, үнэт зүйл, мэдрэмжээс ихээхэн шалтгаалах учиртай. Өөрөөр хэлбэл ямар үнэт зүйлсээр тэтгэгдэнэ тийм л дүр зураг гарч ирнэ. Иймээс бидэнд нэгдсэн үнэт зүйл, эрхэмлэл хамгаас чухал байна.

- Хийх бүтээх ажил үйлтэйгээ, эх оронтойгоо уягдах, өөриймсөх нь хүний хэрэг боловч уяж холбох нь төрийн хэрэг юм. Юуны өмнө хүмүүс “би энэ эх орны, энэ газар шорооны эзэн” гэдгээ ухаарах, тийм ч учраас “би үүний төлөө өөрийгөө зориулна” гэдэг чин бодол, хүсэл эрмэлзэлтэй болох учиртай юм. Урсгал гэдэг бол эцсийн бүлэгт “энэ Эх орны Эзэн нь хэн бэ? гэдэг асуудал. Дэлхий нийтийг хамарсан даяаршил, өөриймсөх үйл явцын түүхэн нугачаанд жинхэнэ монгол өв соёл, уламжлалт мэдлэг

ухаан, технологи нь Монгол орны бие даан орших гол хүчин зүйл юм. Тиймээс өв соёлоо хадгалан хамгаалж, өвлүүлэн үлдээх нь тогтвортой хөгжлийн чухал хөшүүрэг болох ажээ. Ингэж чадвал монголчуудын гадагш чиглэсэн оюуны урсгал “төвөөс зугтсан шигээ төв рүү тэмүүлдэг” байгалийн хууль, зүй тогтол мэт заавал эргэж ирнэ гэдэгт хэлэлцүүлэгт оролцогчид бат итгэлтэй байгаа юм.

## НОМ, ТОВХИМОЛ

дэлхийн философийн өдөр - 2018





ШУА-ийн Философийн хүрээлэн нь ЮНЕСКО-ийн Монголын Үндэсний Комисстэй хамтран 2013 онд "Философи өнөөдөр" сэдэвт илтгэлийн уралдаан, 2014 онд "Ертөнцийн шинжлэх ухааны дүр зургийн өөрчлөлт ба философи" сэдэвт симпозиум, 2016 онд "Аристотель ба орчин үеийн философи сэтгэлгээ" сэдэвт эрдэм шинжилгээний бага хурал, 2017 онд "Тогтвортой хөгжил: Оюуны соёл" сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлыг тус тус зохион байгуулж ирсэн.

Энэ жилийн дэлхийн философийн өдөр 11 дүгээр сарын 15-нд тохиож байгаа бөгөөд олон улсад "Хамтдаа амьдарч сургаая" уриан дор хэлэлцүүлэг, дугуй ширээний ярилцлагын хэлбэрээр зохион байгуулагдаж байгаа бол манай оронд байгаль, экологийн тулгамдаж байгаа олон чухал асуудлуудыг "Олон соёлын хүрээнд экологи, шударга ёс, энх тайвны үйлсэд хамтран ажиллах философи" сэдвийн хүрээнд багцлан хэлэлцэж анэхүү эмхэтгэлийг хэвлүүлээ.

Жил бүрийн эрдэм шинжилгээний хурал, хэлэлцүүлгийн ерөнхий ивээн тэтгэгчээр ажилладаг ЮНЕСКО-ийн Монголын Үндэсний Комисст гүн талархал илэрхийлэе.

ШУА-ИЙН ФИЛОСОФИЙН ХҮРЭЭЛЭН

**ОЛОН СОЁЛЫН ХҮРЭЭНД ЭКОЛОГИ,  
ШУДАРГА ЁС, ЭНХ ТАЙВНЫ ҮЙЛСЭД ХАМТРАН  
АЖИЛЛАХ ФИЛОСОФИ**

*Эрдэм шинжилгээний хэлэлцүүлгийн эмхэтгэл*








ISBN 991767402-7  
9 789917 674027



"Сэдвийн гүнзгий" хэвлэлийн үйлвэрийн эмхэтгэл  
УТАС: 976 11 325052, 99569646, 99181421  
Facebook: www.facebook.com/soyimboprinting



Улаанбаатар 2018



### **3.6. БҮТЭЭЛИЙН ЖАГСААЛТ**

#### **НЭГ СЭДЭВТ БҮТЭЭЛ-4**

1. Ч.Ган-Өлзий. Тогтвортой хөгжил: Оюуны ертөнцийн философи. Редактор доктор (Ph.D) Ш.Ганхуяг. УБ., 2018.
2. Ч.Ган-Өлзий. Орчлонгийн нууцыг тайлахуй. Редактор доктор (Ph.D) Ш.Ганхуяг. УБ., 2020.
3. С.Соёлмаа. Домгийг бүтэц-гэмдэг зүйн үүднээс шинжлэхүй (Монгол аман зохиолын жишээн дээр). Редактор доктор (Ph.D) М.Золзаяа, Г.Лодой. УБ., 2019
4. ШУА-ийн Философийн хүрээлэн. Тогтвортой хөгжлийн оюун санааны үндэс. Хамтын бүтээл. УБ., 2022.

#### **НОМ, ТОВХИМОЛ-4**

1. ШУА-ийн Философийн хүрээлэн. Олон соёлын хүрээнд экологи, шударга ёс, энх тайвны үйлсэд хамран ажиллах философи (ЭШХ-ын эмхэтгэл). Редактор доктор (Ph.D) Б.Пүрэвсүрэн. УБ., 2018.
2. Ч.Ган-Өлзий. Г.Уянга. Тогтвортой хөгжилд чиглэсэн үйлийн боловсрол (компаратив философийн судалгаа). Редактор доктор (Ph.D) Т.Нэмэхжаргал. УБ., 2019.
3. Ч.Ган-Өлзий. Тогтвортой хөгжил нийгмийн шударга ёсны философи (компаратив философийн судалгаа). Редактор доктор (Ph.D) О.Хатанболд. УБ., 2019.
4. ШУА-ийн Философийн хүрээлэн. Тогтвортой хөгжил ба оюуны урсгал (санал, зөвлөмж). Редактор доктор (Ph.D) Б.Пүрэвсүрэн. УБ., 2019.

#### **ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ӨГҮҮЛЭЛ-9**

1. Ж.Бямбасүрэн. Эрдэм шинжилгээний ажилтны ёс зүй. //Шинжлэх ухаан амьдрал. №3. УБ., 2018.
2. Ж.Бямбасүрэн. Нийгмийн тогтвортой хөгжил ба хувь хүний ёс суртахууны ухамсар. //Шинжлэх ухаан амьдрал, №4. УБ., 2019
3. Ч.Ган-Өлзий. Йогочара ба квант физик. //Философи эрхийн судлал XXXIY. УБ., 2019
4. Ч.Ган-Өлзий. Хаосын тайллын мэдэгдэхүүний билиг. //Философи, шашин судлал №21 (516). УБ., 2019



5. Ш.Ганхуяг, Ж.Бямбасүрэн. Нээлттэй нийгмийн тухай К.Попперийн үзэл. //Философи, шашин судлал №21 (516). УБ., 2019
6. Ч.Ган-Өлзий. Тогтвортой хөгжил ба шашны тухай орчин үеийн философи асуудалд. //Шинжлэх ухаан амьдрал №4. УБ., 2019
7. Ч.Ган-Өлзий. Хэт тэгш хэмийн философийн асуудал. //Философи эрхийн судлал. УБ., 2020
8. П.Мягмарсайхан. Принципы гуманизма по отношению к природе как фактор устойчивого развития. //Международный научно-исследовательский журнал. 2019
9. С.Соёлмаа. Мэдлэгийн тогтвортой хөгжлийн хүрээнд домгийн гүйцэтгэх үүргийг шинжлэх асуудалд. //Философи, эрхийн судлал XXXIII. УБ., 2018

#### **ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ИЛТГЭЛ -24**

1. Ш.Ариунаа. Дээд боловсролын багшийн академик ёс зүй. //Тогтвортой хөгжил- Дээд боловсрол улсын II зөвлөгөөн. УБ., 2018
2. Ш.Ариунаа. Ирж байгаа цаг үеийн нийгэм, хүмүүнлэгийн төлөвшлийг авч үзэх нь. //Аж үйлдвэрийн 4 дэх хувьсгалын үе ба Монгол улсын хөгжлийн асуудлууд УБ., 2018
3. Ш.Ариунаа. Еврази: Үндэс угсааны тулгамдсан асуудал. //Евразийн соёл иргэншил: Түүх ба өнөө үе. УБ., 2018
4. Ж.Бямбасүрэн. Монгол хүний ёс суртахууны үнэт зүйлийн өөрчлөлт. //Хүмүүний ертөнц ба тогтвортой хөгжил. УБ., 2018
5. Ж.Бямбасүрэн. Орчин цагийн монголын хүний хандлагыг эргэцүүлэх нь. //Олон соёлын хүрээнд экологи, шударга ёс, энх тайвны үйлсэд хамтран ажиллах философи. УБ., 2018
6. Ж.Бямбасүрэн, Б.Мөнхцацралт. Экологийн ёс зүйн боловсролд шашны гүйцэтгэх үүрэг. //Тогтвортой хөгжил: Ногоон ёс зүй. УБ., 2019
7. Ж.Бямбасүрэн. Цахим орчны нөлөөнд өртсөн монгол ахуй. //Монголын нийгэм дэх цахим орчны нөлөөлөл: Философи асуудлууд. УБ., 2020
8. Ш.Ганхуяг, Ж.Бямбасүрэн. Төрт ёсоо дээдлэх соёл. //Тогтвортой хөгжил ба оюуны соёлын өв. УБ., 2019
9. Ш.Ганхуяг, Б.Очирхуяг. КОВИД-19 цар тахал ба биофилософийн өөрчлөлт. //Монголын нийгэм дэх цахим орчны нөлөөлөл: Философи асуудлууд. УБ., 2020

10. Ч.Ган-өлзий. Монгол туургатны уламжлал, соёл ба тогтвортой хөгжил. //Угсаатны уламжлалт өв, соёл тогтвортой хөгжлийн гол шалгуур үзүүлэлт болох нь. ОУЭШХ. УБ., 2018
11. Ч.Ган-өлзий. Хүмүүний ахуйн тогтвортой төлөв. //Хүмүүний ертөнц ба тогтвортой хөгжил. УБ., 2018
12. Ч.Ган-өлзий. Олон соёлын хүрээнд шударга ёсны хямралын асуудлыг хамтран ярилцах дискурс. //Олон соёлын хүрээнд экологи, шударга ёс, энх тайвны үйлсэд хамтран ажиллах философи. УБ., 2018
13. Ч.Ган-Өлзий. Технологийн метафизик ба цахим ертөнц. //Монголын нийгэм дэх цахим орчны нөлөөлөл: Философи асуудлууд. УБ., 2020
14. Ч.Ган-Өлзий. Дооромбо Гэлэгжамцын боловсрол сурганы үйл ажиллагаа. //XX зууны Монголын утга соёлын өв. УБ., 2020
15. Ч.Ган-Өлзий. “Аргусан хуурчийн домог” шастирт философийн эргэцүүлэл (philosophical reflections)-ийг олны хэлэлцүүлэг (discursus) болгох аргыг хэрэглэсэн нь. //Олон нийтийн дискурс дэх философийн үүрэг. УБ., 2021
16. Б.Пүрэвсүрэн. Нийгмийн экологи ба олон соёлт нөхцөл байдал. //Олон соёлын хүрээнд экологи, шударга ёс, энх тайвны үйлсэд хамтран ажиллах философи. УБ., 2018
17. Б.Пүрэвсүрэн. Монголчууд орос хэлийг дөрөөлөхүй: XX зууны монгол. //Хүмүүний ертөнц ба тогтвортой хөгжил. УБ., 2018
18. С.Соёлмаа, Г.Лодой. Мэдлэгийн тогтвортой хөгжил дэх домгийн төсөөлөх үүргийн асуудалд. // Хүмүүний ертөнц ба тогтвортой хөгжил. УБ., 2018
19. С.Соёлмаа. Шударга ёс ба иргэний нийгмийн зарим асуудлыг үнэлэмжийн философийн үүднээс авч үзэх нь. //Олон соёлын хүрээнд экологи, шударга ёс, энх тайвны үйлсэд хамтран ажиллах философи. УБ., 2018
20. С.Соёлмаа. Соёмбо үсгийн тухай философийн дискурсэд. //Олон нийтийн дискурс дэх философийн үүрэг. УБ., 2021
21. Ж.Энхбаяр. Жон Дьюи: Хүний мөн чанарын тухай. //Хүмүүний ертөнц ба тогтвортой хөгжил. УБ., 2018
22. С.Соёлмаа. Тогтвортой хөгжлийн ёс зүйн асуудлыг монгол домгийн бүтцээр шинжлэхүй. //Тогтвортой хөгжил: Ногоон ёс зүй. УБ., 2019
23. П.Мягмарсайхан. Тогтвортой хөгжихөд монголчуудын байгаль хамгаалах ёс зүйн үзэл чухал болох нь. //Тогтвортой хөгжил: Ногоон ёс зүй. УБ., 2019

24. Ж.Энхбаяр. Үзэл суртал ба улс төрийн дискурс. //Олон нийтийн дискурс дэх  
философийн үүрэг. УБ., 2021

ТӨСЛИЙН ТАЙЛАН БИЧСЭН:  
ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ

ФИЛОСОФИЙН УХААНЫ МАГИСТР  
Ж.БЯМБАСҮРЭН

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ӨГҮҮЛЛҮҮД



STUDIA PHILOSOPHIAE ET JURIS  
INSTITUTI PHILOSOPHIAE  
ACADEMIAE SCIENTIARUM MONGOLICI

TOMUS XXXIII FASCICULUS 1-24

ФИЛОСОФИ,  
ЭРХИЙН  
СУДЛАЛ

✦ XXXIII БОТЬ

Улаанбаатар  
2018

## ГАРЧИГ

### Нэг. ФИЛОСОФИ

1. **Ч.Ган-Өлзий**  
*Монголын мадхьямака ба квант физик* 5
2. **Б.Пүрэвсүрэн**  
*Языковая картина мира: вопросы онтологического начала монгольского языкового ландшафта* 16
3. **И.Лхам, Г.Уянга**  
*Боловсролын талаарх Ж.Дьюнгийн үзэл баримтлалын арга зүйн үндэс* 21
4. **М.Гантуяа, Гэгээнтүяа**  
*Хятад Ганжуур, Данжуурын судлал* 31
5. **С.Соёлмаа**  
*Мэдлэгийн тогтвортой хөгжлийн хүрээнд дамгийн гүйцэтгэх үүргийг шинэслэх асуудалд* 45
6. **Д.Оюунгэрэл, М.Наранцэцэг**  
*Ёс суртахууны боловсрол нь боловсролын философийн чухал асуудал болох нь* 53
7. **Б.Бадрах**  
*Ухамсар уу, бозон уу* 60
8. **Б.Мөнхцацралт**  
*Хятадын их сэтгэгч Лаозын "Дао-дө-жсин" зохиол дахь "үлэмж хүний" тухай үзэл* 67
9. **Б.Ариунзул**  
*Pratīna эпистемологи: танин мэдэхүйн процессын онолын логик бүтэц* 76

### Хоёр. УЛС ТӨРИЙН ЭДИЙН ЗАСГИЙН УХААН

10. **Б.Даш-Ёндон**  
*Улстөрийн эдийн засгийн ухааны философийн асуудалд* 92
11. **Ш.Ганхуяг**  
*Философийн хүрээлэнгийн Философийн салбарт Улс төрийн эдийн засгийн ухааны тасаг байгуулах хэрэгцээ, шаардлагын тухай* 116
12. **Б.Батхишиг**  
*Эдийн засгийн хөгжил ба түүний үзүүлэлт, илэрхийллийн тухай асуудал* 124
13. **Д.Ууганжаргал**  
*Дахин хуваарилалтын бодлогын асуудалд* 144
14. **Б.Батхишиг**  
*Орлого хуваарилалтын зөрчил* 160

## МЭДЛЭГИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ХҮРЭЭНД ДОМГИЙН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРГИЙГ ШИНЖЛЭХ АСУУДАЛД

С.Соёлмаа

Доктор (Ph.D),

ШУА-ийн Философийн хүрээлэн, Философийн салбар

**Abstract:** The article discusses and identifies methodological and terminological ambiguities and problems associated with the study of the roles of myth in the framework of the sustainable development of knowledge.

First of all, we clarify the concept as “sustainable development of knowledge”. Here we support the position of structuralism that the individual should be treated both as mythological-religious and scientific knowledge in order to ensure the sustainability of the spiritual life of society.

Secondly, we are exploring the concept of “myth” here. Although the concept of myth in the Mongolian language is used in different senses, many representatives of Mongolian linguists and philosophers agree that the myth can be called “domog” in the Mongolian language and this concept differs from the rest as a legend, tradition and fairy tale by the terminology and modern philosophy. We here support the position of the American philosopher S. Langer that the myth has a conceptual character in contrast to such concepts as legends, epics and fairy tales. And we believe that the myth is a single picture, which contains the idea, knowledge, faith, value of being.

Thirdly, we propose the idea that the magic function of the myth (although there are different functions of the myth) plays a huge role in the sustainable development of knowledge, especially in the medical practice of different nations. And we believe that magic is not a separate form of thinking, as some researchers believe. Magic is a certain function of consciousness, which is based on its myth and has its own logic; the subject of magical action really affects the object. And we came to the conclusion that in order to argue such a position on magic, we need to turn carefully to the history of the development of knowledge of different peoples.

**Түлхүүр үгс:** домог мэдлэгийн тогтвортой хөгжил, ахуйн тухай төсөөлөл, итгэл үнэмшил, үнэлэмж, илбэ домын үүрэг

Энэ өгүүлэлд мэдлэгийн тогтвортой хөгжлийн хүрээнд шинжлэх асуудлыг домгийн гүйцэтгэх үүргийг нэр томъёоны гарал үүсэл болон орчин үеийн зарим философийн үүднээс тухайлбал, бүтэц шинжлэлийн үүднээс авч үзлээ. Мэдлэг ерөнхийдөө ердийн мэдлэгээс нарийн төвөгтэй, илүү системчлэгдсэн мэдлэг рүү хөгждөг. Ердийн мэдлэгээс домгийн, домгийнхоос философийн мэдлэг рүү, философиос шинжлэх ухаанд шилжих үе шатыг дамждаг.

Бүтэц шинжлэлийн философи (структурализм) мэдлэгийн төрөл зүйлүүд, жишээ нь, домог зүйн болон шинжлэх ухааны мэдлэг танин мэдэхүйн логик, механизмаараа адил тул аль нэг нь болхи, нөгөө нь илүү боловсронгуй гэж батлах бололцоогүй гэдэг. Бүтэц шинжлэлийн философийн эцэг хэмээн нэрлэгддэг, францын философич, хүн судлаач



*Жуулчлалын төв байгуулагчдад зориулав.*

# ШИНЖЛЭХ УХААН АМЬДРАЛ

## ШИНЖЛЭХ УХААН - ТАНИН МЭДЭХҮЙН СЭТГҮҮЛ

ЧИНГИСИЙН ЧУЛУУНЫ БИЧИГ • МАТЕМАТИК ЗАГВАРЧЛАЛ • СЭТГЭЛИЙН ТУХАЙ ШАШНЫ НОМЛОЛЫГ БАЙГАЛИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ЗАРИМ ОНОЛТОЙ ХОЛБОН АВЧ ҮЗЭХ НЬ • ИХ ХЭМЖЭЭНИЙ ӨГӨГДӨЛ БА NADOOR СИСТЕМ • ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ АЖИЛТНЫ ЁС ЗҮЙ • ТОЙРОН БҮЖГИЙН ТУХАЙ МНТ-Д ҮГҮҮЛСНИЙГ ХЭЛЭЛЦҮҮЛЭХ НЬ • СҮНСНИЙ ФИЛОСОФИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ • НОБЕЛИЙН ШАГНАЛТ ШАРИЛЖ • ОНОЛЫН СУРВАЛЖУУДЫГ ХАРЬЦУУЛАН ШИНЖИХҮЙ • ХҮН ГҮРЭН, АЛТАН ШҮТЭЭН, НОЁН УУЛ • СЭТГЭЛИЙГ ЭЗЭМДЭХ ПИАРЫН ТУХАЙ • АНАГААХ УХААНЫ ТҮҮХИЙН БҮТЭЭЛҮҮД • ДОМОГ АМИЛУУЛЖ ДЭЛХИЙН ДЭЭВЭРТ МОРИН ХУУР МОНГОЛ ХӨГЖМИЙГ ТУНХАГЛАСАН ЭРДЭМТЭН • МОНГОЛЧУУДЫН БАЙГАЛЬ ХАМГААЛАХ ЗАН ЗАНШИЛ, ХУУЛЬ ЦААЗ • ҮНДЭСТНИЙ БҮЖГИЙН ДЭГ ЗОХИОМЖ, ХӨДӨЛГӨӨНИЙ НЭГЖ

2  
2018

СОЁМБО ҮСГИЙН СОДОН БИЧЛЭГЭЭС ХУДА.32



## ЭНЭ ДУГААРТ

<i>Л.Болд.</i>	Чингисийн чулууны бичиг .....	3
----------------	-------------------------------	---

### СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭНИЙ АЖИЛ

<i>Д.Содномдорж.</i>	Математик загварчлал.....	18
<i>Б.Бадрах.</i>	Сэтгэлийн тухай шашны номлолыг байгалийн шинжлэх ухааны зарим онолтой холбон авч үзэх нь .....	24
<i>Р.Отгонбаатар.</i>	Соёмбо үсгийн содон бичлэгээс .....	32
<i>Э.Батзаяа, М.Бат-Орших, Б.Нэргүй.</i>	Их хэмжээний өгөгдөл ба hadoop систем .....	37
<i>Ж.Бямбасүрэн.</i>	Эрдэм шинжилгээний ажилтны ёс зүй.....	42

### ШИНЖЛЭХ УХААН, ТАНИН МЭДЭХҮЙ

<i>Л.Дашиням.</i>	Тойрон бүжгийн тухай МНТ-д үгүүлснийг хэлэлцүүлэх нь .....	49
<i>Ч.Ган-Өлзий.</i>	Сүнсний философийн тухай ойлголт .....	57
<i>О.Хонгорзул Д.Өсөхжаргал.</i>	Нобелийн шагналт шарилж .....	63
<i>Н.Энхтөр.</i>	Онолын сурвалжуудыг харьцуулан шинжихүй .....	69
<i>Ц.Батмөнх.</i>	Хүн гүрэн, алтан шүтээн, ноён уул .....	73
<i>Д.Болдхуяг.</i>	Сэтгэлийг эзэмдэх пиарын тухай.....	80

### НОМ, НОМ БҮТЭЭЛИЙН ШҮҮМЖ

<i>“Академич Ш.Болд.</i>	Анагаах ухааны түүхийн бүтээлүүд.....	88
<i>Ж.Болдбаатар.</i>	Домог амилуулж дэлхийн дээвэрт морин хуур монгол хөгжмийг тунхагласан эрдэмтэн .....	91

### СЭТГҮҮЛИЙН ЗОЧИН

<i>Ц.Нарантуяа.</i>	Монголчуудын байгаль хамгаалах зан заншил, хууль цааз.....	97
<i>Н.Наранхуар.</i>	Үндэстний бүжгийн дэг зохиомж, хөдөлгөөний нэгж.....	102

### ҮЙЛ ЯВДАЛ

Эрдэмтэдтэй санал солилцлоо.....	114
Хамтран ажиллана .....	114
Газар хөдлөлтийн асуудлаар олон улсын хурал болов.....	115
“Тал нутгийн эзэнт гүрэн - Монгол” үзэсгэлэн нээлтээ хийлээ .....	116
Монгол эрдэмтэн Ж.Дугаржавын бүтээсэн “гумины бэлдмэл” лагийн үнэрийг дарж байна .....	117
Чадварлаг боловсон хүчин бэлтгэнэ .....	118
Зүрх судасны өвчлөл, нас баралтыг бууруулна.....	118
Багш нарт зориулсан ёсзүйн сургалт боллоо .....	119
Соёл, урлагийн үндэсний зөвлөл байгуулахаар боллоо.....	120
Хаягдлаар шорлогны түлш үйлдвэрлэж байна .....	120



**СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭНИЙ АЖИЛ**

Магистр Ж.БЯМБАСҮРЭН

*/ШУА-ийн Философийн хүрээлэн/***ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ АЖИЛТНЫ ЁС ЗҮЙ**

**Хураангуй:** *Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 454 дүгээр тушаалын хавсралтаар эрдэм шинжилгээний ажилтны ёс зүйн ерөнхий дүрмийг баталсан байдаг. Уг дүрмийн хэрэгжилт болоод бодит байдалд хэрхэн бууж байгаа тухай асуудлуудыг хөндөж, шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн хэрэгжилт эрдэм шинжилгээний ажилтнуудад хэрхэн тусгалаа олж байна вэ? гэх зэрэг асуудлыг судлан шинжилж, ёс зүйн дүрэм зөрчигдөөд байгаа шалтгааныг тодруулан цаашид зөрчил, маргаан гаргахгүй байхад анхаарах санамжийг боловсруулах зорилго тавин ажиллалаа. Энэхүү зорилгынхоо хүрээнд шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн шинэчилсэн найруулга болон эрдэм шинжилгээний ажилтны ёс зүйн ерөнхий дүрмийг судлан шинжилж, зөрчигдөөд байгаа заалтуудыг тусгайлан авч үзээд цаашид анхаарч ажиллах саналыг дэвшүүлээ.*

**Түлхүүр үг:** *эрдэм шинжилгээний ажилтны ёс зүй, эрдэм шинжилгээний ажилтны ёс зүйн зөрчил, хариуцлага, сахилга бат*

Өнөө цагт нийгмийн амьдралын бүхий л салбарт тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд судалгаа



шинжилгээ, шинжлэх ухаанч хандлага маш чухлаар шаардагдах болсон байна. Хамт олон цаашлаад нийтийн дунд тулгарч байгаа асуудлуудыг хууль дүрмээр зохицуулж болох ч ёс зүйн шаардлага, үнэт зүйлсээр шийдвэрлэх асуудал бас бий. Олон нийтийг ёс суртахуунтай байлгахад чиглүүлэгч үүрэг хүлээх хүмүүсийн нэг шинжлэх ухааны салбарт ажиллаж байгаа эрдэмтэд юм. Тэгвэл нийгэмд чухал үүрэг хүлээж байгаа эрдэмтэд өөрсдөө хэрхэн ёс суртахуунтай байна вэ?

Мэдлэгийн салбар бүр чиглэл чиглэлийнхээ зорилго, зорилтод нийцсэн ёс зүйн стандартуудтай байдаг. Эдгээр стандарт нь тэдгээрийн үйл ажиллагааг зохицуулах сахилга батыг сахиулах, олон нийтийн итгэлийг бий болгоход нь тусалдаг билээ.

Шинжлэх ухаан технологийн тухай хуулийн 13.1.4-т “заасан шинжлэх ухаан, технологийн чиглэлээр гадаад улс, олон улсын байгууллагаас зохион байгуулж буй эрдэм шинжилгээний хурал, зөвлөгөөн, чуулганд оролцох, судалгааныхаа ажлын үр дүнг мэдээлэх, харилцан мэдээлэл солилцох” гэсэн заалт нь манай Философийн хүрээлэнд амжилттай мөрдөгдөж байна. Тухайлбал сургалт семинар, хурал, үзэсгэлэнд байгууллагаа



STUDIA PHILOSOPHIAE ET JURIS  
INSTITUTI PHILOSOPHIAE  
ACADEMIAE SCIENTIARUM MONGOLICI

TOMUS XXXIV FASCICULUS 1-20

# ФИЛОСОФИ, ЭРХИЙН СУДЛАЛ

◆ XXXIV БОТЪ

Улаанбаатар  
2019

## ГАРЧИГ

### Нэг. ФИЛОСОФИ

1. **Ч.Ган-Өлзий**  
*Йогачара ба квант физик* 5
2. **Д.Чулуунжав**  
*Галактикийн хувьсах орчил ба хар нүх* 13
3. **О.Болор-Эрдэнэ**  
*Экзистенциаль үзэл санааны эх сурвалжуудыг шинжлэх нь:  
түүхэн нөхцөл, арга зүй, сонгодог хэлбэрүүд* 17
4. **Б.Бадрах**  
*Физик вакуумын онолын философи тайлбар* 28

### Хоёр. УЛС ТӨРИЙН ЭДИЙН ЗАСГИЙН УХААН

5. **Б.Даш-Ёндон**  
*Азийн үйлдвэрлэлийн арга: Монголын түүхийн диалектик* 37
6. **Ц.Сүхбаатар**  
*Үндсэн хууль ба эдийн засаг* 64
7. **Б.Батхишиг**  
*Тэтгэврийн тогтолцоог шинэчлэх асуудалд* 73

### Гурав. СОЦИОЛОГИ

8. **Ц.Пүрэв**  
*Монголын нийгмийн давхраажилтыг нөөц боломжийн хандлагаар  
судлах асуудалд* 90
9. **Ц.Цэцэнбилэг, Ц.Уянга**  
*Гэр бүлийн харилцааг судлах асуудалд* 103
10. **О.Баасантогтох**  
*Арван найман насанд хүрээгүй хүүхэд хүчирхийлсэн гэмт хэрэг  
үйлдсэн хүнд ял оногдуулж буй байдал* 113
11. **В.Г.Жалсанова, Ё.Ундрал**  
*Монгол, Оросын хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн онцлог* 122
12. **Е.Аяулы**  
*Тувачуудын өрхийн амьжиргааны түвшний судалгаа  
(Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын жишээн дээр)* 129

### Дөрөв. УЛС ТӨР СУДЛАЛ

13. **Д.Баасансүрэн**  
*Хятадын улс төрийн соёл: Үндэсний онцлог* 138
14. **О.Хатанболд, Ц.Баттулга**  
*Монголын ардчиллыг ойлгохуйн үндэслэлд гарсан өөрчлөлтийн тойм  
(Ардчиллын дилемма –II)* 147
15. **Б.Оролжав**  
*Монголын ардчиллын прологи: Бид хаашаа явна!* 182
16. **О.Хатанболд, А.Хишигдаваа**  
*Өнөөгийн Монголын ардчиллын төлөв байдалд холбогдох дүгнэлт  
(Ардчиллын дилемма –III)* 193

# НЭГ. ФИЛОСОФИ

## ЙОГАЧАРА БА КВАНТ ФИЗИК

Батын Ч.Ган-Өлзий

Доктор (Sc.D), профессор

ШУА-ийн Философийн хүрээлэн, Философийн салбар

**Abstract.** The article presents the philosophy yogacara Mongolian Buddhism is one of the most correct philosophy for clarifications the process of reduction of wave packet, what is happening in leaps and bounds in the measurement of quantum physics. She believes that, in the most objective reality of real symmetry, anti-symmetry is always opposed as a violation of symmetry: symmetry as an identity, the one must somehow, sooner or later be broken, and the broken symmetry as anti-symmetry must sooner or later be restored in another world of the structure and structural organization of the Universe.

Understanding what happened at the earliest stage of the Universe development is fundamentally connected with quantization of all fields, including gravity. The construction of the wave function of the Universe leads to a seemingly paradoxical conclusion about the simultaneous existence of parallel worlds as independent “branches” of the evolving Universe. In this case, the “destruction” of unnecessary branches does not occur, and all the terms in the mathematical decomposition of the wave function are equal. In each world (branch) the observer sees quite certain result of measurement. For example, when considering the EPR of the paradox from the standpoint of a multi-world interpretation, the wave function consists of two branches: two parallel worlds are obtained, in each of which the results of measurements made by two observers are correlated. If the first observer discovers that the spin of the first particle is directed upwards, the second discovers that the spin of the second particle is directed downwards and Vice versa. This correlation is the result of the fact that in the past particles 1 and 2 interacted, their wave functions “intertwined” and gave a common state vector.

**Түлхүүр үгс:** долгионы багц, редукци, шүтэн барилдахуй, “тодорхойгүй учир зүй”, нэгэн цогц чанар, хар нүх, “олонертөнц”

Материйн суурь үндсэн түвшид философийн үндэслэлийн парадигмын үзэл санаа өөрчлөгдөж, маш нарийн бөөмсийн философи хэтчавхдасны философи, хэттэгшхэм ба хэтэсрэг тэгшхэмт онолоор солигдож байна. Эгэл бөөмсийн нарийн нэгж шинж ба тодорхой байрлал байхгүй болсон ( $m_{p1} = 1019$  ГэВ гэдэг Планкийн хэмжүүрийн чанад дахь) хэтчавхдаснуудыг физикийн суурь бодит байдал гэж үзэх болов. Шинжлэх

ISSN 2220-959X

# PRS

Philosophy,  
Religious  
Studies

---

Official Journal of the National University of Mongolia

VOLUME 21 (516)



## АГУУЛГА

## ФИЛОСОФИ

1	Ш. Ганхуяг Ж. Бямбасүрэн	НЭЭЛТТЭЙ НИЙГМИЙН ТУХАЙ К.ПОППЕРЫН ҮЗЛИЙГ ШИНЖИЛСЭН НЬ	9-14
2	Р. Дарьхүү С. Хишигтогтох	ТОТЕМ ШҮТЛЭГ БА ХОРИО ЦЭЭРИЙН ТУХАЙ З.ФРЕЙДИЙН ПСИХОАНАЛИТИК БАРИМТЛАЛ	15-28
3	Ч. Ган-Өлзий	ХАОСЫН ТАЙЛАЛЫН МЭДЭГДЭХҮҮНИЙ БИЛИГ	29-38

## ШАШИН СУДЛАЛ

1	Т. Чулуун-Эрдэнэ	БАРУУН ОРОНД БУРХНЫ ШАШИН ТОРГОНЫ ЗАМААР ДАМЖИН НЭВТЭРСЭН ТОВЧ ТҮҮХ	41-49
2	Д. Ундрах	БНХАУ-ЫН ШАШНЫ ТАЛААР АВЧ ЯВУУЛЖ БУЙ БОДЛОГО	50-57
3	С. Янжинсүрэн Ц. Эрдэнэцэцэг	ДОЛООН ӨВГӨН ОДНЫ ШҮТЛЭГИЙГ БИЧГИЙН ЭХ СУРВАЛЖИД ТУЛГУУРЛАН ШИНЖЛЭХ НЬ	58-68
4	С. Янжинсүрэн О. Бумдарь	ЖАЛХАНЗ ХУТАГТ ДАМДИНБАЗАРЫН ХОЙД ДҮРИЙГ ТОДРУУЛСАН ТУХАЙ ЗАРИМ МЭДЭЭ	69-73
5	С. Янжинсүрэн Ц. Гантөмөр	ЖОНАНБЫН ЁСНЫ ОНЦЛОГИЙГ ТОДОРХОЙЛОХ НЬ	74-81
6	М. Гантуяа П. Батбаатар	ЗУУРДЫН ХАВЦАЛААС ГЭТЭЛГЭХИЙН ЗАЛБИРАЛ – АЮУЛААС АВРАГЧ БААТАР ХЭМЭЭХ СУДРЫН БҮТЭЦ, АГУУЛГЫН ШИНЖИЛГЭЭ	82-94
7	Ц. Пүрэвсүрэн	МОНГОЛЫН БАРУУН БҮС НУТАГ ДАХЬ БАПТИСТ ШАШНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ҮНЭЛЭХ НЬ	95-105
8	Д. Лувсанжамц	МОНГОЛ, АМЕРИК ХОЁР УЛСЫН ХАРИЛЦААНД МОНГОЛ ЛАМ НАРЫН ОРУУЛСАН ХУВЬ НЭМЭР	106-119
9	М. Отгонбаяр Ж. Пүрэвдорж	ХРИСТИЙН ШАШНЫ ЦУГЛААН БА ДУУЛАХ ЗАН ҮЙЛ	120-128
10	Л. Алтанзаяа	ЭРДЭНЭ ШАНЗУДБА ЛУВСАНГОНЧИГИЙН ТУХАЙ	129-138
11	М.Золзаяа	ЧИНГИС БОГДЫН ЗОХИОСОН СУРАГЧ АРДЫН УХААНЫГ ХӨГЛӨХ ОЮУНЫ ТҮЛХҮҮР (ХӨРВҮҮЛЭГ)	139-148

## НЭЭЛТТЭЙ НИЙГМИЙН ТУХАЙ К.ПОППЕРЫН ҮЗЛИЙГ ШИНЖИЛСЭН НЬ

Ш.Ганхуяг (Ph.D)

Ж.Бямбасүрэн (магистр)

ШУА-ийн Философийн хүрээлэн

**Түлхүүр үг:** историцизм, историзм, хаалттай нийгэм, нээлттэй нийгэм, ардчилсан нийгэм

**Товч утга:** Нээлттэй нийгмийн тухай К.Попперийн үзлийг шинжлэхэд А.Бергсоны "хаалттай нийгэм" гэсэн ойлголтыг судлах шаардлагатай болдог юм. Учир нь хаалттай нийгмийн онцлог шинжийг ойлгосноор нээлттэй нийгмийн давуу тал, онцлогийг мэдэх бололцоотой. К.Поппер "нээлттэй нийгэм"-ийн гол шинжийг тодорхойлохдоо "ийм нийгэм бол иргэдийнхээ бие даасан, бүтээлч, шүүмжлэлт үйл ажиллагааны үр дүн байдаг" гэжээ. Тиймээс нийгмийн хөгжил нь тусгай объектив хууль, зүй тогтлоор тодорхойлогдохгүй хэмээн К.Поппер үзсэн юм. Ингэж нээлттэй нийгмийн шинжийг тодруулахдаа тэрээр историзм, историцизм хэмээх хоёр ойлголтын зөрүүг тайлбарласан байдаг. Өгүүлбээс "историзм бол юмыг түүхэн ёсоор үзэхийг, өөрөөр хэлбэл түүхчлэн үзэхийг шаарддаг, энэ чанараараа шинжлэх ухааны хувьд зөв зүйтэй. Харин историцизм бол өөр юм. Историцизм нь нийгмийн ухаан болбоос ирээдүйг урьдчилан харах зорилгоор түүхийн хуулиудыг нээх ёстой гэж үздэг. Историцизмын ёсоор урт удаан хугацааны урьдчилан харахуйг гаргавал энэ нь шалгалт, няцаалтад өртөхгүй, иймд үл гүйцэлдэх, зөгнөн мөрөөдсөн шинжтэй болно. Ийм зөгнөл мөрөөдөл шинжлэх ухааны урьдчилан харахуйтай огт тохирохгүй ажээ. Ийнхүү нээлттэй нийгмийн тухай үзлээ тэрээр "Нээлттэй нийгэм, түүний дайснууд", "Түүхчлэх үзлийн гуйланчлал", "Диалектик гэж юу вэ?", "Марксын зөгнөл, Марксын ёс зүй" гэх мэт олон зохиол бүтээлүүддээ тодоор илэрхийлсэн байдаг.

Философийн түүхэнд "хаалттай нийгэм" гэдэг нэр томъёог анх хэрэглэсэн эрдэмтэн бол А.Бергсон билээ. Тэрээр нийгмийг амьтанчлах арга зүйн үүднээс тайлбарласан байдаг. Ингэж тайлбарлахдаа үүр бутар амьдардаг зохион байгуулалт бүхий зөгий, шоргоолж, хүн төрөлхтний хамтлаг зэргийг нийтэд нь "нийгэм" хэмээсэн байдаг.<sup>1</sup> Тэрээр: "нийгэм бол хаалттай ба нээлттэй хоёр хэв маягт хуваагддаг гээд, тэдгээр хэв маяг тус бүрт шашин, ёс суртахуун хоёрын статик ба динамик гэсэн хоёр өөр хэв маяг тохирдог" тухай өгүүлсэн байдаг.

"Хаалттай нийгэм нь хаалттай ёс суртахуун, статик шашинд үндэслэдэг бол нээлттэй нийгэм нь динамик шашин, нээлттэй ёс суртахуунд суурилдаг" хэмээн А.Бергсон тодорхойлжээ.

А.Бергсоны тайлбарласнаар хаалттай ёс суртахуун гэдэг бол нэг үгээр "дарамт" юм. Учир нь, ийм хаалттай нийгэмд хүн өөрийгөө амьд биеийн өчүүхэн

<sup>1</sup> Анри Бергсон. Два источника морали и религии. М., 1994, с.114-д энэ тухай үзнэ үү.

DOI: <https://doi.org/10.23670/IRJ.2019.83.5.035>

**ПРИНЦИПЫ ГУМАНИЗМА ПО ОТНОШЕНИЮ К ПРИРОДЕ КАК ФАКТОР УСТОЙЧИВОГО РАЗВИТИЯ**  
Научная статья

**Пурэвдорж М.\***

Институт философии Академии наук Монголии, Улаанбаатар, Монголия

\* Корреспондирующий автор (emiga12[at]yahoo.com)

**Аннотация**

В статье автор развивает мысль о том, что гуманизм в традиционном отношении монголов к природе есть необходимый фактор устойчивого развития. В наше время вызывает тревогу экологический дисбаланс и экологические угрозы. В связи с этим появилась необходимость выработать общие ценности для глобального сотрудничества. Для этого нужно осмыслить и осознать, что природа является частью нас самих.

**Ключевые слова:** гуманизм, устойчивое развитие, природа, мораль, традиция.

**PRINCIPLES OF HUMANITY WITH REGARD TO NATURE AS FACTOR OF SUSTAINABLE DEVELOPMENT**  
Research article

**Purevdorzh M. \***

Institute of Philosophy of the Academy of Sciences of Mongolia, Ulaanbaatar, Mongolia

\* Corresponding author (emiga12[at]yahoo.com)

**Abstract**

The author in this article develops the idea that humanity in the traditional attitude of the Mongols to nature is a necessary factor for sustainable development. Environmental, imbalance and other threats cause anxiety in our time. In this regard, there is a need to develop common values for global cooperation. To do this, one needs to think over and realize that nature is a part of ourselves.

**Keywords:** humanism, sustainable development, nature, morality, tradition.

Наряду с глобализационными процессами и интенсивным развитием науки и техники остро стоят вопросы экологии и морали. В этой связи необходимо изучить общие ценности человечества для решения этих вопросов. Одной из этих общих ценностей являются принципы гуманизма в традиционных культурных ценностях. Принципы гуманизма основаны на человечности, индикаторы развития связаны с человеческой деятельностью и главной целью человечества является его единство. Гуманизм включает в себя понятие от том, что люди должны воспринимать природу не только как среду обитания, а как неотделимая часть нас самих, и поэтому нужно рассматривать мир как единое целое.

Учёный Ч.Гап-Улзий писал: “в онтологии духовной культуры обязательно должно быть понятие о ценности как основы развития для познания качества. Иначе говоря, чтобы понять признаки осознания ценностей, которые являются сущностью духовной культуры, нужно выработать качественное значение этих ценностей” [1, С.10]. Это является необходимым для осмысления устойчивого развития как позитивной ценности и в осознании ценностей гуманных отношений между их членами, основанные на общей морали. Поэтому мы концентрируемся на сегодняшний день не на вещи, которые понимаются под понятием гуманизма, а на качестве этого значения [2, С. 1].

“Во второй половине XX века были предприняты попытки поиска новой модели миропорядка, способной привести глобальную систему к качественно новому состоянию. Результатом совместных и целенаправленных усилий мирового сообщества, действовавшего на основании мандата ООН, с привлечением авторитетных экспертов и общественности различных стран, стала разработка стратегии устойчивого развития (УР), акцент в которой сделан на поиск принципов устройства общества с учетом общечеловеческой проблематики, и конкретных согласованных действий, направленных на ее реализацию” [3, С. 1(2)]. По вопросам устойчивого развития в 1992 году на встрече высшего уровня ООН в Рио-де-Жанейро по теме “Окружающая среда человека и её развитие” была утверждена “Программа развития-21” и другие документы, и была выдвинута модель “Устойчивого развития”.

Устойчивое развитие было определено как модель долгосрочного развития, при котором не ограничивая потребностей и возможностей следующих поколений, удовлетворить потребности нынешнего поколения, оценить человеческий фактор и адаптироваться к окружающей среде [1].

В традиционном мировоззрении монголов человек должен потреблять все в разумных масштабах, почитать жизнь обитателей природы, сохранять и передавать богатство природы следующим поколениям, которые можно найти во многих нравовучениях.

Исходя из принципов гуманизма жизнь людей, их счастье и всё хорошее на земле в большой степени связано с окружающей средой и мы несём ответственность перед следующими поколениями и должны оставить и сохранить после себя условия создания благоприятной жизни.

В нашем обществе такие проблемы как чрезмерное потребление, свободная продажа, переселение, изгнания, изменение климатических условий, загрязнение окружающей среды, проблемы виртуального общения в сетях приводит к размыванию принципов гуманизма и пренебрежению человеческими ценностями в нашей повседневной жизни. “Обеспечение устойчивого развития человечества “sustainable development” является для мирового сообщества самой значимой проблемой” [2, С. 12-14].

\* Тус орос хэл дээрх өгүүлэл нь Международный научно-исследовательский журнал-д хэвлэгдсэн бөгөөд зохиогчид уг сэтгүүлийн онлайн хувилбар буй. Google хайлтаар ороод чөлөөтэй унших боломжтой.



ISSN 2220-959X

# PRS

Philosophy,  
Religious  
Studies

---

Official Journal of the National University of Mongolia

VOLUME 21 (516)



## АГУУЛГА

## ФИЛОСОФИ

1	Ш. Ганхуяг Ж. Бямбасүрэн	НЭЭЛТТЭЙ НИЙГМИЙН ТУХАЙ К.ПОППЕРЫН ҮЗЛИЙГ ШИНЖИЛСЭН НЬ	9-14
2	Р. Дарьхүү С. Хишигтогтох	ТОТЕМ ШҮТЛЭГ БА ХОРИО ЦЭЭРИЙН ТУХАЙ З.ФРЕЙДИЙН ПСИХОАНАЛИТИК БАРИМТЛАЛ	15-28
3	Ч. Ган-Өлзий	ХАОСЫН ТАЙЛАЛЫН МЭДЭГДЭХҮҮНИЙ БИЛИГ	29-38

## ШАШИН СУДЛАЛ

1	Т. Чулуун-Эрдэнэ	БАРУУН ОРОНД БУРХНЫ ШАШИН ТОРГОНЫ ЗАМААР ДАМЖИН НЭВТЭРСЭН ТОВЧ ТҮҮХ	41-49
2	Д. Ундрах	БНХАУ-ЫН ШАШНЫ ТАЛААР АВЧ ЯВУУЛЖ БУЙ БОДЛОГО	50-57
3	С. Янжинсүрэн Ц. Эрдэнэцэцэг	ДОЛООН ӨВГӨН ОДНЫ ШҮТЛЭГИЙГ БИЧГИЙН ЭХ СУРВАЛЖИД ТУЛГУУРЛАН ШИНЖЛЭХ НЬ	58-68
4	С. Янжинсүрэн О. Бумдарь	ЖАЛХАНЗ ХУТАГТ ДАМДИНБАЗАРЫН ХОЙД ДҮРИЙГ ТОДРУУЛСАН ТУХАЙ ЗАРИМ МЭДЭЭ	69-73
5	С. Янжинсүрэн Ц. Гантөмөр	ЖОНАНБЫН ЁСНЫ ОНЦЛОГИЙГ ТОДОРХОЙЛОХ НЬ	74-81
6	М. Гантуяа П. Батбаатар	ЗУУРДЫН ХАВЦАЛААС ГЭТЭЛГЭХИЙН ЗАЛБИРАЛ – АЮУЛААС АВРАГЧ БААТАР ХЭМЭЭХ СУДРЫН БҮТЭЦ, АГУУЛГЫН ШИНЖИЛГЭЭ	82-94
7	Ц. Пүрэвсүрэн	МОНГОЛЫН БАРУУН БҮС НУТАГ ДАХЬ БАПТИСТ ШАШНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ҮНЭЛЭХ НЬ	95-105
8	Д. Лувсанжамц	МОНГОЛ, АМЕРИК ХОЁР УЛСЫН ХАРИЛЦААНД МОНГОЛ ЛАМ НАРЫН ОРУУЛСАН ХУВЬ НЭМЭР	106-119
9	М. Отгонбаяр Ж. Пүрэвдорж	ХРИСТИЙН ШАШНЫ ЦУГЛААН БА ДУУЛАХ ЗАН ҮЙЛ	120-128
10	Л. Алтанзаяа	ЭРДЭНЭ ШАНЗУДБА ЛУВСАНГОНЧИГИЙН ТУХАЙ	129-138
11	М.Золзаяа	ЧИНГИС БОГДЫН ЗОХИОСОН СУРАГЧ АРДЫН УХААНЫГ ХӨГЛӨХ ОЮУНЫ ТҮЛХҮҮР (ХӨРВҮҮЛЭГ)	139-148

## ХАОСЫН ТАЙЛАЛЫН МЭДЭГДЭХҮҮНИЙ БИЛИГ

Батын Ч.Ган-Өлзий (Sc.D)


Эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан

Философийн хүрээлэн. ШУА

**Түлхүүр үгс:** *Философи, астрофизик, эгэл бөөмсийн физик болон космологийн шүтэн барилдахуй, хаос, эмхгүй ба эмх журам, нэгэн цогц ба хоосон чанар.*

Философи анх үүсэхдээ огторгуйн тухай, орчлон ертөнц хэрхэн хаос буюу хоосон чанараас үүссэн болон түүний бүтэц ба бүрэлдэн буй болсон хамгийн жижиг тоосны тухай ухаан л байлаа. Философийн нэг ч том дэг сургууль, нэг ч агуу философич ертөнцийн байгууламж, огторгуй ба Орчлонгийн мөн чанарыг судлаж ойлгохоос холуур өнгөрч байгаагүй. Философи хөгжиж ирсэн олон мянган жилийн түүх бүхэлдээ Орчлон, түүний үүсч хөгжсөн хууль зүй тогтлыг тайлбарлах, энгүй энэ дайдад хүмүүний ахуйн эзлэх байр суурь, үүргийг ойлгох оролдлого байв. Эдүгээ шинжлэх ухаан эгэл бөөмсийн харилцан үйлчлэлийн хүчний ачаар матери физик чанаргүй болдог конфайнмент үзэгдлээс нэгж нь тэрбумээр хэмжигддэг од гараг, хар нүх хүртэлх матери, орон, хугацаа ба бүтэц, хөдөлгөөнийг тайлбарлаж байна. Эгэл бөөмсийн физик, астрофизик ба космологийн орчин үеийн мэдлэг, харьцангуйн болон квант онол, хаосын үзэл баримтлалын шүтэн барилдахуй л хүний оюун сэтгэлгээг бүх түүхийн турш догдлуулж ирсэн философи, ертөнцийг үзэх үзлийн тулгамдсан асуудалд үнэн зөв хариу өгч чадна. Өөрчлөн шинэчлэгч философи шинжлэх ухааны орчин үеийн ололт амжилтад тулгуурлан ертөнцийн тухай түгээмэл онолыг боловсруулдаг төдийгүй ертөнцийн байгууламж дахь хүний ахуй, сэтгэлгээний ерөнхий зүй тогтлыг тайлбарладаг. Чухам үүнд л философийн үндсэн зориулалт, ертөнцийн мөн чанарыг таньж мэдэх, түүн дэх хүмүүний ахуйн утгыг ойлгох, тайлах явдал оршдог.

Өнгөрсөн зуунуудын гол төлөв европ төвт үзэл ба сонгодог физикийн механик төсөөлөлд суурилж ирсэн стратегийн сэтгэлгээ философийн инновацид хангалттай орон зай гаргаж чадахгүй болжээ. Философио шинээр ухан ойлгохын тулд хэрэглэж байгаа судалгааны аргаа өөрчлөх зайлшгүй шаардлага үүсэв. Философи болон шинжлэх ухааны шинэ парадигмуудыг шүтэн барилдуулж, өөрчлөн байгуулагч төсөөллийг эш болгох аваас бид илүү үр дүнтэй стратегийн зарчмуудыг олж харж чадах болно. Зөвхөн философийг өөрийг нь хөгжүүлж, түүнийг шүүмжлэгч, өөрчлөгч шинжлэх ухаан болгоод зогсохгүй орчин үеийн бүх шинжлэх ухаануудын зааг дээр тэднийг хооронд нь зуучлан ажиллаж, ололт амжилтыг нь ойлгон тайлбарлах зорилт тулгарч ирлээ. Ийм философи, философдох аргын нэг нь тайлал зүйн мэдэгдэхүүний билиг мөн. Үүнийг үндэс болгон хамгийн жижиг ба хамгийн том юмны тухай шинжлэх ухааны мэдлэгийн бүрэн төгс шүтэн барилдахуй, суурь бүтэц эцэс төгсгөлгүйн бүрэн төгс шүтэн барилдахуйг тайлбарлах нэг өнцөг нь хаосын тайллын мэдэгдэхүүний



К.И.Померанцев «Лувсан хуурч»  
Зотон, тос. 1932 он.  
Улаанбаатар хотноо Театрын музейд  
хадгалагдаж буй

# ШИНЖЛЭХ УХААН АМЬДРАЛ

## ШИНЖЛЭХ УХААН - ТАНИН МЭДЭХҮЙН СЭТГҮҮЛ

МОНГОЛ УЛСАД САЛХИНЫ ЭРЧИМ ХҮЧИЙГ АШИГЛАХ БОЛОМЖ \* МОНГОЛ ОЮУТНЫ УР  
ЧАДВАРЫН ЧИГ ХАНДЛАГЫН СУДАЛГАА \* ТӨВ АЗИЙН УС ХАГАЛБАР \* АЛТАЙН УРИАНХАЙН  
УЛАМЖЛАЛТ ЭСГИЙГ ӨВЛӨН ХАДГАЛЖ БУЙ БАЙДАЛ \* МОНГОЛД АНУ-ИЙН ХУДАЛДАА,  
ЭДИЙН ЗАСГИЙН АШИГ СОНИРХОЛ БУЙ БОЛЖ ӨРГӨЖСӨН НЬ \* НИЙГМИЙН ТОГТВОРТОЙ  
ХӨГЖИЛ БА ХУВЬ ХҮНИЙ ЁС СУРТАХУУНЫ УХАМСАР \* ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ БА ШАШНЫ  
ТУХАЙ ОРЧИН ҮЕИЙН ФИЛОСОФИ АСУУДАЛД \* ХАЙПЕРСПЕКТРИЙН ТАНДАН СУДЛАЛЫН  
ОРЧИН ҮЕИЙН ЧИГ ХАНДЛАГА \* ДАРАМБАЗАРЫН СЭНГЭЭ ГЭВШ \* МӨСӨН ШАГАЙН ХАРВАА  
\* НЭГЭН САНААЧЛАГЫН ТҮҮХ \* УРАН ЗОХИОЛ ДАХЬ ТЭМЭЭНИЙ ДҮРСЛЭЛИЙН ХАРЬЦУУЛАЛ

4  
2019

СЭТГЭЛ ХЭМЭЭХ ҮГИЙН УТГА, ХЭРЭГЛЭЭ Х.18



## ЭНЭ ДУГААРТ

### СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭНИЙ АЖИЛ ҮР ДҮН

<i>Д.Содномдорж, П.Товуудорж.</i>	Монгол улсад салхины эрчим хүчийг ашиглах боломж .....	3
<i>К.Шиничиро, К.Акиёши, Б.Оюунцэцэг.</i>	Монгол оюутны ур чадварын чиг хандлагын судалгаа .....	10
<i>Ц.Эрдэнэзаяа, Д.Энхчимэг.</i>	Сэтгэл хэмээх үгийн утга, хэрэглээ .....	18
<i>Ч.Нармандах.</i>	Төв Азийн ус хагалбар .....	25
<i>Х.Едилхан.</i>	Алтайн урианхайн уламжлалт эсгийг өвлөн хадгалж буй байдал .....	29
<i>Д.Уламбаяр.</i>	Монголд АНУ-ийн худалдаа, эдийн засгийн ашиг сонирхол буй болж өргөжсөн нь .....	36

### ШИНЖЛЭХ УХААН, ТАНИН МЭДЭХҮЙ

<i>Ж.Бямбасүрэн.</i>	Нийгмийн тогтвортой хөгжил ба хувь хүний ёс суртахууны ухамсар .....	59
<i>С.Соёлмаа.</i>	Тогтвортой хөгжил ба шашны тухай орчин үеийн философи асуудалд .....	67
<i>А.Мөнх-Эрдэнэ, Б.Нэргүй.</i>	Хайперспектрийн тандан судлалын орчин үеийн чиг хандлага .....	75
<i>Р.Ринченбазар.</i>	Дарамбазарын Сэнгээ гэвш .....	82
<i>Т.Ядамсүрэн.</i>	Мөсөн шагайн харваа .....	91

### ДҮРСАМЖ

<i>А.Жамбал.</i>	Нэгэн санаачлагын түүх .....	95
------------------	------------------------------	----

### СЭТГҮҮЛИЙН ЗОЧИН

<i>Алтанчулуу.</i>	Уран зохиол дахь тэмээний дүрслэлийн харьцуулал .....	105
--------------------	---	-----

### МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

Төрийн ордонд заллаа .....	116
Нэрэмжит танхимын нээлт боллоо .....	116
Гадаад гишүүнээр сонгогджээ .....	118
Шилдэг судлаачдыг тодрууллаа .....	118
Шилдгүүд тодорлоо .....	120

## ШИНЖЛЭХ УХААН, ТАНИН МЭДЭХҮЙ

Магистр Ж.БЯМБАСҮРЭН

ШУА-ийн Философийн хүрээлэнгийн ЭША

### НИЙГМИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ БА ХУВЬ ХҮНИЙ ЁС СУРТАХУУНЫ УХАМСАР\*

#### Хураангуй:

“Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал – 2030” нь нийгэм, эдийн засаг, экологийн гурван тулгуурт үзэл баримтлал дээр тулгуурлан батлагдсан байдаг. Нийгмийн тогтвортой хөгжлийн хүрээнд хүн ам зүйн бүтэц, эрүүл мэнд, боловсрол, соёл, шинжлэх ухааны хөгжлийн төлөв байдал, дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ, хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдлийн түвшин, нийгмийн халамж, хамгаалал гэх мэт олон асуудлыг ярьж болно. Эдгээрийн хэм хэмжээг зохист түвшинд барьж хөгжүүлэхэд иргэн бүрийн оролцоо, идэвхи санаачлага хамгаас чухал. Хүмүүс хоорондын харилцаан дээр нийгэм суурилдаг учраас нийгмийн тулгамдаж буй асуудал эцэстээ хүний өмнө тулгарч буй бэрхшээл юм. Иймийн тулд уг илтгэлээрээ нийгэмд үүсээд байгаа зохисгүй үйлдэл, гэмт хэрэг зэрэг сөрөг үзэгдлүүд хувь хүний ёс суртахуунтай шууд хамааралтай болохыг тодорхойлж, үүнийг даван туулах гарц шийдлийг “ёс зүйн



боловсрол” мөн гэсэн санаагаа илэрхийллээ.

**Түлхүүр үг:** гэрийн хүмүүжил, төлөвшил, хандлага, ёс зүйн боловсрол

Энэхүү илтгэлээрээ өнөөгийн хүн төрөлхтний хөгжил нь “тогтвортой хөгжил”

хэмээгээд түүнд боловсрол нь нийгмийн тогтвортой хөгжлийн баталгаа мөн гэж тунхагласан бодлогын баримт бичгийг гол болгож албан болон албан бус боловсролоор олговол зохих “ёс зүйн боловсрол”-ыг хамгийн чухал юм гэсэн санаагаа гаргахыг хичээлээ.

2015 оны 9 дүгээр сард НҮБ-ийн 193 орны төрийн тэргүүд Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, зорилгуудыг санал нэгтгэйгээр баталж 2016 оны 1 дүгээр сарын нэгнээс албан ёсоор дэлхий нийтээр хэрэгжиж эхэлсэн билээ. Үүнээс урд буюу 2000 онд НҮБ-ийн ерөнхий асемблейн 189 орны төрийн тэргүүн оролцсон хуралдаанаар “Мянганы тунхаглал”-ыг гаргаж 2000-2015 онд хийж гүйцэтгэх зорилтуудыг баталсан байдаг нь МУ-д 2005 онд “Мянганы хөгжлийн зорилт”, 2008 онд

\* Засгийн газрын тохируулагч агентлаг Үндэсний хөгжлийн газраас зохион байгуулсан “Монголын хөгжлийн философи” сэдэвт хуралд тавьсан илтгэл.

## ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ИЛТГЭЛҮҮД

дэлхийн философийн өдөр - 2018



### ОЛОН СОЁЛЫН ХҮРЭЭНД ЭКОЛОГИ, ШУДАРГА ЁС, ЭНХ ТАЙВНЫ ҮЙЛСЭД ХАМТРАН АЖИЛЛАХ ФИЛОСОФИ

*Эрдэм шинжилгээний хэлэлцүүлгийн эмхэтгэл*

Улаанбаатар 2018

## ГАРЧИГ

<b>ӨМНӨХ ҮГ</b>	5
<b>ЮНЕСКО-ИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ ОДРИ АЗУЛЭЙГЭЭС ИРҮҮЛСЭН ИЛГЭЭЛТ</b>	7
<b>НЭЭЛТИЙН ҮГ</b>	9
<b>Д.ДОРЖГОТОВ.</b> Соёл иргэншлийн ба экологийн хямрал	12
<b>Л.ХАЙСАНДАЙ.</b> Чингис хааны төрийн алтан аргамжийн бодлого: Дайтах ба найрамдахын тухайд	23
<b>Л.ДҮГЭРЖАВ.</b> Антарктидын цаг уурын өөрчлөлтүүд	32
<b>Б.ПҮРЭВСҮРЭН.</b> Нийгмийн экологи ба олон соёлт нөхцөл байдал	44
<b>Р.ДАРЬХҮҮ.</b> Экологийн ёс зүйн асуудалд	52
<b>Ч.ГАН-ӨЛЗИЙ.</b> Олон соёлын хүрээнд шударга ёсны хямралын асуудлыг хамтран ярилцах дискурс	71
<b>С.СОЁЛМАА.</b> Шударга ёс ба иргэний нийгмийн зарим асуудлыг үнэлэмжийн философийн үүднээс авч үзэх нь	82
<b>Ц.БАТЦЭРЭН.</b> Бид хэн бэ?	97
<b>Г.МЭНД-АМАР.</b> Эртний үеийн сэтгэгчидийн байгал орчны талаарх философийн үзэл баримтлалууд	106
<b>Ж.БЯМБАСҮРЭН.</b> Орчин цагийн монгол хүний хандлагыг эргэцүүлэх нь	120
<b>ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН САНАЛ ХҮСЭЛТ</b>	124
<b>ХААЛТЫН ҮГ</b>	131
<b>ХЭЛЭЛЦҮҮЛГЭЭС ГАРСАН ҮР ДҮН, ЗӨВЛӨМЖ</b>	134



## НИЙГМИЙН ЭКОЛОГИ БА ОЛОН СОЁЛТ НӨХЦӨЛ БАЙДАЛ

Б.Пүрэвсүрэн

Доктор (Ph.D), дэд профессор

Түлхүүр үг: соёл, экологи, нийгмийн экологи, соёлын олон янз байдал, олон соёлт нөхцөл, хүлцэмж, тогтвортой хөгжил, экологийн соёл,

Соёл бол тогтвортой хөгжлийг хангагч чухал зүйл. Тогтвортой хөгжлийг хангахын тулд уугуул иргэдийн соёлын олон янз байдал, илэрхийллийг хөндөхгүйгээр хөгжлийн үзүүлэлтүүдийг хангах нь нэн тэргүүний зарчим болдог.

2001.11.02-нд НҮБ-н Ерөнхий хуралдаанаар Соёлын олон янз байдлын талаарх ЮНЕСКО-н түгээмэл тунхагийг<sup>1</sup> хэлэлцэн баталсан бөгөөд тунхагийн агуулга нь “эрх” “эрх чөлөө” “хөгжил” “плюрализм” зэрэг хүний ахуйн түгээмэл шинж тэмдэгийн өөрчлөлтийг уриалсан чиглэлтэй байдаг. Соёлын олон төрөл зүйл нь хүн төрөлхтний нийтлэг өв, соёлын олон янз байдлаас соёлын олон ургальч үзэлд шилжих нь, соёлын олон янз байдал нь хөгжлийн хүчин зүйл болдог гэх зэргээр тунхагийн ерөнхий заалдууд эхэлдэг.

Ийнхүү зааснаараа цаг хугацаа, орон зайд хүний ахуйн эзлэх байр суурь, тодруулбал өнөөгийн хүн төрөлхтөний стандарт зан төлөв, амьдрах хэв маяг, зонхилох соёлын зохилдолгоот нөхцөл байдлыг заах логик бүхий байдалтай болдог. Энэ байдал нь наанадаж барууны онол номлол буюу западнизмаар соёлын олон янз байдал болон олон соёлт нөхцөл мөр зэрэгцэн орших тулгуур болсон хүлцэмжийг /толерантность/ шаарддаг.

Биологийн олон янз байдал амьд байгалийн хувьд, хүн төрөлхтөний хувьд соёлын олон янз байдал нь зайлшгүй чухал шинжтэй хэмээн тунхагд заасан байдаг. Үүнээс үзвэл био-соёлын олон янз байдал нь өнөөгийн экосистемийн оршин тогтнол, тодруулбал нийгмийн экологийн хувьд чухал судлагдахуун, анхаарах сэдэв болох нь дамжиггүй байна.

<sup>1</sup> [http://www.un.org/ru/documents/decl\\_conv/declarations/cultural\\_diversity.shtml](http://www.un.org/ru/documents/decl_conv/declarations/cultural_diversity.shtml)  
2018.11.11:

## ШУДАРГА ЁС БА ИРГЭНИЙ НИЙГМИЙН ЗАРИМ АСУУДЛЫГ ҮНЭЛЭМЖИЙН ФИЛОСОФИЙН ҮҮДНЭЭС АВЧ ҮЗЭХ НЬ

*Доктор (Ph.D) С.Соёлмаа  
ШУА-ийн Философийн хүрээлэн*

**Түлхүүр үг:** чин эрхэмнэл, хэм хэмжээ, ач холбогдол, объект, байгаль, ёстой ба хүссэн зорилго

**Хураангуй:** Илтгэлд үнэлэмжийг субъект-объект гэсэн үнэлэжийн сонгодог философийн үүднээс авч үздэг хандлагыг шүүмжилж, субъект-субъектийн харилцаанд тогтолцооны үүднээс авч үздэг орчин үеийн зарим философийн гол санааг дэвшүүлж, улмаар эдгээр философийн үүднээс орчин үеийн монголын иргэний нийгмийн шударга байдлыг авч үзсэн юм. Гол санаа нь хэдийгээр монгол улсын үндсэн хуульд иргэний ардчилсан хүмүүнлэг нийгмийн цогцлоон байгуулна хэмээн заасан боловч бодит байдал дээр монгол иргэнийхээ, хүнийхээ чөлөөт хүслийг хэм хэмжээ болох эрх зүй, хуульд сайн тусгаж өгөхгүй байгааг шүүмжилж, гарах гарцыг дэвшүүлсэн юм. Монголын эрх зүй, хуулийн тогтолцоо нь шийтгэдэг бус, харин иргэдийн санаа бодол, хүсэл сонирхлыг харгалзан үзсэн ёс суртахуунт шинжтэй хууль байх нь дээрх асуудлыг шийдэх гарц юм гэсэн ерөнхий дүгнэлтийг хийсэн юм.

Орчин үеийн хүн юуг хамгийн үнэт зүйлээ гэж үнэлж байна вэ? гэсэн асуулт нь энгийн мэт хэдий ч хүний өмнө тулгарч байдаг хамгийн чухал асуудлын нэг байдаг. Үнэлэмж, үнэт зүйлийг утга санаа, утга учир гэсэн хамгийн өргөн ойлголтоор нь авч үзэх юм бол хүний төдийгүй аливаа соёлын онцлогийг авч үзэх, хадгалан хамгаалахад энэ соёлыг тээгч хүнийх нь үнэлэмжийн асуудлыг хөндөх нь зайлшгүй шаардлагатай зүйл юм.

Оросын философич Г.П.Выжлецов «Соёлын философи мэдлэгийн тогтолцоон дахь соёлын аксиологи» хэмээх өгүүлэлдээ «... соёлыг юу гэж ч ойлгосон түүний ямар ч төрөл зүйл, түвшингийн анхдагч эхлэл гэсэн утгаараа үнэлэмж нь аливаа ард түмэн, нийгэм, соёлын дотоод үндэс, цөм нь болж, улмаар аливаа

## ОЛОН СОЁЛЫН ХҮРЭЭНД ШУДАРГА ЁСНЫХЯМРАЛЫН АСУУДЛЫГ ХАМТРАН ЯРИЛЦАХ ДИСКУРС

*Доктор (Sc.D), профессор Батын Ч. Ган-Өлзий  
ШУА-ийн Философийн хүрээлэнгийн*

**Түлхүүр үгс:** Янз бүрийн соёл, уламжлал, шашныг зуучлан уулзуулах шүүмжлэлт эргэцүүлэл, шударга ёсны хямрал, хамтран оролцох эргэцүүлэл.

Хүн төрөлхтний өмнө тулгарч буй шийдвэрлэх асуудалтай уялдуулан олон соёлын хүрээнд эртний болон эдүгээгийн сэтгэгчдийн философдох янз бүрийн хэлбэрийг бүрэн хамрахын тулд философийн судалгааг даяаршлах зорилтыг Дэлхийн философичдын XXIV конгресс саяхан дэвшүүллээ. Энэ зорилтыг хэрэгжүүлэхдээ философийн өөрийнх нь тухай, орчин үеийн ертөнцөд түүний эзлэх байр суурь, гүйцэтгэх үүрэг, зорилгын тухай шүүмжлэлт эргэцүүлэлд онцгой анхаарах ёстой. Тулгамдсан асуудлыг шийдвэрлэхийн тулд философийн дискурс буюу эргэцүүллийг нээлттэй болгож, хүмүүнлэгийн, нийгмийн болон байгалийн шинжлэлийн салбар ухаанууд, эдийн засаг, нийгэм, улс төр, шашны хүрээ хийгээд янз бүрийн соёл, уламжлалын үйл ажиллагааны хэлбэрүүдтэй үр дүнтэй хамтран ажиллах зам хамгийн ашигтай гэж Конгресс үзэж санал болголоо. Философийн эргэцүүллийг урамшуулж үр ашигтай болгохын тулд философийн өмнө өнөөдөр тулгарч буй гол суудал болох экологи, шударга ёс ба энх тайвны үйлсэд гарч буй хямралт асуудлаар олон нийтийн мэтгэлцээн хийж байхыг ч зорилго болгосон нь манай судалгааны чигтэй таатай нийцэж байна. Эргэцүүллийн төвд “хүн”-ийг тавьж, улмаар хүнд тулгамдсан асуудлыг олж тогтоох, шийдвэрлэх үүргийг философид оноосон зорилтыг товч дурьдвал:

- орчин үеийн ертөнцөд философийн эзлэх байр суурь, гүйцэтгэх үүрэг, зорилгын тухай шүүмжлэлт эргэцүүлэл (critical reflections)
- философийн судалгааг даяаршлах
- тулгамдсан асуудлыг шийдвэрлэхийн тулд философийн эргэцүүллийг нээлттэй болгож, хүмүүнлэгийн,

## ОРЧИН ЦАГИЙН МОНГОЛ ХҮНИЙ ХАНДЛАГЫГ ЭРГЭЦҮҮЛЭХ НЬ

*Ж.Бямбасүрэн (магистр)  
Философийн хүрээлэнгийн ЭША*

**Түлхүүр үг:** үнэт зүйл, ёс суртахуун, хариуцлага

**Хураангуй:** Орчин цагийн монголчууд бид нүүдлийн соёл иргэншлээсээ холдож суурин соёлд дадахын хирээр язгуурын монгол уламжлал, соёл, үнэт зүйлээсээ алсарчээ. Даяаршлын нөхцөлд үндэсний соёл дахин сэргэх, хувиран өөрчлөгдөх, зарим хэсэг нь мартагдаж үгүй болох үйл явц явагдсаар байна. Тиймээс үндэсний соёл, үнэт зүйлсийн дархлааг хадгалж үлдэх арга замыг эрэлхийлж төрийн бодлого боловсруулагч, шийдвэр гаргагчид энэ асуудалд идэвх зүтгэлтэй хандаж, нийт иргэдэд нэн шаардлагатай эрх зүйн орчинг бүрдүүлэх хэрэгтэй байна.

Монголын улс төр, эдийн засаг, нийгмийн өөрчлөлт, шинэчлэлт, мэдээллийн технологийн дэвшил нь ард иргэдийн ертөнцийг үзэх үзэл, үнэт зүйл, чиг баримжаа, амьдралын хэв маягт ихээхэн нөлөөлж байна. Үүний зэрэгцээ монгол хүн бүрийн ухамсар, харилцаа, хандлага зэрэг нь улсын соёл, уламжлалын үнэ цэнийг хадгалж, тээж явах ирээдүйг нь тодорхойлох ажээ.

Өнөөдөр монгол хүн өөрийн үнэт зүйл, улс орныхоо үнэ цэнэ, эрхэм нандин зүйлийг тодорхойлж, түүнийгээ хүндэтгэн дээдэлж, бишрэн шүтэж чадаж байна уу? Даяаршин буй энэ цаг үед хувь хүний үнэт зүйл нь хэрэгцээ, шаардлагадаа захирагдан тодорхойлогдох болсон ч иргэн бүрийн дотоод итгэл үнэмшилд эх орон, газар нутаг, соёл, ёс заншил нь . Гагцхүү олон янзын хэрэгцээнд дарагдсан эх оронч сэтгэл зүрхийг ил гаргаж ёс суртахууны гол элемент болох шударга ёс, нинжин сэтгэл, тусч зан, хөдөлмөрч байдалтай нь уялдуулан хөгжүүлж чадвал үндэсний соёл, уламжлал дахин сэргэх учиртай.

Монголчуудын нийтлэг үнэт зүйлийн чиг баримжааг тодорхойлно гэдэг бэрхшээлтэй ч улс орны тусгаар тогтнол, халдашгүй дархан байдлыг бий болгодог зүйл бол газар нутаг, эх хэл, түүх, соёл, уламжлал билээ. Гэхдээ энэ хорвоо ертөнц дээр үнэт зүйлийг бий болгож бүтээж байгаа ХҮН-ээс өөр хамгийн

МОНГОЛ УЛСЫН  
ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ  
ФИЛОСОФИЙН ХҮРЭЭЛЭН

# ХҮМҮҮНИЙ ЕРТӨНЦ БА ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

*Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн,  
Доктор (Sc.d), профессор Ц.Балхаажавын 90 насны ойд  
зориулсан эрдэм шинжилгээний бага хурлын элхэтгэл*

УЛААНБААТАР ХОТ  
2018 ОН

## ГАРЧИГ

### I. Дурсамж

1. <i>Х.Цэвлээ</i> . Оргил.....	11
2. <i>Л.Лантуу</i> . Цэрэнпил гуайн Балхаажав доктор.....	18
3. <i>Н.Жадамба, Ө.Цэрэндорж</i> . “Төр нийгмийн зүтгэлтэн Ц.Балхаажав гуайн тухай бяцхан дурсамж-хөөрөлдөөн” .....	19
4. <i>Н.Бэгз</i> . Миний багш Ц.Балхаажав.....	25
5. <i>Д.Сүхбаатар</i> . Номон хөшөөний эзэн .....	33
6. <i>Р.Дарьхүү</i> . Эрхэм хүмүүн.....	35
7. <i>Жа.Пүрэв</i> . Халуун яриа.....	38

### II. Илтгэл

1. <i>Г.Чулуунбаатар</i> . Философич, доктор (Sc.D) профессор Ц.Балхаажав бол хүн судлалын ухааны монголын анхны томоохон эрдэмтэн мөн .....	49
2. <i>Б.Даши-Ёндон</i> . Монгол хүний чин хүслэнгийн асуудалд .....	55
3. <i>Ч.Даваадаш</i> . Доктор (Sc.D), профессор Ц.Балхаажав бол МАН-ын үзэл суртлын ажлыг олон жил удирдсан улс төрч мөн.....	60
4. <i>Ч. Ган-Өлзий</i> . Хүмүүний ахуйн тогтвортой төлөв.....	66
5. <i>А.Жамбал</i> . Нэрт философич, профессор Цэрэнпилийн Балхаажавын 1950-иад оны үеийн эрдэм судлал, бүтээл туурвил.....	72
6. <i>Л.Дашиням</i> . Хүнээр хүн хийх асуудалд.....	89
7. <i>Г.Лодой</i> . Хүний тухай асуудалд холбогдох өрнийн философийн зарим баримтлал .....	96
8. <i>Р.Дарьхүү</i> . Доктор, профессор Ц.Балхаажавын бүтээл дэх хүний хөгжлийн асуудал .....	100
9. <i>Ж.Энхбаяр</i> . Жон Дьюи: Хүний мөн чанарын тухай .....	106
10. <i>И.Лхам, Г.Уянга</i> . Хүүхэд гэж хэн бэ?.....	110
11. <i>С.Соёлмаа, Г.Лодой</i> . Мэдлэгийн тогтвортой хөгжил дэх домгийн төсөөлөх үүргийн асуудалд .....	120
12. <i>Б.Галиндэв</i> . Өнөөгийн монголын оюутан залуучуудын нийгэмшлийн асуудалд .....	127
13. <i>С.Базарпүрэв, Б.Насанбат</i> . Тогтвортой хөгжлийн үзэл санаа ба Монгол улсын хөгжлийн бодлого.....	137
14. <i>Б.Пүрэвсүрэн</i> . Монголчууд орос хэлийг дөрөөлөхүй: XX зууны монгол .....	145
15. <i>Ц.Батбаяр</i> . Тогтвортой хөгжилд орчин үеийн нийгмийн өөрчлөлт, хандлага, нийгэм-соёлын гүйцэтгэх үүрэг .....	152

## МОНГОЛЧУУД ОРОС ХЭЛИЙГ ДӨРӨӨЛӨХҮЙ: XX ЗУУНЫ МОНГОЛ

*Б.Пүрэвсүрэн, профессор  
Философийн ухааны доктор (Ph.D)*

Хэл бол соёлын хэрэглээ, соёлын эрх чөлөөний биелэл болох утгаараа соёлын адилсал эсрэг тохиолдолд ялгааны тэргүүн илрэл болдог. Орос хэл, соёлоор хойд хөрштэйгээ тийнхүү ижилсэх их хэрэг XX зууны Монголд өрнөсөн юм. Тийнхүү тэр үеийн дэлхийн их гүрэнгэй (энэ утгаараа Монгол дүү нь) эзэнт их гүрэн байсан монголчууд (энэ утгаараа Монгол ах нь) ах дүүгийн харилцаанд орсон билээ. Гэхдээ ах дүүгийн харилцаа гэдгийг найрамдалт, хамтын, нөхөрсөг гэсэн утгаар тайлбарлаж байв.

Соёлын бодлого, соёлын эрх чөлөөний үүднээс **олон соёл** зэрэгцэн орших бодлогыг баримталж байсан болон нүүдлийн иргэншлийн хөдөлгүүр болсон адуун соёл, түүний гол бүрдэл **дөрөө**, ташуур нь дэлхийг дайтаж явсан морьтон баатруудын хувьд чухал хэрэгсэл байсан гэдэг. Эдүгээ морь, дөрөө, ташуурын аль нь ч орчин цагийн монгол хэлнээ хэлэхүйн соёл уламжлал, монгол соёлын тогтолцоонд гүйцэтгэж байсан үүргээс улбаалан давхар утгат соёлын концепц болон хувирдаг ойлголтууд юм.

Тийм учраас энэ илтгэлд **дөрөөг** эмээллийн тоноглол болох төмөр дөрөөний тухай объект утгаас морьтныг газраас дээгүүр морины нуруунаа гаргахад нь дэм, тулгуур болж эрх чөлөөнд тэмүүлэх хүслийн хэрэглүүр болж буй тухай шилжсэн болон мета утга холбогдлын үүднээс хэрэглэж байгаа билээ. Гэхдээ дөрөөлөхүй гэдэг доор дөрөө даах болон дөрөө сэтлэх зэрэг утгууд ороогүй болно.

Дөрөө хэмээх үг утга шилжсэний нэг илрэл гадаад хэлийг нэг болоод нэгжгээд хэдээр нь эзэмшсэн хүнийг эрдэмтэй номтой гэхээс гадна “морьтой”, “хос морьтой”, “хөтөлгөө морьтой” хүн хэмээн нэрлэдэг явдал юм. Энэ тухай монгол хэл шинжлэлийн тэргүүлэх эрдэмтдийн нэгэн болох С.Галсан<sup>1</sup> зохих үндэслэлийг дэвшүүлсэн байдаг.

Сайн морьтноос гадна сайхан морины нуруунд халгаатай морьтон ч бас байдаг шиг гадаад хэлийг сурахын зэрэгцээ түүнийг хэрэглэх, ашиглах, зарим нэр томъёог унаган хэлнээ унага даага мэт номхруулах, орчуулах үйлнээ урагш муутай хандах нь их эрдэмтэн Б.Ренчин гуайн “Марк Твений минь махыг нь идэж дээ” /1958/ гэсэн орчуулгын шүүмж бичихэд хүргэдэг үйл юм. Тэрээр энэхүү шүүмждээ орчуулга гэдэг бол **соёлын эрхэм үүрэг** гэдгийг онцлон тодотгосон байх бөгөөд хайртай сайхан ардынхаа хэлний чадлыг дутуу ашигласан явдал гэдгийг өгүүлсэн байдаг нь өнөө ч анхааруштай зүйл юм.

Гадаад хэлийг дөрөөлж буй үе буюу голлох гадаад хэлний хэрэглээний хувьд, тодруулбал XX зуунд Монголчууд орос хэл, кирилл цагаан толгойн үсгийг авч хэрэглэсэнээрээ /ь, щ үсгийн асуудлыг эс тооцвол/ монгол хэл эвдэрсэн, хөгжсөн гэх туйлширмал маргаанд ямар нэгэн судалгааны арга зүй хэрэгтэй болох нь

<sup>1</sup> С.Галсан “Хэл шинжлэл ба бусад зүйл” УБ., 2008 он. 36-38 дахь тал

## ХҮМҮҮНИЙ АХУЙН ТОГТВОРТОЙ ТӨЛӨВ

Батын Ч. Ган-Өлзий  
доктор (Sc.D), профессор

Философийн үндсэн салбар болох онтологийн үндсэн судлагдахуун нь оршин буй юм, бодит байдлын бүх хэлбэр (бодит, объектив, физик гэх мэт болон субъектив, нийгмийн ба виртуаль зэрэг)-ийн иж бүрдэл ба нэгдэл гэж тодорхойлогддог ахуй мөн гэдэг зарчимд тулгуурлан түүний хэв маягийг дараах байдлаар тодорхойлж болно. Үүнд: Судлагдахууны салбараас үл хамаарах хамгийн ерөнхий түгээмэл ойлголтыг тодорхойлох *Метаонтологи*. Судалгааны салбарыг албан ёсоор тодорхойлдог бөгөөд метаонтологид нэгэнт тодорхойлогдсон ойлголтыг улам нарийсган тодотгохын тулд, эсвэл судлагдахууны хүрээний нэр томъёоны нийтлэг суурийг тодорхойлохын тулд хэрэглэгддэг *судлагдахууны салбарын онтологи*. Шийдвэрлэх асуудал, зорилгын нэр томъёоны нийтлэг суурь үндсийг тодорхойлдог *тодорхой зорилгын онтологи*. Судлагдахууны салбар ба зорилгын объектуудын гүйцэтгэх үйл ажиллагааны эцсийн үр дүнг тодорхойлохын тулд ихэнхдээ ашиглагддаг *сүлжээний онтологи*. Хэлбэр талаас нь онтологийг  $0 = \langle X, R, F \rangle$  гэж томъёолж болох бөгөөд үүнд: **X** нь судлагдахууны салбарын ойлголтуудын эцсийн олонлог, **R** нь ойлголт хоорондын харилцааны эцсийн олонлог, **F** бол тайлбарлах үйлийн эцсийн олонлог байх болно.

Хүмүүний ертөнцийн утга учрыг судлахдаа философийн шинжлэх ухааны доктор Ц. Балхаажав багшийн нэгэнт боловсруулан баримталж ирсэн бүхэллэг хандлага ба ахуйн задлан шинжилгээнд оруулж буй “**өөрийн**” гэдэг тодотголыг орчин үеийн онтологийн хандлагын үүднээс тайлбарлах хэдэн санаа байна. Юуны өмнө, Балхаажав доктор “хүн бол оюун цэнэгт амьдрал”<sup>1</sup> хэмээн тодорхойлж буй нь хүний ахуйн тухай сонгодог философийн баримтлалыг өргөтгөж өгч байгаа хэрэг. Энэ нь философи сонирхогчдод ахуйн тухай сонгодог онолыг шүүмжлэн шинэчлэж буй Яспэрс, Сартр болон Хайдэггер нарын үзэл баримтлалыг, юуны өмнө Хайдэггерийн суурь онтологийн зарчмыг тодорхойлон гаргаж түүндээ тулгуурлан “ахуй” ба “оршихуй”, “байх” ба “байх бус” хэмээх ойлголтуудын ялгааг гаргах илүү боломж олгох учиртай. Хүний ахуй философийн шинжилгээнд Балхаажав докторын хэрэглэж буй хүнийг ойлгох “байгаль, нийгэм, оюуны ба өөрийн гэх дөрвөн төрөл оролцооны нэгдмэл”<sup>2</sup> хандлагад дөрөөлөн хүмүүний ахуй руу цааш дахин нэг алхвал, энэ нь хүний ахуйг тэмдэглэхдээ Хайдэггерийн хэрэглэсэн “Дазайн” (“Dasein”) хэмээх ойлголтын арга зүйн ач холбогдол Дазайн шинжилгээний алхмуудыг зөв ойлгоход тус болоод зогсохгүй монголын уламжлалт философийн тайлал зүйтэй холбох боломж олгоно.

Хайдэггерийн суурь онтологийн үндсэн зарчим, “юм” ба “юу ч биш”, “хэл”, “орон”, “хугацаа”-ны метафизик зэрэг зарим ойлголтыг монголын мадхьямака философийн гол төлөөлөгчийн нэг З.Агваанбалдангийн суурь буюу мадаггүй үнэн баримтлал болж буй онол, шүтэн барилдуулах замаар хоосон чанарыг танин

<sup>1</sup> Ц. Балхаажав. Хүн алдрын гайхамшиг. II боть. УБ., 2016. 22 дахь тал.

<sup>2</sup> Ц. Балхаажав. Хүн алдрын гайхамшиг. II боть. УБ., 2016. 25 дахь тал.



## ЖОН ДЬЮИ: ХҮНИЙ МӨН ЧАНАРЫН ТУХАЙ

Ж.Энхбаяр (Ph.D)  
ШУА, Философийн Хүрээлэн

АНУ-ын философич Жон Дьюи нь хүний мөн чанарын тухай даацтай судалгаа хийж сэтгэл судлал, ёс суртахуун, боловсролын философийн хөгжилд томоохон хувь нэмэр оруулсан хүний нэг болно. Ж.Дьюи гэдэг нэрнээсээ илүү “Америкийн философич” гэгдэж түүхэнд үлдсэн түүний прагматик философийн үзэл санаа нь ХХ зууны философийн янз бүрийн урсгал чиглэлд, тухайлбал, эмпирицизм, гуманизм, натурализмын хөгжилд чухал нөлөөг үзүүлж, түүнчлэн орчин үеийн нийгэм - улс төрийн философи, логик, мэдлэгийн тухай онол, гоо зүйн гээд бараг философийн бүх сэдвээр ажилласан байдаг. Сэтгэл судлалын функционалист, беховарист чиглэлийг үндэслэгчид тооцогддоогоос гадна нийгмийн халамж, эмэгтэйчүүдийн сонгуулийн эрх, улс төрийн шинэчлэлийн төлөөх иргэний хөдөлгөөнүүдийн тэмцлийг дэмжиж идэвхтэй оролцож байжээ. Ялангуяа амьдралынхаа сүүлийн жилүүдэд 1930-50-аад онд янз бүрийн сайн дурын нийгэмлэг холбоо, хүмүүнлэгийн үйл ажиллагаанд чармайлттай оролцож байв.

Канадын нэрт түүхч, сурган хүмүүжүүлэгч Хильда Марион Нейтбигийн хэлсэн лүгээ “Аристотель дундад зуунд ямар их нөлөөтэй байсан шиг Жон Дьюи манай эрин үед их нөлөөтэй”<sup>1</sup> философич юм. Бид Жон Дьюиг нэгд, багш, боловсролын шинэчлэлийн төлөөх хөдөлгөөний эцэг, хоёрт, либераль ардчилсан үзэлтэн, гуравт, прагматик сэтгэгч гэсэн гурван үндсэн хүрээнд авч үзэж ирсэн билээ. Энэ удаа Жон Дьюигийн боловсрол, ёс суртахууны философийн суурь зарчим болсон хүний мөн чанарын тухай үзлийг нь товчийн төдийд өгүүлэхийг хүсэв.

Ингэхийн учир гэвээс, хүний мөн чанарыг гаргуун шинжиж ойлгож мэдэхгүйгээр нийгмийн өөрчлөлтийг гүйцээн төрийг төвхнүүлэх амаргүй, нийгмийн үй түмэн асуудал, ёс суртахууны доройтол уналтыг зогсоож тохинуулах нь бэрх болохыг монголын сүүлийн 28 жилийн түүхээс харлаа. Хүний мөн чанарыг эс мэдэх нөхөд хууль тогтоож, хүний хэлэх, үйлдэхийг журамлан эрх зүйт төр, ардчилсан нийгмийг зохион байгуулна гэдэг бүтэхээс бүтэхгүй нь их аж. Нөгөө талаар, 90 насны ойгоо тэмдэглэж буй Ц.Балхаажав гуайн нөр их хөдөлмөрийн үрээр монголд хүний тухай философийн суурь тавигдаж, эрдмийн сан хөмрөг бүрдэж байна. Энэ сан хөмрөгт Жон Дьюигийн хүний мөн чанарын тухай үзлээс нэмэрлэх нь зүйтэй юм. Үе үеийн гарамгай философичид хүн гэж юу вэ? мөн чанар нь юу болох талаар судлан боловсруулж, өөр өөрсдийн үзэл бодол, үнэлэмжээр хүний тухай философийн эргэцүүллийг баяжуулж ирсэн байдаг.

Чингэхдээ Жон Дьюигийн хүний зан үйл, дадал зуршил, сэтгэл зүйн нийгмийн өдөөгч хүчин зүйлсийн тухай бичсэн “Хүний мөн чанар ба үйлдэл: нийгмийн сэтгэл зүйн удиртгал”<sup>2</sup> хэмээх номонд дурдагдсан санааг голлон авч үзэв. Тэрээр Дарвины хувьслын онолыг дэмжин баримталж, аливаа амьд биетийн нэгэн

<sup>1</sup> Hilda M. Neatby, *So Little for the Mind* (Toronto: Clarke Irwin & Co. Ltd., 1953), pp.22-23.

<sup>2</sup> John Dewey, *Human Nature and Conduct*, Dover Publications, NY: 2002

## МЭДЛЭГИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ ДЭХ ДОМГИЙН ТӨСӨӨЛӨХ ҮҮРГИЙН АСУУДАЛД

*С.Соёлмаа, доктор (Ph.D),  
ШУА, Философийн хүрээлэн,*

*Г.Лодой, доктор (Ph.D),  
МУИС-ийн зөвлөх профессор*

Бид саяхны нэг өгүүлэлдээ<sup>1</sup> мэдлэгийн тогтвортой хөгжил гэсэн ойлголтыг бүхэлд нь бүтэц шинжлэлийн философийн үүднээс тодруулсан учраас энд товч илэрхийлье. Мэдлэгийн тогтвортой хөгжил гэсэн ойлголт нь шинжлэх ухааны хөгжил гэсэн ойлголттой салшгүй холбоотой юм. Шинжлэх ухааны мэдлэгийн хөгжлийн тухай философийн ухааны доктор, Санкт-Петербургийн Их сургуулийн профессор В.А.Гуторов авч үзсэн байна. Жишээ нь, тэрээр сүүлийн үеийн нэгэн өгүүлэлдээ бичихдээ “Модерн үеэс л шинжлэх ухааны дэвшил (прогресс) нь нийгмийн өөрчлөлт шинэчлэлтийн чухал шалгуур нь болж улмаар энэхүү шинжлэх ухааны хөгжлийн онолын шинжлэл нь дэлхийн түүхийг болон хүний үйл ажиллагааны олон талт дэвшилтэт өөрчлөлтийн тухай үзэл санааг онолын хувьд үнэлж дүгнэх ойлголтын нэгдлийг цэвэр арга зүйн хувьд хангахад чиглэдэг юм”<sup>2</sup> гэсэн байна. Энд шинжлэх ухааны хөгжлийг дэвшил гэсэн ухагдахуунаар авч үзжээ. Ерөнхийд нь энд яриад буй хөгжил гэсэн ойлголтыг дэвшил ч хэмээн ойлгож болох юм. Жишээ нь, В.А.Гуторов бичихдээ «Дэвшил бол яг таг тодорхой гэхээсээ илүү зорилгод чиглэсэн, хэм хэмжээ юм. Тухайлбал, А гэсэн онолоос Б гэсэн өөр онол руу шилжих алхам нь өсөлт дэвшил гэж үзвэл энэ нь Б бол тодорхой харилцаанд л А гэсэн онолыг сайжруулсан гэсэн үг юм. Энэ утгаараа өсөлт дэвшил бол хөгжил (развитие) гэсэн дундын ойлголттой хам шинжтэй болдог [Niiniluoto 1984, 75–76]. Ср.: [Losee 2004, 1]” юм гэснээс дүгнэхэд шинжлэх ухааны мэдлэгийн хөгжил нь тийм ч хатуу чанд, яг таг, механик ойлголт биш юм.

Бидний өгүүлсэнчлэн «мэдлэгийн тогтвортой хөгжил» гэдэг бол шинжлэх ухаан, философи гэх рациональ шинжтэй мэдлэгүүд дангаараа, өөрөөр хэлбэл домог, шашин зэрэг иррациональ мэдлэггүйгээр хөгжих бололцоогүй байдаг учир эдгээр төрлийн мэдлэг нь тогтвортой хөгжихийн тулд харилцан бие биедээ үүрэгтэй байдаг гэсэн ойлголт юм. Тиймээс энэ илтгэлдээ философи, шинжлэх ухааны мэдлэгийн хөгжилд домгийн олон үүргүүдийн (бид өмнө нь авч үзсэн) нэг болох төсөөлөх үүргийг авч үзэх юм.

Домгийг төсөөлөх үүргийнх нь талаас шинжлэх ухааны үүднээс авч үзсэн нь соён гэгээрлийн үеэс эхлэлтэй юм.

XVIII зууны үед домгийг түүх-социологийн үүднээс тайлбарлах оролдлогыг Вико хийжээ. Тэрээр арга зүйн хувьд түүхэн дэвшлийн тухай картезианч<sup>3</sup> хувилбарын эсрэг байр суурьтай байсан юм. Тухайлбал, Фонтенель

<sup>1</sup> Философи, эрхийн судлал-XXXIII. УБ., 2018 /хэвлэлтгэл/.

<sup>2</sup> Гуторов В.А. О некоторых тенденциях интерпретации концепции прогресса в современной социальной теории // Вопросы философии. 2017. № 12.

<sup>3</sup> \*Рене Декартын философийг баримтлагч

16. <i>Б.Цэрэнханд</i> . Хүний тухай аналитик философи эргэцүүлэл .....	160
17. <i>О.Баасантогтох</i> . Малчдын хөдөлмөр эрхлэлтэд гарч буй өөрчлөлт.....	164
18. <i>Б.Нарантунгалаг</i> . Тогтвортой хөгжил ба хүний хөгжлийн зарим асуудал .....	169
19. <i>Б.Азбаяр, Б.Бадрах</i> . Нийслэлийн иргэдийн буддын шашинд хандах хандлага, олон нийтийн байгууллагын нөлөөлөл .....	177
20. <i>Ж.Бямбасүрэн</i> . Монгол хүний ёс суртахууны үнэт зүйлийн өөрчлөлт.....	182
21. <i>Э.Молор-Эрдэнэ, М.Мөнгөнзул, Э.Даваадулам</i> . Ээж ба үлгэр дууриалал ....	186
22. <i>Б.Ариунцэцэг</i> . Хүний оршихуйн талаарх Жан Поль Сартрын үзэл.....	193
23. <i>Ч.Ичинхорлоо</i> . Бие хүний соёл хөгжлийн үндэс болох нь.....	199
24. <i>С.Хишигтогтох</i> . Урлаг хүний ертөнцийн өвөрмөц үзэгдэл болох тухай З.Фрейдийн баримтлал .....	204

### III. Ц.Балхаажавын сүүлийн үеийн зарим бүтээл ба гэрэл зураг

1. Бүх төрлийн сэтгэлгээний төрсөн эцэг нь хүн .....	215
2. Философич мэргэжил, сэтгэлгээний товч тойм .....	218
3. Хүнийг үзэх үзлийн ноён нуруу .....	220
4. Философи сэтгэлгээний танин мэдэхүйн толинд монгол малчны хөгжлийн түүхэн замналыг харахуйд .....	222
5. Дэлхийн соёл иргэншилд монгол хүний оруулсан хувь нэмэр .....	229
6. Монгол хүний мал маллахуй үйлдвэрлэлийн технологи .....	240
7. Малчин хөдөлмөр .....	246
8. Цаг хугацааны монгол баримтлал .....	252
9. Монголын философичдын VI симпозиум дээр доктор (Sc.D), профессор Ц.Балхаажавын хэлсэн үг.....	256
10. Гэрэл зураг.....	258

## МОНГОЛ ХҮНИЙ ЁС СУРТАХУУНЫ ҮНЭТ ЗҮЙЛИЙН ӨӨРЧЛӨЛТ

Ж.Бямбасүрэн, магистр  
ШУА-ийн Философийн хүрээлэн

*Түлхүүр үг: ёс суртахууны үнэт зүйл, үнэт зүйлийн өөрчлөлт, ёс зүйн боловсрол*

**Товч утга:** Монгол хүн гэж ийм хүнийг хэлнээ гэсэн ёс суртахууных нь үүднээс тодорхойлох шинжүүд юу байж болох вэ талаар тунгаан бодож, энэ талаар ном, өгүүлэл уншиж судлахдаа монгол хүний ёс суртахууны эрхэмлэл, үнэт зүйлийг тодорхойлохдоо монголчуудын түүх, нийгмийн тогтолцооны онцлогтой нь уялдуулан судлах нь илүү оновчтой болох юм хэмээн бодлоо.


Өнгөрсөн зуунуудад хүн-хүнтэйгээ, хүн-байгальтайгаа зүй ёсоор харьцах шаардлагатайд онцгойлон анхаардаг байсан бол аж үйлдвэрийн дөрөв дэх хувьсгалын нөлөөгөөр хүн-техниктэй (цахилгаан болон хийн тоног төхөөрөмж ашиглах, цахим орчинд гэх мэт) хэрхэн зов зохистой харьцах арга ухаан бидэнд зайлшгүй шаардлагатай боллоо. Дэлхий дээр хиймэл оюун ухаан бий болж хүний үйл ажиллагааг оролсон бүр цаашлаад хиймэл оюун ухаант хүн бүтээгдсэн энэ цаг үед хүнийг хүн ёсоор авч үлдэх цор ганц зүйл бол ёс суртахуун юм.

Мал аж ахуйгаа эрхлэн нүүдэллэн аж төрсөөр ирсэн монголчуудын хэв маяг суурин соёлд хурдацтайгаар шилжиж хөдөөгийн малчин гэрээсээ интернетэд холбогдож, дуртай кино, контентуудаа үзэж, морин уналгын оронд мотоцикль, машин хөлөглөж, жилийн дөрвөн улиралдаа зохицсон тохилог байшин сууцтай болжээ. Энэ бүхэнтэй холбоотойгоор монгол хүний үнэт зүйл тэр дундаа ёс суртахууны үнэт зүйл цагийн аясаар өөрчлөгдөн шинэ агуулга, шинэ үнэлэмжтэй болж байна. Хэдийгээр объект субъектээс хамаараад харилцан адилгүй үнэлэмж өгөх зүйлийг тодорхойлох, нэг мөр болгох боломжгүй ч олон нийтийн санаа бодол, хүсэл зориг хаашаа тэмүүлж, юуг хүсч байна вэ гэдгээс ерөнхий зураглал гаргаж болох юм. Миний хувьд монгол хүний нэрийн хуудас “хүндлэл, итгэлцэл” байх ёстой гэдэг үүднээс энэхүү илтгэлээ бичлээ. Нийтийн дунд “япон хариуцлага”, “герман чанар” гэсэн яриа хөвөрсөөр байдаг. Үүнтэй адил монгол улсыг олон улсад таниулах ёс суртахууны үнэт зүйл нь “монгол хүндлэл” байх ёстой гэж бодно.

“Хүн төрөлхтөний амьдралд хэдэн мянган жилээр оршиж уламжилж ирсэн ёс суртахууны эгэл хуулиуд гэвэл хөгшид, эмэгтэйчүүдийг хүндлэх, хүүхэд эмгэд өвчтөнг асрах, эв санааны нэгдэл, харилцан туслах, харилцан хүндэтгэлцэх, эелдэг эвч, энгийн даруу усгал зөөлөн, үнэнч, зөвч, цэвэр ариун ёс зэргийг дурдаж болно”<sup>1</sup> хэмээн Д.Дашжамц гуай өөрийн номондоо бичжээ. Эдгээр ёс зүйн үндсэн зарчмыг хүн өөртөө төлөвшүүлснээр хүн хоорондын, хүн байгалийн харилцаа эрүүл, зөв байх нөхцөл бүрэлдэх юм.

Монгол улсын үндсэн хууль болон соёлын тухай хуулинд үнэт зүйл гэсэн нэр томъёо тусгагдсан байдаг. Тэгвэл үнэт зүйл гэж чухам юу вэ? Энэ нь хувь хүн

<sup>1</sup> Д.Дашжамц. Хүн, хүмүүжил, ёс суртахуун. УБ., 1978, 139 дэх тал.



# ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ БА ОЮУНЫ СОЁЛЫН ӨВ

УЛААНБААТАР ХОТ  
2019

ГАРЧИГ

<b>ӨМНӨХ ҮГ</b> .....	5
1. Д.ДАШПҮРЭВ The Mongolian mind: principal ideas of mongolian historiography .....	6
2. С.ДУЛАМ Монголчуудын үндэсний ижилсэл-ондоошлын тэмдэг бэлгэдлийн судалгаа .....	11
3. А.ЭНХБААТАР Монгол дахь философийн хөгжил: Индигенизаци.....	24
4. С.ОДХҮҮ Монгол менталитетийн асуудалд .....	30
5. Б.ГАЛИНДЭВ Өнөөгийн монголын нийгмийн оюун санааны орон зайн төлөв байдал, агуулга, чиг хандлага .....	40
6. Ш.ГАНХУЯГ, Ж.БЯМБАСҮРЭН Төрт ёсоо дээдлэх соёл.....	51
7. Б.ДЭЛГЭРМАА, Д.АРИУНЖАРГАЛ Тогтвортой хөгжилд үндэсний соёл чухал болох нь .....	57
8. Д.ГАНТӨМӨР Монголын оюун санааны тогтвортой хөгжлийн асуудалд .....	63
9. Ц.МӨНХ-ЭРДЭНЭ Монголчуудын бичиг соёлын өв уламжлал ба хэрэглээ .....	74
10. Б.БУЯНДЭЛГЭР Монголчуудын “сүнс” хэмээх ойлголтын соёл, зан заншлын улбааг судлах асуудалд.....	83
11. Г.ЖАРГАЛСАЙХАН Монголчуудын байгаль төвт оюуны соёлын зарим илэрцийн тухайд.....	90
12. Д.ЧУЛУУНГЭРЭЛ Когнитив соёлын хандлага.....	99
13. Ц.БАТБАЯР Нийгмийн өөрчлөлтөд шашин-ёс суртахууны үнэт зүйлсийн гүйцэтгэх үүрэг, ач холбогдол.....	103
14. Ч.ИЧИНХОРЛОО Нүүдэлчдийн ахуй соёл ба тогтвортой хөгжил.....	108

## ТӨРТ ЁСОО ДЭЭДЛЭХ СОЁЛ

Ш.ГАНХУЯГ

Доктор (Ph.D), дэд профессор

Ж.БЯМБАСҮРЭН

Магистр

ШУА-ийн Философийн хүрээлэн

**Түлхүүр үг:** төрт ёс, төрөө дээдлэх ухаан, ардчилал, хөгжлийн философи


Хууль цааз үүсээгүй эрт үед хүмүүсийн харилцааг зохицуулагч гол зүйл нь ёс суртахуун байсан бол төрт ёс үүссэнээр нийгмийн харилцааг хууль, дүрэм журам зохицуулах болсон. Монголын төрт ёсны уламжлалын хөрс суурь нь нүүдэлчдийн соёл, ёс заншил, сэтгэлгээний уламжлал юм. Монголын нүүдэлчдийн төрт ёс нь тэдний амьдралын арга ухаан, ёс заншил, шашин шүтлэг, сэтгэл зүйн болон үнэлэмжийн онцлогоос улбаатай төрийг тогтоогч оюун санааны багана юм. Монголын нүүдэлчдийн төрт ёсны уламжлалыг авч үзэхдээ, төрт ёс нь төрийн бичиг соёл, төрөөс иргэн, улс түмэндээ хандах хандлагыг илэрхийлсэн засаглалын үзэл санаа, иргэдээс төрд хандах ёс, үзэл бодол, суртал хийгээд төрийн билэгдэлтэй холбоотой.

Өнөөдрийн илтгэлдээ монгол түмний уламжлалт соёлын нэг хэсэг болсон төрийг дээдлэх, захирах, захирагдах ёс цагийн аясад яаж хадгалагдан, хувьсаж ирсэн талаар товчхон өгүүлэхийг зорьсон юм. Үүнд нийгэм улс төрийн нөхцөлд иргэн нь төрөө дээдэлж, төр нь иргэнээ энэрэн тэтгэдэг төрт ёсны уламжлалт үнэт зүйлсийн талаар ярих нь дамжиггүй юм.


Монгол түмний уламжлалт соёлын нэг чухал хэсэг болсон төрийг дээдлэх, шүтэн захирагдах ёс нь цаг хугацааны хувьд өөрчлөгдөж янз бүрээр оршин байжээ. Тиймдээ ч монголын төрт ёсны уламжлал нь монголчууд төрт улсаа хэрхэн байгуулж байсан түүхтэй салшгүй холбоотой юм.

Аливаа аймаг, угсаатан нэгдэн нийлж төр улсыг үүсгэн нэгдмэл оюун сэтгэхүй бүрэлдэн бий болж, хууль дүрэм боловсруулж нийгмийн харилцаагаа зохицуулж ирсэн түүх аль ч улс орны өнөөгийн түвшний шалтгаан болсон байдаг. Монгол орны хувьд төрт ёс үүссэн түүх тэртээх НТӨ 318 онд Хүннү нар бусад улсуудтай нийлэн Цинь улс руу довтолсон гэж түүхийн сударт хамгийн анх дурдагдсанаар илтгэгддэг.

Их Монгол Улс, Монголын эзэнт гүрний үед төрт ёсоо дээдлэх үзэл соёлын нэгэн тэм үнэт зүйл байсан нь хэн бүхэнд тодорхой. Харин Манж Чин улсын эрхшээлд ирсэн үеэс энэ нь ихээхэн өөрчлөгдөж ирсэн байдаг. Энэ үеийн монголын төр нь ягуурын ба харийн гэсэн хоёрдмол шинжтэй болж хаад, ноёд, түшмэл, шүүх цаазын болон төрийн албаны нэг хэсгийнх нь үйл ажил, үзэл бодол, улс үндэстний болон иргэдийнхээ ашиг сонирхлыг төлөөлөх чадвар, шударга чанар нь алдагдан тэр



# ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ: НОГООН ЁС ЗҮЙ



Улаанбаатар  
2019



ГАРЧИГ

Д.Тунгалаг	<i>Эко ёс зүйн монгол уламжлал, түүний онцлог</i>	7
Б.Галиндэв	<i>Экологийн боловсрол, ёс зүй эх оронч үзлийн тулгуур болох нь</i>	18
Р.Дарьхүү	<i>Монгол Улс дахь экологийн ёс зүйн сургалт, судалгааны өнөөгийн байдал</i>	27
М.Гантуяа, Б.Бадрах	<i>Байгаль орчлонгийн талаарх нүүдэлчдийн ба буддын уламжлалт үзэл ойлголтын зохицол</i>	37
М.Золзаяа	<i>Ногоон ёс зүй хэмээх ойлголтыг тодруулах нь</i>	47
Б.Мөнхжавхлан Б.Дагзмаа	<i>“Хүрээлэн буй орчны философи” хичээлийн хөтөлбөр, агуулгын тухайд</i>	57
Г.Эрдэнэбаяр Д.Оюунгэрэл	<i>Ёс суртахууны үнэт зүйлс: тогтвортой хөгжил</i>	63
Ц.Батцэрэн	<i>Био ёс зүйн хөгжил ба монгол уламжлал</i>	70
Г.Уянга, И.Лхам	<i>Хүрээлэн буй орчныг хамгаалах үйлсэд их сургуулийн санаачилга, манлайлал</i>	80
Д.Гантөмөр	<i>Тогтвортой аялал жуулчлалын хөгжил дэх ёс зүйн асуудал</i>	89
С.Соёлмаа	<i>Тогтвортой хөгжлийн ёс зүйн асуудлыг монгол домгийн бүтцээр шинжлэхүй</i>	97
С.Дэмбэрэл	<i>Дээрхийн Гэгээн XIV Далай ламын нэгэн зохиолд ногоон ёс зүйн үзэл санаа илрэх нь</i>	103
А.Энхтогтох С.Цогбадрах	<i>Бага боловсролын “Хүн ба орчин”-ы сургалтын цөм хөтөлбөр, тогтвортой хөгжил, тогтвортой хөгжлийн зорилтын хамаарлыг илрүүлсэн үр дүн</i>	109
Б.Буяндэлгэр	<i>Олимпизм дахь экологийн ёс зүйн практик асуудлууд</i>	118
Д.Лхагвасүрэн Т.Цэрэнлхам С.Отгонбүрэн Ц.Дашдулам	<i>Монголчуудын байгаль хамгаалах уламжлалт аргууд, ёс зүйн асуудлууд</i>	129
Ц.Пүрэвсүрэн	<i>Байгаль орчныг хайрлан хамгаалахад шашны ёс зүйн нөлөө</i>	137
Р.Бигэрмаа	<i>Орчин үеийн яруу найраг дахь байгаль хамгааллын ёс зүйн асуудалд /Ардын уран зохиолч Б.Лхагвасүрэнгийн яруу найргийн жишээн дээр/</i>	144

## ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН АСУУДЛЫГ МОНГОЛ ДОМГИЙН БҮТЦЭЭР ШИНЖЛЭХҮЙ

С.Соёлмаа. Доктор (Ph.D)  
ШУА-ийн Философийн хүрээлэн

*Резюме:* В данной статье мы исследовали конкретный пример монгольского мифа на основе актуальных этических проблем устойчивого развития. Для этой цели, мы выбрали мифический сюжет "Монгольского Сокровенного сказания", связанный с идеями структурализма и постструктурализма, о том что главный герой мифа всегда приходит в этот мир с иного, высшего мира и миф есть часто не отражение реальности, а хотение и представление о будущей реальности. Это есть ключевая методология нашего исследования.

Прежде всего мы определяли что такое "устойчивое развитие" на основе новейших философских дискуссиях. И наша гипотеза заключается в том, что "устойчивое развитие" означает не только отношение человека к природе и окружающей среде, а также роли окружающей среды и природы в социальном, культурном, интеллектуальном развитии человека. И миф, в том числе наш пример Монгольского мифа отражает отношения между такими сетями оппозиций как космогонических, техно-экономических и социокультурных.

В заключении мы сделали такие выводы как динамические отношения между сетями оппозиций мифа и есть основа развития, а функция замены крайних метафизических оппозиций в другие сети оппозиции и есть основа устойчивого развития.

Энэ илтгэлдээ бид юуны өмнө хөгжил, тогтвортой хөгжил зэрэг чухал асуудлуудыг авч үзэж улмаар монгол домгийн бүтцийн философийн үүднээс шинжлэхийг оролдлоо.

"Хөгжил" гэх нэр томъёог "Философийн толь" бичгүүдэд дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд, "хөгжил гэдэг нь нэг төлөв, чанараас нөгөө рүү, хуучнаас шинэ рүү шилжих, байгаль ба нийгмийн өөрчлөлт, хөдөлгөөний дээд хэлбэр"<sup>69</sup> хэмээн тодорхойлсон байна. Үүнээс хөгжил гэдэг бол үргэлж ямар нэг төлвөөс нөгөө төлөв рүү шилжих шилжилт байдаг бөгөөд энэ нь ямар нэг объектын доод буурай байдлаас дээд төгс төгөлдөрт шилжих нэгэн чигийн хөдөлгөөн бөгөөд ухралт бууралт, дэвшил мандалтыг өөртөө багтаадаг ойлголт билээ. Ер нь

<sup>69</sup> Новая философская энциклопедия. Том третий. Мысль.: М., 2010. С.397.

## ЭКОЛОГИЙН ЁС ЗҮЙН БОЛОВСРОЛД ШАШНЫ ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ

Б.Мөнхцацралт (докторант),  
Ж.Бямбасүрэн (магистр),  
ШУА-ийн Философийн хүрээлэн

**Abstract:** Today in shamanism, Buddhism, Christianity and Islam there are basic religious traditions, in addition, new religious traditions, called "new religions", have been developed in many ways and are becoming increasingly popular among many religions. These five categories aren't largely homogeneous but there have multiple streams. In this report we aim to clarify citizens' awareness of the ecological education of the community through training, seminars, advertising and collaboration, such as the activities of these religious organizations, and to clarify whether their understanding of ecological ethics is as well as possible. Mongolians have a unique and culturally diverse group of people who seek and protect the environment from ancient times. It is important to reinforce this tradition and make it for the children to understand and use it.

**Түлхүүр үг:** Ёс суртахууны ухамсар, шашны олон нийтийн байгууллага, экологийн боловсрол, тогтвортой хөгжил

Монголчууд байгаль, хүрээлэн буй орчинтойгоо нягт зохицон амьдарч ирсэн уламжлалтай. Эх дэлхийтэйгээ ойр байж, ахуй амьдралаа залгуулж ирсэн нь хүрээлэн буй байгаль орчноо хайрлан хамгаалах эрхэм ёс, хорио цээр бүхий үзэл санаа, зан үйлийн цогцыг бий болгожээ. Монголчуудын хувьд байгаль орчноо хамгаалах нь түүнийг гадны ямар нэгэн хүч нөлөөнөөс нүд цавчилгүй харж хамгаалахын, эсвэл эвдрэл доройтолд орсных нь дараа “орсон борооны дараа цув нөмрөх” адил халаглан харамсахын нэр төдий бус бөгөөд харин болзошгүй эрсдэл, аюулаас урьдчилан сэргийлэхэд байгалийн зүй ёсонд нийцэн амьдрах, газар дэлхийгээ ижийтэйгээ зүйрлэн, хүндэтгэн дээдлэх, түүнийг хүнчлэн үзэж, хүмүүнлэг сэтгэлээр хандан, амьтан ургамлаа энэрэх, экологийн өндөр ёс зүйтэй байж нөөц баялгийг нь ариглан гамнах үзлээр илэрхийлэгдэх билээ.

Уламжлал, зан заншлын хэлхээ холбоо алдарч, энэ хэрээр хүн байгалийн хоорондын харилцааны эрхэм нандин чанар алдагдаж буй өнөө үед байгалийн сүр хүчийг бишрэн шүтэж, аргадан тахидаг байсан уламжлалаас хөндийрч, байгалийг зөвхөн эдийн засгийн хэрэглүүр болгож харах болжээ. Энэ нөхцөлд уламжлалыг тээгч нийгэм, соёлын нэг чухал үзэгдэл болох шашны үүрэг, ач холбогдлыг тодруулан авч үзэх нь бидний илтгэлийн гол зорилго болно.

## ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛД БАЙГАЛЬ ХАМГААЛАХ ТАЛААРХ МОНГОЛЧУУДЫН ЁС СУРТАХУУНЫ УЛАМЖЛАЛ ЧУХАЛ БОЛОХ НЬ

П.Мягмарсайхан. Магистр  
ШУА-ийн Философийн хүрээлэн

**Хураангуй:** Монголчууд хүрээлэн буй орчин, газар шороо, уул усаа хайрлан хамгаалж байгальтайгаа зүй зохистой харьцаж амьдарч ирсэн олон зуун жилийн баялаг уламжлалтай. Энэ талаар Р.Дарьхүү “Байгаль хамгаалах монголчуудын ёс суртахууны түүхэн уламжлалаас эдүгээ суралцах зүйл их байна. Бидний өвөг дээдэс маань газар эх, тэнгэр эцэг хэмээн байгалийг шүтэж хайрлаж, зүй зохистой харьцаж, хамгаалж ирсэн уламжлалт ёс зүйгээ сэргээн судалж суралцах талаар бид дорвитой судалгаа хийх хэрэгтэй юм. ... Байгалиа хайрлан хамгаалах монгол уламжлал бол нүүдэлчдийн оюун ухаан, дадал заншил, ёс суртахууны үнэт бүтээл учраас түүнийг цаашид нарийвчлан гүнзгийрүүлэн судлах, суралцаж хэрэглэх нь шинжлэх ухаан, практикийн нэг тулгамдсан асуудал болно.”<sup>9</sup> хэмээн чухалчилсан буй. Иймээс байгальтайгаа хүйн холбоотой аж төрж ирсэн монголчуудын ёс суртахууны баялаг уламжлал нь орчин үеийн тогтвортой хөгжлийн асуудалд чухал ач холбогдолтой болохыг илтгэлдээ авч үзлээ.

**Түлхүүр үг:** байгаль, экологи, ёс суртахуун, уламжлал

Эдүгээ шинжлэх ухаан, мэдээлэл технологийн үсрэнгүй хөгжлийн зэрэгцээ хүрээлэн буй орчны болоод хүний үйлдэлтэй холбогдсон ёс суртахууны асуудал, үүнд байгаль орчин, экосистемийн аюулгүй байдлын эмзэг асуудлууд ундарч хүн төрөлхтөн нийтээрээ санаа тавихаас аргагүй байдалд орж байна. Учир нь хүн төрөлхтөн хөгжлийн төлөө ганц чиглэл зорилготой явсаар эдүгээ зарим улс өндөр хөгжилд хүрч, зарим нь хөгжлийнхөө шатанд, ерөнхийдөө хөгжихийн тулд байгаа боломж бүхнээ шавхаж байгаа нь хүний амьдралын чанарт сайн талтай хэдий ч нөгөө талд нь байгаль орчинд сөргөөр нөлөөлөх нь ихсэж, эрт цагаас байгальтай дасан зохицож амьдарч ирсэн уламжлалыг эргэн харах шаардлагатай болсон.

Ингээд хөгжлийн асуудлыг өнөө болон ирээдүй үедээ аль алиндаа зохистой байлгах шаардлагын хүрээнд тогтвортой хөгжлийн асуудлыг их ярьдаг боллоо. НҮБ-аас тогтвортой хөгжлийн зорилгыг тунхаглаж улс орон бүхэн өөрсдийн хийж хэрэгжүүлэх хөтөлбөр

<sup>9</sup> Дарьхүү Р. Экологийн ёс зүйн асуудалд. //Олон соёлын хүрээнд экологи, шударга ёс, энх тайвны үйлсэд хамтран ажиллах философи. УБ, 2018. 68 дахь тал.

ДЭЛХИЙН ФИЛОСОФИЙН ӨДӨР 2020



МОНГОЛЫН НИЙГЭМ ДЭХ ЦАХИМ  
ОРЧНЫ НӨЛӨӨЛӨЛ:  
ФИЛОСОФИ АСУУДЛУУД

## ГАРЧИГ

<b>Мэндчилгээ</b> .....	5
<b>Монголын Философийн Холбооны мэндчилгээ</b> .....	7
<b>Өмнөх үг</b> .....	9
<b>Ч.Ган-Өлзий</b>	
Технологийн метафизик ба цахим ертөнц .....	11
<b>Б.Очирхуяг, Ш.Ганхуяг</b>	
КОВИД -19 цар тахал ба биофилософийн өөрчлөлт .....	17
<b>Б.Дагзмаа, М.Отгонбаяр, В.А.Иноземцев</b>	
Орчин үеийн нийгмийн өөрчлөлтийн тухай онолууд дахь шинжлэх ухаан, технологийн нөлөөллийн асуудал .....	22
<b>Ц.Нямсүрэн, А.Ган-Эрдэнэ, Т.Жаргалсайхан, М.Л.Ивлева</b>	
КОВИД-19 цар тахлын үеийн нийгмийн сэтгэлзүй цахим орчинд .....	29
<b>Б.Отгонсүвд, Д.Ууганбаатар</b>	
Хиймэл оюун, түүний ёс зүйн зарим асуудлууд .....	41
<b>Г.Уянга, И.Лхам</b>	
Цахим хичээлийн чанар, үр дүнгийн талаарх суралцагчдын сэтгэл ханамж, тулгамдаж буй асуудал .....	49
<b>М.Золзаяа</b>	
Хиймэл оюун ухааны ёс зүй: сорилт ба хариуцлага .....	56
<b>М.Хүрэлтогоо, А.Мөнхшагай</b>	
Дижитал сурах бичигт тавих шаардлага, шалгуур .....	64
<b>Ч.Нямсүрэн, Б.Мөнхдорж</b>	
Хиймэл оюун ухаан ба криминологийн хөгжлийн чиг хандлага .....	71

## ТЕХНОЛОГИЙН МЕТАФИЗИК БА ЦАХИМ ЕРТӨНЦ

**Батын Ч.Ган-Өлзий**

*Доктор (Sc.D), профессор  
ШУА-ийн Философийн хүрээлэн*

Метафизикийн хамгийн гол салбар нь ертөнцөд юмсын ямар төрөл хэлбэрүүд оршдог хийгээд тэд хоорондоо хэрхэн харилцдаг тухай асуудлыг судлан шинжилдэг **ахуй ёс буюу (ontology)** юм. Ийм судалгаа хийхийн тулд оршихуй, судлагдах байдал, шинж чанар, орон, хугацаа, шалтгаан ба бололцоо зэрэг ойлголтуудын агуулгыг тодруулан ашигладаг. Онтологийн үндсэн судлагдахуун нь оршин буй юм, бодит байдлын бүх хэлбэр (бодит, объектив, физик гэх мэт болон субъектив, нийгмийн ба виртуаль зэрэг)-ийн иж бүрдэл ба нэгдэл гэж тодорхойлогддог ахуй мөн. Философийн “ахуй” хэмээх ойлголт нь суурь онтологийн арай явцуу утгаар байгаа юмны оршихуйн талыг түүний өөрийнх нь мөн чанараас ялган гаргаж үзэх авай. Үүнээс ургуулан үзвэл, “Байж байгаа юм гэж юу юм бэ?” гэдэг асуултаар тухайн юмны мөн чанар тодорхойлогддог аваас харин “Юм байж байна гэдэг юу юм бэ?” хэмээх асуулт ахуйг тодорхойлж өгөх учиртай.

Мэдээллийн нийгэмд интернэтийг бүтээн ашиглах болсон нь онтологийг ергөтгөн танин мэдэхүйн энгийн хувьсгалаас илүү өргөн утга агуулгыг бий болгож, онтологийн бус асуудлыг онтологид оруулан судлах шинэ боломж нээж байгааг онолын хувьд үндэслэв.

**Онтологийн “эргэлт” (ontological “turn”).** Оршихуйн үндэс нь бодис, эсвэл санаа байх ёстой гэж үздэг өрнөдийн монист философийн онтологи мухардалд орж, түүнээсээ гарахын тулд хэд хэдэн удаа онолын эргэлт, хувьсгал хийж байсан билээ.

**Нэг.** Эхлээд Кант танин мэдэхүй бол өөрийн өвөрмөц хуулиар явагддаг үйл явц гэж үзээд танин мэдэхүйн арга барил ба мэдлэгийг бүтээдэг зүйлийг тодорхойлдог гол хүчин зүйл нь танин мэдэгдэж буй субстанцын шинж чанар, бүтэц биш, харин танин мэдэгч субъектийн өвөрмөц чанар мөн гэснээрээ ийм эргэлт хийсэн. Кантынхаар, онолын философийн судлагдахуун нь байгаль, ертөнц, хүмүүн зэрэг алив юмсыг өөрийг нь судлах биш, харин танин мэдэх үйл ажиллагааг шинжлэх, хүний оюун ухааны хууль ба зааг хязгаарыг тогтоох явдал ажээ. Чухам энэ утгаар Кант өөрийн философийг трансценденталь гэж, арга зүйгээ шүүмжлэлт хэмээн нэрлэж байсан.

Туршлагын чинад буюу трансценденталь философи нь туршлага гэж юу болох, туршлагын өмнөх мэдлэг ба гэр хоёрын харьцааны асуудал, туршлагатай хамсаагүй бодол эргэцүүлэлд анхнаасаа байсан, туршлагыг нөхцөлдүүлж өгдөг зүйлүүдийн ерөнхий зүй тогтлыг судалдаг. Тийм зүйлүүд нь Кантынхаар Орон, хугацаа, шалтгаант чанар, зайлшгүй байдал болон бусад категориуд байх ажээ.

## КОВИД-19 ЦАР ТАХАЛ БА БИОФИЛОСОФИЙН ӨӨРЧЛӨЛТ

**Ш.Ганхуяг**

*Доктор (Ph.D), дэд профессор  
ШУА-ийн Философийн хүрээлэн*

**Б.Очирхуяг**

*Доктор (Ph.D), дэд профессор  
МУИС-ийн ШУС-ийн Биологийн тэнхим*

Сүүлийн жилүүдэд аж үйлдвэрийн IV хувьсгалын (Аж үйлдвэр IV) нөлөөгөөр дэлхий дахинд гарч байгаа өөрчлөлтийн талаар өргөнөөр хэлэлцэх боллоо. 2010 оны үеэс дэлхийн эдийн засгийн хөгжингүй орнууд ба дэлхийн тэргүүлэх корпорацууд өөрийн хөгжлийн стратеги төлөвлөгөөгөө шинэчлэн боловсруулах шаварлагатай болсон бөгөөд түүнийгээ хэрэгжүүлж эхэллээ. Тухайлбал:

- АНУ 2011 онд ‘Advanced Manufacturing Partnership’ (AMP) дараагийн эрийн үеийн аж үйлдвэрийн хөтөлбөр,
- ХБНГУ 2012 онд ‘High-Tech Strategy 2020’ сүүлийн үеийн технологийг хөгжүүлэх,
- Франц улс 2013 онд ‘La Nouvelle France Industrielle’ аж үйлдвэрийн хөгжлийн чиглэлийг тодорхойлсон бодлогын баримт бичиг,
- Англи улс 2013 онд ‘Future of Manufacturing’ 2050. Удаан хугацааны Аж үйлдвэрийн тогтвортой хөгжлийн бодлогын баримт бичиг,
- Өмнөд Солонгос улс 2014 ‘Innovation in Manufacturing 3.0’ аж үйлдвэрийн шинэ үсрэлтийн стратегийг дэмжих,
- Хятад улс 2015 онд ‘Made in China 2025’ Аж үйлдвэрийн 10 салбарт тоон тогтолцоог шуурхай нэвтрүүлэх баримт бичиг,
- Япон улс 2015 онд ‘5th Science and Technology Basic Plan’ дэлхийд тэргүүлэх аж үйлдвэрийг бий болгох хөтөлбөр, Уг хөгжлийн хөтөлбөрт нийгмийн хөгжлийн 5-р үе ирж байгааг тодорхойлоод тоон тогтолцоотой хүн төвтэй ‘Super Smart Society’-г хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулсан (1, 2).

НҮБ-аас 2015 онд “UNESCO science report. Towards 2030” Дэлхийн шинжлэх ухааны хөгжлийн чиг хандлагыг Дэлхийн нийтийн интернетийн сүлжээ 2.0 (WEB 2.0) болон нээлттэй шинжлэх ухааны 2.0 үе шат (Science 2.0) хамттай хөгжиж өгөгдлийн хувьсал руу хүргэж шинжлэх ухааны орчийн үеийн арга зүй хөгжинө гэж тодорхойлж байна.



**Ц.Батбаяр**

Цахим орчин дахь хүүхэд, залуусын эсрэг гэмт явдал,  
түүнд хийсэн шинжилгээ .....85

**Б.Дэлгэрмаа, Д.Ариунжаргал**

Монголын нийгэм дэх цахим орчны судалгаа.....91

**Ж.Бямбасүрэн**

Цахим орчны нөлөөнд өртсөн монгол ахуй. ....103

**Б.Өнөрболд**

ЕБС-ийн ахлах ангийн сурагчдын эрүүл мэнд,  
хөгжилд компьютер тоглоомын үзүүлж буй нөлөө .....108

**Ж.Хулан**

Вирус хүн төрөлхтний амьдралд хэрхэн нөлөөлж болох вэ? .....122

**Д.Чулуунгэрэл**

Мэдээлэл технологийн орчин үеийн чиг хандлага ..... 127

**А.Энхцэцэг**

Хиймэл оюун ухаан ба философи .....131

**Б.Цэрмаа, Ц.Эрдэнэбат**

Монгол хүний ёс суртахууны өөрчлөлт ба цахим орчин .....140

Философи: үйл явдал, бүтээл - 2020 .....147

## ЦАХИМ ОРЧНЫ НӨЛӨӨНД ӨРТСӨН МОНГОЛ АХУЙ

Ж.Бямбасүрэн

Магистр

ШУА-ийн Философийн хүрээлэн

**Хураангуй:** Даяаршлын нөлөөгөөр монголчууд суурин соёлд хурдацтай шилжих болсон нь нүүдэлчдийн уламжлалт соёлын залгамж холбоо алдагдахад хурч улмаар гадны юм бүхнийг шүтэн биширч, даган дуурайх боллоо. Үүнд цахим орчин ихээхэн нөлөөлж байгаа юм. Энэ байдал даамжирсаар төрөлх хэл, соёл, зан заншил, аж төрөх ёсоо үгүйсгэх дүр зураг ч ажиглагдаж байна. Гадны юм бүхэн гоё, сайхан, үнэтэй, бахдалтай. Харин дотоодын “уламжлалт” тодотголтой юм бүхэн үеэ өнгөрөөсөн, бүдүүлэг, хөдөөний болчихно. Ингээж өнгөрсөн түүх, уламжлалт соёлоо үгүйсгэж тэр ч байтугай мэдэхгүй өсөж байгаа хүүхдүүд улс орныхоо соёлын дархлааг, үндэсний аюулгүй байдлаа хэрхэн, яаж хамгаалах вэ? Иймээс хүүхэд, залууст улсынхаа түүхийг үнэн зөвөөр танин мэдүүлж, өв соёлоороо бахархах, хүндэтгэн биширүүлэх сэтгэлийг төрүүлж, цаашид түүх, ёс заншлаа өвлүүлэхэд чиглэсэн ажлыг бодлогын түвшинд дэмжин ажиллаж, хэрэгжүүлэх нэн шаардлагатай байна. Иймийн тулд сүүлийн 15 жилийн хугацаанд хүмүүсийн амьдралд нэвчиж буй цахим сүлжээг ашиглан, үүсээд буй соёлын зарим гажуудлыг арилгах, үндэсний түүх, соёлоо танин мэдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг түгээмэл явуулах нь зүйтэй байна.

**Түлхүүр үг:** даяаршил, мэдээлэл, цахим сүлжээ, соёл


Илтгэлээ эхлэхийн өмнө даяаршил гэж юу вэ? даяаршил бидний амьдралд хэрхэн нөлөөлж байна вэ? гэсэн асуултуудыг тунгаан үзэх нь зүйтэй гэж бодлоо.

Даяаршил гэдэг нь (globalization) дэлхийн улс орнууд эдийн засаг, санхүү, улс төр, хэл, соёл, техник технологи, цэргийн салбарын хүрээнд нэгдэн нягтрах үйл явц гэсэн тодорхойлолтыг нэгэн илтгэлээс олж харлаа. Мөн Петерсоны олон улсын эдийн засгийн хүрээлэнгийн тодорхойлолтоор даяаршил гэдэг бол бараа, үйлчилгээний хил дамнасан худалдаа, технологи, хөрөнгө оруулалт, хүмүүс, мэдээллийн урсгал зэргээс үүдэлтэй дэлхийн эдийн засаг, соёл, хүн амын өсөн нэмэгдэж буй харилцан хамаарлыг тодорхойлоход хэрэглэгддэг үг юм гэсэн олон янзын тайлбар, тодорхойлолт байна.

Эрдэмтдийн үзэж байгаагаар даяаршлын үйл явцыг дараах хэдэн үед ангилж үзсэн байна. Үүнд:

- Эртний ромын эзэнт гүрэн (МЭ I-III зуун)
- Исламын алтан үе (VI-VIII зуун)
- Монголын эзэнт гүрэн (XIII зуун)
- Европын колоничлол, худалдааны эрин үе (XVI-XVII зуун)
- XVII зуунаас дэлхийн I дайны үе хүртэл
- XX зуунаас одоог хүртэл.

Олон нийтийн  
**ДИСКУРС**  
ДЭХ ФИЛОСОФИЙН ҮҮРЭГ



**World Philosophy Day-2021**

ГАРЧИГ

<b>ӨМНӨХ ҮГ</b> .....	5
<b>МОНГОЛЫН ФИЛОСОФИЙН ХОЛБООНЫ МЭНДЧИЛГЭЭ</b> .....	6
<b>Ц.Гомбосүрэн</b> Мишель Фукогийн боловсруулсан дискурсив (уялдмал эргэцүүллийн) арга зүйн зарим гол бүрэлдэхүүн .....	8
<b>Б.Дагзмаа, Ц.Нямсүрэн</b> Философи өнөө юу хийх вэ?.....	14
<b>Ч.Ган-Өлзий</b> “Аргасун хуурчийн домог” шастирт философийн эргэцүүлэл (philosophical reflections)-ийг олны хэлэлцүүлэг (discursus) болгох аргыг хэрэглэсэн нь .....	18
<b>Ч.Өлзийсайхан</b> Сонгодог философи, орчин үеийн Монголын улс төрийн философийн нийцэл, зөрчлийн асуудалд .....	24
<b>М.Мөнхзул, Г.Уянга</b> Үндэсний өөрийн ухамсрыг судлахад философи арга зүйн ач холбогдол .....	33
<b>О.Хатанболд, А.Хишигдаваа</b> Өнөөгийн монголчуудын үндэсний үзлийн талаарх дискурс шинжилгээ .....	38
<b>С.Соёлмаа</b> Соёмбо үсгийн тухай философийн дискурсэд .....	52
<b>М.Батзориг</b> Дүрслэхүйн дискурс ба дүрслэлээс тагталзсан тэрслүү санаанууд .....	61
<b>М.Золзаяа</b> Нийгмийн тэгш бус байдлыг дискурсив ёс зүйн үүднээс авч үзэх нь.....	68
<b>Ж.Энхбаяр</b> Үзэл суртал ба улс төрийн дискурс .....	74
<b>Л.Долгор, Г.Уянга</b> Олон нийтийн дискурсийн онцлог, зарим туршлага .....	81

**“АРГАСУН ХУУРЧИЙН ДОМОГ” ШАСТИРТ ФИЛОСОФИЙН  
ЭРГЭЦҮҮЛЭЛ (PHILOSOPHICAL REFLECTIONS)-ИЙГ ОЛНЫ  
ХЭЛЭЛЦҮҮЛЭГ (DISCURSUS) БОЛГОХ АРГЫГ ХЭРЭГЛЭСЭН НЬ**

**Батын Ч.Ган-Өлзий**

*Доктор (Sc.D), профессор  
ШУА-ийн Философийн хүрээлэн*

Монголын ард түмэн нэн эрт үеэс өөрийн оюун санааны илрэл болсон аман зохиолоороо, хожим XIII зууны үеэс сонгодог бичгийн хэлээрээ дамжуулан өөрийн философийг бүтээж, философидох хүмүүнлэгийн ухааны олон аргууд, түүний дотор хэлэлцүүлгийн аргыг хэрэглэж ирсэн билээ. Монгол философи нийт дорнын философийн нэгэн адил тухайн үндэстний урлаг, түүний дотроос шүлэг яруу найрагтай хамт ээцлэх ухаан болон боловсорч, нэн ялангуяа бичгийн хэл үүссэн цагаас эхлэн тайлбарлах философийн хэлбэрт шилжин хөгжсөн байна. Үүнийг гэрчлэх монголын худам бичиг сонгодог хэлбэрээ олж байсан XIII зууны эхэн үеэс бидэнд уламжлагдан ирсэн философи, яруу найргийн цөөхөн дурсгалын нэг нь “Аргасун хуурчийн домог” хэмээх шастир билээ. Энэ шастир Чингис хаан сартуул иргэнийг дайлан эзэлсэн үе буюу 1222 онд бүтээгдсэн гэж үздэг. “Аргасун хуурчийн домог” хэмээх энэ найраглалд сэцэн найрагч, хөгжимчин Аргасун хуурч ба Чингис хаан, түүний хүүхдүүдийн харилцан яриа (dialogus), хэлэлцүүлэг (discursus)-ийг шүлэглэсэн хэлбэрээр илэрхийлжээ. Манай хүмүүнлэг соёл, сонгодог бичгийн хэлний энэ артефактаас яруу найраг ба ээцлэх ухаан болох философийн нэгдмэл тогтолцоог бүрнээ харж болохын дээр оюун билгийн бүтээлийн гүн увдисын арга зүйн олон асуудлыг мэдэж болох амой.

Философийн эргэцүүлүүд (philosophical reflections)-ийг олны хэлэлцүүлэг болгодог монолог, диалоги ба дискурсийн уламжлалыг гарган үзүүлэхээр бид хамаг Монгол улс нэгдэж, хүмүүнлэг соёлын үндэс бичгийн хэлтэй болсны дараа сартуулыг дайлан эзэлсэн цаг буюу Чингис хааны амьд сэрүүн байх үеийн шүлэглэсэн найраглалын цөөн дурсгалын нэг гэж олонх эрдэмтэд санал нэгтэй үздэг “Аргасун хуурчийн домог” хэмээх шастирыг сонгон авлаа.

“Хатан хөвүүд чинь мэнд байнам.

Хамаг улсын чинь зан аашийг эс мэдэв.

Эм хөвүүд чинь мэнд байнам.

Энэ их улсын чинь зан аашийг эс мэдэв.

Хагархай амандаа холтос хальс олж идэв.

Хамаг улсын чинь зан аашийг эс мэдэв.

Умдаасах амандаа ус цас олж уув.

Улс монголын чинь зан аашийг эс мэдэв...”<sup>1</sup>

хэмээн эхэлдэг энэ шастирт Чингис хаан өөрийн мэргэн түшмэд, хатад, хөвгүүд ба “аргасан хуурч”-тай ярилцсан жирийн ярианы тухай биш, харин харилцан ярилцсан (dialogue) тухай өгүүлж буй нь илт. Сократаас эхтэй харилцан ярианы

<sup>1</sup> Дамдинсүрэн Ц. Монголын уран зохиолын түүх. УБ., 1957, Цэрэнсодном Д. Монгол уран зохиол. УБ., 1987 номуудаас харьцуулан авав.

## СОЁМБО ҮСГИЙН ТУХАЙ ФИЛОСОФИЙН ДИСКУРСЭД

Цэдэвийнхэн С.Соёлмаа

Доктор (Ph.D)

ШУА-ийн Философийн хүрээлэн

## Abstract

*In this report, we argue that the totem worship of the ancient Mongols is usually of earthly, worldly nature (deer, wolf, horse, etc.), while the main heroes of other peoples' myths, such as ancient China, are celestial and underground animals (birds or fish, snakes, etc.). Therefore, it is necessary to reconsider the scientific and philosophical basis of whether the two rotating fishes, which are located in the middle of the "Soyombo" symbol on the state emblem and flag of modern Mongolia, are real traditional idols and emblems of Mongolians. For this reason we saw scientific books, articles and reports about "Soyombo" symbol and found that their confirmation about that fish symbolizing the prosper for the Mongolians is false. And there are also religious interpretations about the Soyombo symbol. They consider that two fishes indicate Buddhist view point about "Arga and Bileg". But in our opinion fish is the symbol of Ancient Chinese mythology. By the Chinese mythology, two rotating fishes from the Fu Hsi and Nyu-Va, which were idols for the ancient Chinese tribe, are the Chinese idol. Then, they two were merged in one symbol of the women and man. Meanwhile, fish for the Mongolians from the ancient state Xiongnu and the Great Imperia of Genghis Khan is the symbol of weakness, destruction and lie. In the conclusion, we came to the idea that the state emblem of Mongolia could be replaced by a deer on a deer stone statue, instead of two rotating fishes, and a wolf on the other hand in the Mongolian Secret History. Perhaps the time will come for artists and thinkers to ponder with their wisdom and intuition that a deer and a wolf can be the perfect symbols for the Mongolia.*

Ю.Хабермас нь “Ёс суртахууны ухамсар ба харилцааны үйлдэл” хэмээх номондоо философийн үндэслэгээ ямар байх тухай санааг дэвшүүлсэн. Тэрээр философич Рортигоос санаа авч “Философи бол оюун ухааныг хадгалагч гэдэг зорилгоосоо салах ёстой”<sup>1</sup> гэсэн байна. “Сайн” гэсэн үнэлгээнээс зөвхөн “шударга” л үлдсэн бөгөөд философи нь сайн муугийн үнэмлэхүй шүүгчийн бус, харин “зуучлагч” гэсэн үүргээ хадгалах нь зүйтэй<sup>2</sup> гэдэг санааг дэвшүүлсэн байна. Мөн Хабермас нь Рортигоос ишлэхдээ “Философийн сонирхол бол арай өргөн хүрээг хамарсан зөвтгөлийг манай нийгмийн амьдралын практикт байгаа зүйлсээс олж харахад оршдог”<sup>3</sup> гэсэн байна. Өөрөөр хэлбэл, орчин үеийн философи нь нийгмийн амьдралд тогтсон аливаа хэв маяг, үзэл, ойлголтоос татгалзаж, хуучин утгыг шинэ болгож тайлбарладаг зуучлагчийн үүргийг гүйцэтгэх нь зөв тухай санааг Хабермас дэвшүүлжээ. Аливаа философийн

<sup>1</sup> Хабермас Ю. Моральное сознание и коммуникативное действие. Пер. с нем. Д.В.Скляднева. Санкт-Петербург. Наука. 2001. с.10.

<sup>2</sup> Мөн тэнд. 32 дахь тал.

<sup>3</sup> Мөн тэнд. 33 дахь тал.

## ҮЗЭЛ СУРТАЛ БА УЛС ТӨРИЙН ДИСКУРС

**Ж.Энхбаяр**

*Доктор (Ph.D)*

*ШУА-ийн Философийн Хүрээлэн*

2021 онд монголын тулгар төр Хүннү гүрэн байгуулагдсаны 2230, Их Монгол улс байгуулагдсаны 815, үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 110, ардын хувьсгалын 100 жилийн түүхэн тэмдэглэлт ойнууд тохиож байна. Эдгээр ой бол нүүдэлчдийн байгуулсан Улс, бүтээсэн Төрийн түүх, нүүдлийн соёл, үнэт зүйлсийн илэрхийлэл, эдүгээгийн Монгол Улс, үндэстний эв нэгдлийн нэгэн бэлэг тэмдэг юм. Төв Азийн өндөрлөг газар, тал нутгаар тархан суурьшиж байсан нүүдэлчин түмэн Гүрэн улсаа байгуулж, газар нутгаа тэлэн мандан бадарч, агшиж мөхөж, ээлж дараалан шинэ улс, үндэстэн бүрэлдэн хөгжиж ирсний түүх юм. Эртнээс эдүгээ хүртэлх нүүдэлчдийн туулсан зам, мандуулсан төр улс, нийгмийн түүхэн хөгжлийг илтгэх гол хэсэг бол Монгол Улс, Монгол үндэстэн бөгөөд энэхүү төр ёсны уламжлалыг нандигнан дээдэлж, бахархан тэмдэглэх нь зүйн хэрэг билээ.

Түүнчлэн Монголд улс төрийн нам үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойг тухайн нам, гишүүд, дэмжигчдийн хүрээнд өргөн дэлгэр тэмдэглэж байгаа нь дээр дурдсан төр, улсын түүхэн ойнуудаас дутахгүй нийгэм - улс төрийн ач холбогдолтой үйл явдал болно. Хүмүүсийн үүсгэл санаачилгаар улс төрийн нам бий болох, нэгдэж нягтрахын үндэс болсон үзэл суртлын тухайд өргөн хүрээнд, тэгэхдээ шүүмжлэлт дискурс анализ хийх эрдэм шинжилгээ, судалгааны томоохон сэдэв, сэдэл болж байгаа юм. Өнгөрсөн зуун жилийн ихэнх хугацаанд зөвлөлтийн марксизм монголын төр, улс төрийн ууган намын онолын үндэс, нийгмийг нэгтгэдэг зонхилох үзэл суртал байж, цаашилбал монголд улс төрийн философи, улс төрийн шинжлэх ухааны хөгжлийн үндсийг тавьсан юм. 1921 оны ардын хувьсгалын дараахан анхдугаар Үндсэн Хуулиа баталж, Бүгд Найрамдах засаглалын хэлбэрт шилжиж, 1990 оныг хүртэл марксизмын онолын үндсэн дээр монголын нийгэмд социализм байгуулах үйл хэрэг өрнөжээ. Улмаар 1990 оны ардчилсан хувьсгалаар үндсэн хуулиа дахин шинэчлэн баталж, нийгэм, эдийн засгийн байгууллага үндсээр нь өөрчилж ирсэн түүхийг үзвээс орчин үеийн улс төрийн онол номоор улс орноо засаглаад зуугаадхан жил болжээ. Эдгээр ой, тэмдэглэлт үйл явдлууд бол хэмжээгүй эрхт хаант засаглалаас ард түмний мэдэлд засгийн эрх шилжсэн болон олон намын тогтолцоо бүхий ардчилсан засаглалыг сонгож авсан зэрэг монголын нийгэм, улс төрийн сэтгэлгээний хөгжил, төлөвшлийн түүхийг илтгэн харуулж байдаг.

Сүүлийн гучаад жилд улс төрийн олон төрлийн үзэл баримтлал дэлгэрч, түүгээрээ ялгарч эвлэлдэн нэгдсэн улс төрийн намууд, нийгмийн бүлэг хөдөлгөөнүүд үүсэн бүрэлдэв. Нэг үзэл суртал тойрон нийгмээрээ нэгдэн нягтарч байсан бол одоо нийгэм, улс төр, оюун санааны төлөв байдал үндсээрээ өөрчлөгдөж, иргэдийн үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, итгэл үнэмшлээрээ улс төрийн намд элсэх, сонгох, сонгогдох эрх чөлөө бүхий улс төрийн плюралист



# ХҮҮХДИЙН ХӨГЖИЛ, ТӨЛӨВШИЛ **2021**

УЛААНБААТАР 2021



<b>Таван настай хүүхдийн бие даах чадварыг гэр бүлд түшиглэн зайны сургалтаар дэмжлэг үзүүлэх нь.....</b>	<b>95</b>
<i>Г.Монхцэцэг</i>	
<b>Сурагчдын үндэсний бичиг хичээлд хандах хандлагыг судалсан үр дүн.....</b>	<b>105</b>
<i>А.Хоёрмөнхцаст-Алтай</i>	
<b>Дорнод аймгийн хүүхэд хамгааллын нөхцөл байдалд хийсэн шинжилгээний зарим үр дүн.....</b>	<b>109</b>
<i>Б.Оюун-Эрдэнэ</i>	
<b>Хүүхдийн хөгжил, төлөвшилд гэрийн хүмүүжил хэрхэн нөлөөлөх тухай асуудал.....</b>	<b>118</b>
<i>Ж.Бямбасүрэн</i>	
<b>Ирээдүйн багшийн бичих чадварын судалгааны зарим үр дүнгээс.....</b>	<b>124</b>
<i>Х.Жүгдэрнамжил</i>	
<b>Ахлах ангийн сурагчдын зан төлөвийг судалсан үр дүн.....</b>	<b>130</b>
<i>Ч.Анударь</i>	
<b>Хүүхэд, өсвөр үеийнхэнд үзүүлэх урлагийн боловсролын нөлөөлөл.....</b>	<b>137</b>
<i>Д.Төрсайхан</i>	


## Хүүхдийн хөгжил, төлөвшилд гэрийн хүмүүжил хэрхэн нөлөөлөх тухай асуудал

Ж.Бямбасүрэн /магистр/  
ШУА-ийн Философийн хүрээлэн, ЭША

**Abstract:** Social development is directly related to civic education, ethic and upbringing. Because depending on how one is brought up in the family environment, individual upbringing is reflected in social communication. In other words, knowledge, experience, morality acquired in the family are the primary ground for a person's social communication. While we often criticize the causes of the positive and negative phenomena in our society in relation to the state, law or someone in power, we don't understand the reasons behind the responsibilities, kindness and values of the family members. Therefore, in this speech, I want to express my position on the influence of family morality in the society and peculiarities of family upbringing of modern Mongolians based on some study.

**Түлхүүр үг:** үнэт зүйл, ёс суртахуун, гэрийн хүмүүжил

Монголчуудын ёс заншилд гэрийн хүмүүжлийн үүрэг, ач холбогдол чухал байр суурь эзэлдэг төдийгүй энэ нь ардын сурган хүмүүжүүлэх арга ухаан болон хөгжсөөр өнөөдрийг хүрсэн билээ. Уламжлалт сурган хүмүүжүүлэх арга ухаан нь хүүхдийг ажил амьдралын гярхай ухаанд сургаж, төрөө дээдлэх, ахмадыг хүндлэх, хүнлэг, нинжин сэтгэлд дадуулах, эр зориг, хатуужил гэвчээрт сургахын зэрэгцээ ажил хөдөлмөрийн үр шимийн амтыг мэдрүүлэх зэрэг үндсэн зорилготой. Гэрийн хүмүүжлийн өвөрмөц онцлог, арга хэлбэрүүд нь түүхийн урт замыг туулахдаа тухайн цаг үеийнхээ онцлогийг шингээн өөрчлөгдөн хөгжиж ирсэн ч эрдэм ном, шударга ёс, эр зориг, нинжин сэтгэл, ажил хөдөлмөр, арвигч хямгач занг ямагт эрхэмлэн дээдэлж үр хүүхэддээ зааж сургаж байсан нь түүхнээ тодхон. Харин орчин үед гэрийн хүмүүжлийн арга, хэлбэрүүд шинэчлэгдэж шинэ хэв шинжийг бий болгон хөгжиж байна. Ийм шинэчлэл нь нийгмийн хэрэгцээ шаардлагаас урган гарсан төдийгүй амьдралын хэв маяг, ажил үүргийн онцлог, олон соёлын нөлөөллөөс шууд хамааралтай. Энэхүү илтгэлдээ монголчуудын гэрийн хүмүүжлийн уламжлалт онцлогийг дурдахаас илүүтэй орчин цагийн монголчуудын хүүхэд хүмүүжүүлэх арга хэлбэрийн давуу болон сул талыг ажиглан зарим судалгааны дүн мэдээнд тулгуурлан тайлбар хийхийг зорилоо.



Хүснэгт 1. 2019 оны төрөлтийн коэффициент<sup>1\*</sup>

<sup>1\*</sup> Статистикийн мэдээллийн нэгдсэн санг.  
[https://www.1212.mn/tables.aspx?TBL\\_ID=DT\\_NS0\\_0300\\_029V1](https://www.1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NS0_0300_029V1)